



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

ЗӨРЧЛИЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

ХII БОТЬ

(2021 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2022 он

ДАА 340
ННА 67
Н-615

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛСЫН ХАРАА

Олон улсын жишигт нийцсэн эрдэм, шинжилгээ,
сургалт мэдээллийн үндэсний хүрээлэн болон хөгжинө.

© Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хянан тохиолдуулсан : Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Эмхэтгэсэн: Хууль зүйн судалгааны төв

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Эх бэлтгэгч, дизайнер Б.Заяа
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Хэвлэсэн хугацаа: 2022 он.

ISBN 978-9919-9964-5-1

ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт уншигч та бүхний түмэн амгаланг айлтган мэндчилье.

Хууль зүйн үндэсний хүрээлэн 2021 онд гүйцэтгэсэн судалгаануудаа “Хувийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть)”, “Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл X боть)”, “Нийтийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XI боть)”, “Зөрчлийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XII боть)” хэмээх

дөрвөн ботиор уншигч олноо толилуулж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 49.3-т “Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” хэмээн заасанчлан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/195 тоот албан үүргийн дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт тус тус хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж байна.

2021 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө батлагдсан бөгөөд тус төлөвлөгөөнд эрх зүйн салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэ хүрээнд зөрчлийн эрх зүйд холбогдох судалгааг багтаасан энэхүү судалгааны тайлангийн XII ботийг эмхэтгэлээ.

Уг эмхэтгэлд өмнө нь төдийлөн судлагдаагүй Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тодорхой асуудлыг хөндөн судалсан. Тухайлбал, зөрчил шалган шийдвэрлэх шүүхийн харьяаллын талаар судалж шүүхийн практикт үүсэж буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлон харьяалан шийдвэрлэх шүүхийн давхардлыг арилгах тухайд саналыг дэвшүүлсэн ба зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавих прокурорын чиг үүргийн эрх зүйн асуудал болоод түүний практик дахь хэрэгжилтийн байдлыг дүгнэсэн. Түүнчлэн тодорхой төрлийн зөрчлийн хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг судалсан бөгөөд тус ботид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн эрх зүйн зохицуулалтыг манай улсын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоотой холбон хэрэгжилтийн байдлыг үнэлж, цаашид эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах нь зүйтэй хэмээн үзсэн. Мөн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах сануулах болон торгох шийтгэлийн эрх зүйн зохицуулалтыг гадаад орнуудтай харьцуулан судалж өөрийн улсын холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тодорхой саналыг дэвшүүлсэн болно.

Энэхүү ботид эмхэтгэгдсэн судалгаа нь Монгол Улсын зөрчлийн эрх зүйн салбарт тулгамдаж буй олон асуудлыг шинжлэх ухааны үүднээс шийдвэрлэгдэхэд зохих ёсоор хувь нэмэр оруулна гэдэгт бид бүхэн гүнээ итгэж байна.

ЗАХИРАЛ  Х.ЭРДЭМ-УНДРАХ

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	I
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	IV
НЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ СУДЛАХ НЬ.....	1
ХОЁР. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ХАРЬАЛАЛ	39
ГУРАВ. ЗӨРЧИЛ ҮЙЛДЭГЧИД ОНОГДУУЛАХ САНУУЛАХ БОЛОН ТОРГОХ ШИЙТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	81
ДӨРӨВ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ПРОКУРОРЫН ОРОЛЦОО	105

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АИХ	Ардын Их Хурал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АМХГ	Аймгийн мэргэжлийн хяналтын газар
БНИУ	Бүгд Найрамдах Итали Улс
БНПУ	Бүгд Найрамдах Перу Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
БНПУ	Бүгд Найрамдах Перу Улс
БНКУ	Бүгд Найрамдах Казакстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОГУУХ	Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналт
ГБХТ-Х	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГҮТББ	Гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага
ДТХ	Дампуурлын тухай хууль
ЕАБХАБ	Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага
ЕХ	Европын холбоо
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗХШХШТХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХДЗШШ	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
ЗЕХ	Захиргааны хэргийн хууль
ЗХАШШ	Захиргааны хэргийн анхан шатны шүүх
ЗХШ	Захиргааны хэргийн шүүх
ЗШША	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа
ЗШШТХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХАШШ	Иргэний хэргийн анхан шатны шүүх
ИХ	Иргэний хууль
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
КТХ	Компанийн тухай хууль
МСӨХДЗ	Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл
МУ	Монгол Улс
МУЕ-Х	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль

МУИХтХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
ННФ	Нээлттэй нийгэм форум
НДЗХАШШ	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх
НШГА	Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба
НЭЗЭ	Нийтийн эрх зүйн этгээд
ОХУ	Оросын Холбооны Улс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СӨХЭЗБНЗОСБДӨЭХтХ	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
СнЗ	Сайд нарын зөвлөл
ТАтХ	Төрийн албаны тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗ	Төрийн захиргаа
ТТ	Төрийн тусгай
ТХШтХ	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын их хурал
УТХТХ	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
УША	Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа
ҮЦБ	Үнэт цаасны байгууллага
ҮЦЗЗТХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ХАБҮЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХШЗ	Хянан шалгагчдын зөвлөл
ХШ	Хянан шалгагч

ХЭУБ	Хуулийн этгээдийн улсын бүртгэл
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХШ	Эрүүгийн хэргийн шүүх
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭИХХЦХ	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналт
PC	Private company
LLC	Limited liability company
SARL	Société à Responsabilité Limitée
SRL	Società a responsabilità limitata
GmbH	Gesellschaft Mit Beschränkter Haftung
LS	Limited Sirket

НЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ СУДЛАХ НЬ

Судалгааг удирдсан:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D) С.Сүхбаатар
Эрдэм шинжилгээний
ахлах ажилтан С.Соёл-Эрдэнэ
Эрдэм шинжилгээний ажилтан Т.Намуун
Эрдэм шинжилгээний ажилтан А.Намуунаа

УДИРТГАЛ

Гэр бүлийн харилцаа нь нийгмийн бусад төрлийн харилцаанаас хамгийн төвөгтэй, өвөрмөц харилцаа бөгөөд дан ганц хууль эрх зүйн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй байдаг. Монгол улсад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (цаашид “ГБХТТХууль” гэж товчилно) нь анх 2004 онд батлагдсан ба шинэчилсэн найруулга нь 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч түүний гэр бүл, бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршдог¹. Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт хуульчилсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн зөрчил нь Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад бий болсон харьцангуй шинэ төрлийн зөрчлийн хэрэг тул эрх зүйн зохицуулалт болон түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлага тулгарч буй юм.

1.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван зургадугаар зүйлд “иргэн” эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй.”, “Гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх, үүний дотор хохирогчийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох заалт тусгагдсан.

Түүнчлэн Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хүүхэд хамгааллын тухай, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль, бусад холбогдох дүрэм журмын хүрээнд зохицуулсан. Иймд ГБХ-ийн зөрчлийн талаарх зохицуулалтууд нь хууль эрх зүйн хүрээнд хангалттай хэрэгжиж, асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаж байгаа эсэхийг судлан дүгнэхээр энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Практик шаардлага

Анх 2004 онд Монгол Улсын Их Хурлаас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” бие даасан хуулийг баталснаар гэр бүлийн хүчирхийллийг хүний эрхийн

1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, 1 дүгээр зүйл.

зөрчилд тооцдог болсон ба 2016 онд тус хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заавар, журмуудыг ХЗЯ, ЭМЯ, НХХЯ-аас батлан хэрэгжүүлж, хохирогчдыг хамгаалан байрлуулах, утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэшсэн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан үйлчилгээ үзүүлэх зэрэг ахицтай алхмууд өнгөрсөн хугацаанд хийгдсэн.

2019 онд Улсын хэмжээнд нийт 2,175,825 зөрчил шалгасан нь 2018 оны мөн үетэй харьцуулбал 477,647 буюу 28,1 хувиар, 2,168,335 зөрчлийг шийдвэрлэсэн нь мөн үетэй харьцуулбал 481,104 буюу 28,5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 8962 буюу 0,4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил эзэлж байна.²

Цагдаагийн ерөнхий газраас гаргадаг тоон мэдээллүүдээс харахад (График 1-ээс харах) ГБХ үйлдэх зөрчлийн тоон үзүүлэлт 2018 оноос тогтмол өссөөр байгаа нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, эрх бүхий албан тушаалтнуудын хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил үйлдсэн этгээдэд олгож буй шийтгэлийн үр нөлөөтэй байдал, албадан сургалтын чанар, гэрч, хохирогчийн аюулгүй байдал зэрэг асуудалд хуулийн хүрээнд оновчтой, нарийвчлалтай зохицуулалт дутагдаж буйг харуулж байна.

Вард Фарнсвортын Эрх зүйн аналитист номд “Бид зөвхөн зарим зах зээлийг хянах боломжтой бөгөөд энэ ертөнцөд бидний хянах боломжтой зүйлийг сайжруулсан өөрчлөлт нь бидний хянаж чадахгүй байгаа бусад зүйлсийг улам дордуулж болзошгүй юм. Мөн заримдаа муу үр дагавар нь сайнаас давж гардаг”³ гэж бичсэн байдаг. Үүнээс үзвэл Зөрчлийн тухай хуулийн 5.4 дэх хэсгийг зөрчсөн хүмүүсийг шууд баривчилж байгаа нь өөрөө эргээд сөрөг үр дагавартай байгааг онолын хувьд харуулж байна. Тухайн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүнд хариуцлага оногдуулан арга хэмжээ авч байгаа нь гэр бүлийн хүчирхийллийг хянаж түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой боловч, зарим тохиолдолд уг зорилгодоо хүрч чадахгүй байгаан зэрэгцээ хохирогчид эргээд сэтгэл зүйн дарамт, эдийн засгийн дарамтыг үзүүлж байна. Жишээ нь хүчирхийлэгч нь гэр бүлээ санхүүгийн хувьд дэмжин, ар гэрээ авч явдаг хүн бөгөөд түүнийг баривчилсан тохиолдолд уг гэр бүл нь санхүүгийн хувьд хүнд байдалд орох эрсдэлтэй юм. Мөн хохирогч нь дуудлага өгсний улмаас гэр бүлийн хүн нь баривчлагдан гарч ирээд уурлаж, бухимдан дахин хүчирхийлэл үйлдэхвй гэсэн айдас түгшүүрээс болж мэдүүлгээ буцаах тохиолдол практикт цөөнгүй байна. Үүнээс харвал нэг асуудлыг шийдэх гэснээс улбаалан илүү том асуудал гарч ирж байна. Тиймээс уг асуудлыг бүрэн шийдвэрлэхийн тулд авч буй арга хэмжээ, хариуцлагын тогтолцоо дээрээ анхаарч хохирогч, хүчирхийлэгч хоёрын хоёулангийнх нь талаас харж бодитой шийдвэр гаргах хэрэгтэй байна. Ийнхүү ГБХ-тэй тэмцэх эрх зүйн зохицуулалт манай улсад жинхэнэ утгаараа хөгжихөд саад болж буй хүчин зүйл, түүнийг шийдвэрлэх арга зам, зарчмын асуудлыг онол болон практикийн үүднээс нэгтгэн дүгнэж, судлан тодорхойлох шаардлага тулгарч буйгаас үүдэн уг сэдвийг сонгон судаллаа.

2 Цагдаагийн ерөнхий газар, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, УБ, 2020он, 8 дахь тал.

3 Ward Farnsworth, *The Legal Analyst*, University of Chicago press, 2007, page 25.

1.2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн төлөв байдлыг судлах зорилгыг дэвшүүлсэн болно. Судалгааны зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтууд нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэргийн нөхцөл байдлыг судалж, хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлох;
2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид оноож буй баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэлийн үр нөлөөтэй байдлыг үнэлж, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;
3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийг Эрүүгийн хуультай уялдуулан судлах;
4. Гадаадын зарим орны хууль тогтоомжид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн талаар зохицуулсан байдлыг харьцуулан судлах;

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах талаар дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг харгалзан үзэж дараах зүйл, заалтыг сонгон авсан болно. Үүнд:

Хүснэгт 1. Үнэлэх зүйл, заалт

Д/д	Сонгосон зүйл, заалт	Агуулга
1	5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 4.1.зодсон; 4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; 4.3.бусадтай харилцахыг хязгаарласан; 4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд ихээхэн цаг хугацаа, хөдөлмөр, зардал шаардагдана. Иймд хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх тусгайлан сонгож авсан зарим зохицуулалтад үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй.

Зөрчлийн тухай хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлэх 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн зохицуулалтыг өргөн хүрээнд судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

1.4. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотойгоор хийгдсэн судалгааны ажил, ном товхимол, нэг сэдэвт бүтээлүүд харьцангуй олон байдаг.

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-аас 2017 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага”, 2020 онд “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ” мэргэжилтнүүд болон өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвөөс 2019 онд “Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт” мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагыг боловсруулан гаргасан байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс 2014 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт”, 2018 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн албан хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт”, 2019 онд “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт”, 2020 онд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авч буй байдал” зэрэг сэдвүүдээр мониторингийн тайланг гүйцэтгэж, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтууд болон практикт тулгарч буй асуудлуудыг дэвшүүлэн тухай бүр зөвлөмжүүдийг гаргасан хэдий ч дэвшүүлсэн санал, зөвлөмжийн дагуу шийдтэй арга хэмжээ, шинэчлэлтийг хийлгүй өдийг хүрчээ.

“Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төсөлд зориулан гүйцэтгэсэн “Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааны ажиглалт” судалгааны тайланд гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд тулгарч буй асуудлыг өргөн хүрээнд ажиглаж, нарийвчилсан зөвлөмжүүдийг гаргасан ба энэхүү судалгаанд ач холбогдолтой зөвлөмжүүдээс дурдвал хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчид учирсан хохирол, гэм хорыг, нэн ялангуяа ГБХ-ийн хохирогч болсон хүүхэд болон тэднийг хамгаалахад харгалзаж үзэх; ГБХ-ийн хэрэгт маргаан шийдвэрлэх бусад үр дүнтэй аргыг нэвтрүүлэх боломжийг авч үзэх, ГБХ-д хариу үйлдэл үзүүлэх хууль зүйн салбарын оролцогчдын мэргэшлийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай хэмээн үзэж зөвлөмжийн үндэслэлийг ажиглалтын үндсэн дээр дэлгэрэнгүй тайлбарлан бичжээ.

Нээлттэй нийгэм форумын 2021 оны 6 дугаар сард хийсэн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдал орон нутагт” судалгааны ажлыг баримт бичгийн судалгааг бодит нөхцөл байдлын судалгаатай хослуулан хийжээ. Судалгааны үр дүнд орон нутагт уг зөрчил, гэмт хэрэгтэй холбоотой хууль, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй ба гэр бүлийн хүчирхийллийн 70 гаруй хувь нь гэр бүлийн хүрээнд архидаан согтуурсан үед үйлдэгдэж байгаагаас зарим гэмт хэрэг, зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 буюу “бусдын амгалан тайван байдал алдагдуулсан”, 15 дугаар зүйлийн 15.9.1 буюу “худал дуудлага мэдээлэл өгсөн” гэх заалтаар шийдвэрлэж байгааг онцолсон. Мөн Зөрчлийн тухай хуулийн шийтгэл нь хүчирхийлэл үйлдэгчдэд нөлөөлж чадахгүй, үр дүн муутай буюу гэр бүлд нь эргээд сэтгэл санаа, эдийн засгийн дарамт учруулж байгаа бөгөөд эрт шатандаа байх

тохиолдолд хөнгөн шийтгэл оногдуулах зохицуулалтыг нэмж тусгах шаардлагыг дурджээ. Уг судалгааны дүнд прокурорын байгууллагын хяналтыг сайжруулах, зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвхөн хүчирхийлэл үйлдэгч буюу холбогдогчдод хийх бус хохирогч, холбоо хамаарал бүхий гэр бүлийн бусад гишүүнд давхар өгч, сэтгэл зүйд нь нөлөөлөх арга ажиллагааг үр дүнтэй хийж хэвшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж буй ял, шийтгэл түүний гүйцэтгэлийг хэрэгжүүлж буй цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын хандлага, ур чадварыг нэмэгдүүлж, бусад нөөцөөр хангах хэрэгтэй гэсэн зөвлөмж гаргасан.

Нээлттэй нийгэм форум “Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал” судалгааны ажлыг 2021 оны 9 дүгээр сард хийсэн бөгөөд тус судалгааны хүрээнд “ялгаварлан гадуурхах”, “хууль бусаар мөрдөн мөшгөх”, “заналхийлэх”, “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргаар судалгаа гүйцэтгэжээ. Судалгааны дүнд хэсэгт “...эдгээр шинэ төрлийн гэмт хэргийн талаарх Эрүүгийн хуулийн зүйл заалтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт зөв ойлгож, нэг мөр хэрэглэх явдал дутмаг байна. Шинэ төрлийн гэмт хэргийн онцлог, хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зүйл, ялангуяа хохирогчийг хамгаалах тогтолцооны талаарх хууль сахиулагчдын ойлголт, мэдлэг сул байгаагаас хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгох явдал түгээмэл байгааг анхаарч холбогдох сургалт, сурталчилгаа хийх хэрэгцээ, шаардлага тулгамдсан асуудал болжээ.” хэмээн дурджээ. Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд болон Зөрчлийн тухай хуультай уялдуулж оновчтой тодорхойлох, мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчдийн энэ төрлийн гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд нэн шаардлагатай ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах гэсэн зөвлөмжийг гаргасан байна.

Түүнчлэн хуульч, судлаач Г.Оюунболдын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудал”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш Д.Бадам, Хууль зүйн магистр У.Буянтогтох нарын “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал”, Ц.Алтанцэцэг, С.Эрдэнэболор, О.Хишигмөнх нарын “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал” зэрэг судалгаа хийгдсэн. Дээрх судалгааг харьцуулан үзвэл гэр бүлийн хүчирхийллийн зөрчилтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын талаарх хэм хэмжээний хийдэл, практикийн учир дутагдалтай талыг хөндснөөрөө ижил байна.

ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН

2.1 ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1.1 Олон улсын эрх зүйн зохицуулалт

Олон улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр НҮБ-ын 1979 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Олон улсын хүний эрхийн байгууллагууд 1993 онд Вена хотод хуралдаж гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийг хүчирхийлэх бүх хэлбэрийг устгахыг уриалсан Венийн тунхаглал, НҮБ-ын Хүний эрхийн комисс 1994 онд эмэгтэйчүүдийн хүчирхийллийн асуудлаар илтгэх тусгай илтгэгч томилсон шийдвэр, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны зүйл бүхий эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тунхаглал, Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг 1995 оны Бээжингийн тунхаглал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хүчирхийллийн асуудал нь эрүүл мэндийн салбарын тэргүүлэх ач холбогдол өгөх зүйл болохыг онцолсон 1996 оны тогтоол, 1997 оны хүчирхийлэлд өртсөн хүнд тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамж зэрэг эрх зүйн актууд үйлчилж байна.⁴

2.1.2. Монгол Улсын Үндсэн хууль

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван зургадугаар зүйлд иргэн”...аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй”, “Гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус заасан.

2.1.3.Хууль тогтоомж, түүхэн уламжлал

Монгол Улсын Засгийн газраас 1996 онд Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг, 2002 онд Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг тус тус батлан зорилтыг тавьсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд анх удаа УИХ-аас батлан “Гэр бүлийн хүчирхийлэл” хэмээх нэр томьёог албан ёсоор хуульчилсан. Энэ хуульд гэр бүлийн харилцааны хүрээнд гарч байгаа хөнгөн хэлбэрийн хүчирхийллийг тухайн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хууль, ИХШХШТХ-иар шийдвэрлэх, хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах, түүнд эрх хязгаарлах арга хэмжээ авах, зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах зэрэг цоо шинэ хариуцлагын хэлбэрийг НҮБ-ын загвар хуулийн жишгээр, өөрийн орны нөхцөлд тохируулан тогтоосон ба гэр бүлийн хүрээнд гардаг хүндэвтэр, хүнд хэлбэрийн хүчирхийллийг Эрүүгийн хуулиар шийдвэрлэж ирсэн.⁵

4 Гэр бүлийн хүчирхийлэл, www.cccp.mn/гэр-бүлийн-хүчирхийлэл/ (Сүүлд үзсэн:2021.10.22).

5 Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага, УБ, 2017 он, 57 дахь тал.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх, үүний дотор хохирогчийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох заалт тусгагдсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004)

Монгол Улсад 2004 онд Монгол улсын УИХ-аас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг анх баталснаар хуулийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бүрдсэн. Монгол Улсын төр энэ хуулийг баталснаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн⁶ гэж үздэг. 2004 оны ГБХТхуулийн нэг дутагдалтай тал нь гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг хэмээн шууд тодорхойлоогүй, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэхэд хүндрэлтэй байсан тул хөнгөн хэргийг ихэнхдээ архидан согтуурсан эсвэл танхайрсан хэрэг хэмээн бүртгэж байсан бол ноцтой, хүнд хэргүүдийг бусдын эрүүл мэндэд халдсан, бие махбодод гэмтэл учруулсан гэх зэргээр гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг харгалзалгүй бүртгэн зүйлчилж, ихэнх тохиолдолд хохирогч гомдлоо буцаан татсан үндэслэлээр хэрэг хаагдаж байжээ.⁷

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)

2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэлд хамаарах зарчмын томоохон өөрчлөлтийн нэг нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх процессыг тодруулснаас гадна гэр бүлийн хүчирхийллийг иргэний эрх зүйн маргаан бус гэмт хэрэг, зөрчил болохыг хуульчилсан явдал билээ.⁸ Энэхүү хуульд гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагч, асран хамгаалагч, үрчлэн авсан хүүхэд, эцэг эх, салсан хосууд болон хамтрагчид зэргийг хуульд хамруулснаас гадна ГБХ-ийн тодорхойлолтыг илүү өргөжүүлэн, сэтгэл санаа, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрч энэхүү хуульд тусгасан.⁹

6 Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль Монгол улс Хүний эрхийн тайлан, УБ, 2014 он.

7 НҮБ-ын Хүн Амын сан, Монгол Улс дахь жөндөрт суурилсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа, УБ, 2018, 41 дэх тал.

8 Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай цагдаагийн албан хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт, УБ, 2018 он, 7 дахь тал.

9 Монголын Криминологичдын Холбоо, Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь, УБ, 2018 он, 6 дахь тал.

Зөрчлийн тухай хууль

УИХ-аас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэж заажээ.

Эрүүгийн хууль

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.7 дугаар зүйлд “Гэр бүлийн харилцаатай хүнийг байнга зодсон; харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гээд 2 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; таслан зогсоох хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” хэмээн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчилжээ. Түүнчлэн Эрүүгийн хуулийн бусад төрлийн гэмт хэрэгт дараах байдлаар хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчилжээ:

Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь заалт- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг санаатай алах; 11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах; 11.4 дүгээр зүйл 2.1 дэх заалт- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах; 11.6 дугаар зүйл 2 дахь хэсэг- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах; 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх зэрэг байна.

2.1 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1.1 Зөрчлийн хэргийн нөхцөл байдал


Монгол Улсад ГБХТТХууль хэрэгжиж эхлээд 17 жил өнгөрсөн хэдий ч гэр бүлийн хүчирхийлэл буурах биш өссөөр байна.

Цагдаагийн байгууллага хоногт 150 гэр бүлийн хүчирхийллийн дуудлага хүлээн авдаг, төрийн бус байгууллагуудаас хийсэн судалгаагаар өдөрт таван эмэгтэй гэр бүлийн хүчирхийллийн золиос болдог бөгөөд тэдний зөвхөн нэг нь л хууль хяналтын байгууллагын тусламжийг авдаг.¹⁰

10 ЦЕГ-ийн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Э.Баярбаясгалантай хийсэн ярилцлагаас.

Монгол Улсын өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг бөгөөд ГБХ үйлдсэн зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэх, ГБХ үйлдэх хийгээд ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгчийн дахин хүчирхийлэл үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, холбогдох зохицуулалт хангалттай хэрэгжихгүй эсвэл сайжруулах шаардлагатай байгааг ГБХ-тэй холбогдолтой хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлт илтгэж байна.

График 1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчлийн тоон үзүүлэлт, оноор



Дээрх графикаас харвал ГБХ үйлдэх зөрчил 2018 онд 5,577, 2019 онд 8,548 буюу өмнөх оныхоос 34,7 хувиар өссөн¹¹ үзүүлэлттэй ба 2020 онд 10306 зөрчил бүртгэгдсэнээс 8451 зөрчлийг, 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 6688 зөрчил бүртгэгдсэнээс 4723¹² ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн зөрчлийг шийдвэрлэжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх шалтгаан, сэдэлд хувь хүний өөрийн ёс суртахуун, ухамсар, хүмүүжил асар их нөлөөтэй хэдий ч нийгмийн хүчин зүйлүүд болох нийгэм, эдийн засгийн байдал, амьдрах орчин, нийгмийн хүрээлэл зэрэг ч нөлөөлдөг. Бид энэхүү судалгаагаар нийгмийн хүрээн дэх олон хүчин зүйлийг дэлгэрүүлэн дурдахгүйгээр судалгааны зорилтод дэвшүүлсний дагуу ГБХ үйлдэх зөрчлийн эрх зүйн зохицуулалтыг хэрхэн боловсронгуй болгосноор гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, цаашлаад зөрчил үйлдэгчид тохирсон хариуцлагыг оноох талаар цаашид дэлгэрүүлэн авч үзнэ.

11 Цагдаагийн ерөнхий газар, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2019, УБ, 2020 он, 405 дахь тал.

12 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, бүс, аймаг, нийслэлээр, сараар.

1. Гэр бүлийн хамаарал бүхий этгээд

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн үндсэн шинж нь тухайн хүчирхийллийн үйлдэл зөвхөн гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүдийн хооронд байх бөгөөд “гэр бүлийн хүчирхийлэл” гэдэг нь гэр бүлийн харилцааны хүрээнд нөгөө хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүй¹³ билээ. ГБХТхуульд зааснаар гэр бүлийн хамаарал бүхий этгээд гэдэгт дараах хүмүүсийг ойлгодог.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд
3.1. Энэ хуулийн үйлчлэлд дараах этгээд хамаарна:
3.1.1. эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;
3.1.2. тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.
3.2. Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна.

Зарим гадаад орнуудын хууль, эрх зүйн зохицуулалтад гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүдэд хэнийг хамааруулан хуульчилсныг дараах хүснэгтээр харууллаа. Манай улсын нэгэн адил гэр бүлийн хамаарал бүхий этгээдэд хамаарах хүмүүс нь нийтлэг ижил зохицуулалттай байх бөгөөд ГБХ-ийн үйлдлийг шийдвэрлэхдээ ГБХ-ийн хэрэг, зөрчлийн үндсэн шинж нь хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийн нэг нь нөгөөдөө эрх мэдэл, хяналтаа тогтоох явдал хэмээн олон улсад үздэг.

Хүснэгт 2. Гэр бүлийн хамаарал бүхий этгээд /гадаад улс орнуудын зохицуулалт/

№	Улс	Хуулийн зүйл, заалт
1	БНСУ	Гэр бүлийн хүчирхийллийн хариуцлагын (шийтгэлийн) тухай тусгай хууль ¹⁴ 2-р зүйл (Тодорхойлолтууд) 2. “Гэр бүлийн гишүүн” гэсэн нэр томъёо нь дараах хүмүүсийн аль нэгийг хэлнэ. (а) Эхнэр / нөхөр (бодит гэрлэлтийн харилцаанд байгаа хүмүүсийг оролцуулан; цаашид үүнийг мөн хамаарна) эсвэл хуучин эхнэр / нөхөр; (б) удам угсааны холбоотой хүн, өвөг дээдсийн хамааралтай байсан хүн (үрчлэн авах замаар бий болсон эцэг эх, хүүхдийн харилцаанд хамаарах болно; цаашид үүнийг мөн хамаарна); (в) Хойд эцэг эх, үр удмын хооронд харилцаатай байсан эсвэл аавын хууль ёсны эхнэр, эзэгтэйн хүүхдийн хооронд харилцаатай байсан хүн; (г) Хамт амьдардаг хамаатан садны хоорондын харилцаатай хүн;
2	Япон	Эхнэр, нөхрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ба хохирогчдыг хамгаалах тухай хууль (Act on the Prevention of Spousal Violence and the Protection of Victims) ¹⁵ 1-р бүлэг 1 дүгээр зүйл (3) Энэхүү хуульд хэрэглэсэн “эхнэр, нөхөр” гэсэн нэр томъёо нь хууль ёсны бүртгэлд бүртгэгдээгүй гэрлэлтийн бодит байдалтай байгаа хүмүүсийг багтаадаг. “Гэр бүл салалт” гэсэн нэр томъёо нь хууль ёсны бүртгэлд хамрагдаагүй, бодит байдал дээр гэрлэлтийн байдалтай байсан, нөхцөл байдал нь салалтын бодит байдал болж өөрчлөгдсөн хүмүүсийг багтаадаг.

13 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг.

14 Act on special cases concerning the punishment, etc. Of crimes of domestic violence, 2011 https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=28039&type=new&key.

15 Irako, Keiko, and Koji Ono. “The Prevention of Spousal Violence and the Protection of Victims in Japan.” Int'l Surv. Fam. L. (2005): 371. https://www.gender.go.jp/policy/no_violence/e-vaw/law/pdf/sv.pdf
Last visited 2021.10.14.

3	БНХАУ	БНХАУ-ын Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль 1-р бүлэг 2-р зүйл. Энэ хуульд заасны дагуу гэр бүлийн гишүүдэд эхнэр, нөхөр, эцэг эх, хүүхдүүд, бусад ойрын хамаатан садан орно. Асран хамгаалагч гэр бүлийн харилцаатай хүмүүсийн хоорондох хүчирхийллийг гэр бүлийн хүчирхийлэл гэж үзнэ. Гэр бүлийн тухай хууль 3.1.2. "гэр бүл" гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг;
4	Тайвань	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль ¹⁶ 3-р зүйл Энэхүү хуульд заасан гэр бүлийн гишүүн нь дараах гишүүд болон тэдний насанд хүрээгүй хүүхдүүдийг багтаадаг. 1. Эхнэр нөхөр эсвэл хуучин эхнэр / нөхөр. 2. Хамтран амьдарч байсан эсвэл урьд нь хамт амьдарч байсан хүмүүс, гэрийн эзэн болон өрхийн гишүүдийн хоорондын харилцаа эсвэл өрхийн гишүүдийн хоорондын харилцаа. 3. Одоо байгаа эсвэл хуучин цусан төрлийн хамаатан садан, гэрлэлтээр бий болсон удам дамжсан харилцаатай хүмүүс. 4. Одоо байгаа эсвэл хуучин ураг төрлийн дөрвөн үеийн доторх холын хамаатан садан, эсвэл гэрлэлтийн дагуу бий болсон холын хамаатан садны холбоотой хүмүүс.

Монгол Улсын эрх зүйн орчинд гэр бүлийн хүчирхийллийн хэргийг зүйлчлэхэд практикт ойлгомжгүй байдал үүсгэдэг нэгэн асуудал нь тухайн зөрчлийн шинжтэй үйлдэл гэр бүлийн хамаарал бүхий этгээдийн эсрэг мөн үү, биш үү гэдэг дээр цагдаа, прокурорын байгууллага хооронд нэгдмэл нэг ойлголттой бус байдаг гэжээ.

"Дээд шүүхээс шүүгч нартаа өгсөн зөвлөмж, Прокурорын газраас прокурорууддаа өгсөн зөвлөмж, өөрсдийн тайлбар дээрээ гэр бүлийн хамаарал бүхий гэдэгт зөвхөн нэг гэрт хамт амьдарч байгаа хүмүүсийг хэлнэ гэдэг. Гэвч ГБХТ-хуулиар гэр бүлийн харилцаатай байсан хүмүүс ч ордог. Прокуророос гэр бүлийн хамаарал бүхий хүмүүс биш байна аа, хүний биед халдах гэдэг зүйлчлэлээр торго гэж хэлдэг. Прокуророос сүүлийн үед гаргаж байгаа практик дээр хэрэв нэг гэрт амьдардаг бол 5.4 буюу гэр бүлийн хүчирхийллээр зүйлчилж шалга, хэрэв нэг гэрт амьдардаггүй бол 6.27 буюу хүүхдийн эрхийг зөрчих зөрчлөөр зүйлчилж шалга гэдэг."¹⁷

Судлаач О: "Шүүх гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн хооронд гарсан маргаан, үйлдэл бүрийг гэр бүлийн хүчирхийлэл биш гэж үзсэн. Яагаад гэвэл ГБХ нь урт удаан үргэлжилсэн, тухайн орчиндоо түгшүүр төрүүлсэн, нөгөө хүн нь хүчирхийлэгчээсээ айдаг шинжтэй байх ёстой. Гэтэл хоёулаа сайхан амьдарч байгаад нэг өдөр хардалтаас болоод мөн уг хардалт нь үндэслэлтэй, бодитой байвал нэгнийгээ цохисон хэрэг дээр ГБХ гэж зүйлчилж болохгүй. Хэрэв өмнө нь хүчирхийллийн түүх байхгүй бол нэг удаагийн харилцааны зөрчил гэж үзнэ.
ГБХ-ийг шалгахдаа зүйлчлэл дээр анхаарах ёстой. Шүүхийн практик дээр бодитой хардалтаас үүдэлтэй гэр бүлийн маргаан гарсан бол ГБХ гэж үздэггүй. Дээд шүүх шүүхийн практик тогтоосон. Ахуйн хүрээнд байнгын дарамтанд байхыг ГБХ гэж прокурор нар үздэг бол, цагдаа нар ахуйн хүрээнд хамт амьдардаггүй ч гэр бүлийн харилцаатай байсан хүмүүсийн хооронд гарсан хүчирхийллийг ГБХ гэж үздэг. Цагдаа нар харилцааны шинжтэй зөрчлийг ГБХ гэж үзэж зүйлчилснийг прокурор ГБХ биш гээд буцаадаг байна. Цагдаа нарт өгч байгаа үүрэг, чиглэл нь буруу байна. Гэр бүлийн харилцаатай хүмүүсийн хооронд гарсан л бол ГБХ гэж үз, тохиолдол болгоныг баривчил гэсэн чиглэл өгөөд байгаа нь асуудалтай. Харин шүүх, прокуророос хэргийг буцаадаг. ГБХ-ийн шинжийг сайн тодорхойлж, зүйлчлэлийн асуудал дээр анхаарах ёстой. Цагдаагийн албан хаагч нарт өгч буй зөвлөмжөө өөрчилж, шүүх прокурортой ойлголтоо нэгтгэх хэрэгтэй. Зөрчлийн хэрэг бүртгэгч нарт ямар тохиолдолд ГБХ, ямар тохиолдолд танхайрах гэх мэтээр зүйлчлээд байгаа гэдэг дээр зөвлөмж, чиглэл өгөх ёстой."¹⁸

16 Domestic violence act (2021) <https://law.moj.gov.tw/Eng/LawClass/LawAll.aspx?PCode=D0050071>.

17 ЦЕГ-ийн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн дарга Б.Баярбаясгалантай хийсэн ярилцлагын хэсгээс.

18 Бодлогын судлаачтай хийсэн ярилцлагын хэсгээс.

ГБХ-ийн аливаа үйлдлүүд нь бусад гэмт хэрэг, зөрчилтэй харьцуулахад дараах байдлаар онцлог байдаг. Үүнд:¹⁹

- а) Субъектийн хувьд ГБХ нь ихэвчлэн эдийн засаг, эрх мэдлийн тэгш бус харьцаатай гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүдийн хооронд үйлдэгддэг.
- б) Байнга давтамжтай, далд нууцаар үйлддэг. Хүчирхийллийн үйлдэл тухайн хүний үзэл хандлагатай холбоотой учир үзэл бодол нь өөрчлөгдөөгүй цагт давтагдсаар л байдаг. Давтамж нь янз бүр байх бөгөөд зарим тохиолдолд 1-2 жилийн зайтай байх тохиолдол бий.
- в) ГБХ тойрог хэлбэрээр байнга давтагдан даамжирч байдаг бөгөөд хохирогч уг эргүүлгээс гарахад хэцүү байдаг.

Дээрх хоёр ярилцлагаас дүгнэвэл цагдаа, шүүх, прокурорын байгууллага гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг шалган шийдвэрлэхэд гэр бүлийн хамаарал бүхий этгээд гэсэн ойлголтыг нэг мөр ойлгоогүйгээс гэмт хэрэг, зөрчлийн хэргийн зүйлчлэл хийхэд бэрхшээл тулгарч, цагдаагаас ГБХ зөрчил байна хэмээн хэрэг бүртгэлтээ хийгээд явж байхад прокурорын хяналтаар зүйлчлэлийг өөрчлүүлэх, хэргийн нөхцөл байдлыг шинээр судлах зэрэг процессыг даамжруулах маргаан бүхий асуудлууд гардаг болох нь тогтоогдож байна. Иймд гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүд хоорондын маргаан бүрийг ГБХ-ийн зөрчил хэмээн үзэж, хэтэрхий чанга буюу зөвхөн баривчлах шийтгэл оноож буй нь алдаа, дутагдалтай, эргээд гэр бүлийн нандин харилцааг сэвтүүлэх, цаашлаад гэр бүл салалтад нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй.

Дээр дурдсанчлан цагдаагийн алба хаагчид ГБХ-ийн шинж байдлыг сайтар ойлгож, тухайн тохиолдол хуульд заасан гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хэдий ч нэг удаагийн маргаан бүхий шинжтэй, хохирогчийн буруутай үйлдлээс бус үнэхээр эрх мэдлийн тэнцвэргүй харилцааны үндсэн дээр ГБХ-ийн 4 хэлбэрийн аль нэгээр²⁰ хүчирхийлэл үйлдэгдсэн, тэр нь давтагддаг эсвэл давтагдах шинжтэй эсэхэд мэдрэмжтэй хандах юм. Мөн шүүхээс энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэхэд практик тогтсон, прокурорын байгууллага мөн түүний дагуу хяналт тавьж шийдвэрлэдэг бол цагдаагийн байгууллага, ГБХ-ийн зөрчлийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулж, ойлголтоо нэгтгэн хууль тогтоомжоо нэг мөр хэрэглэх хэрэгтэй.

Цагдаагийн алба хаагч нь хууль сахиулагч болохынхоо хувьд хэрэг, зөрчлийг зүйлчлэхдээ хуульд заасан утга агуулгаар ойлгож, хуулийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлдэг тул практикт тулгарч буй энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд хууль тогтоомжоо нарийвчлан зохицуулж, аргачлалаа боловсронгуй болгон энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил дээр ажилладаг цагдаагийн ажилтнуудыг чадавхжуулах тал дээр дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй.

19 Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO), Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ" мэргэжилтнүүд болон өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага, УБ, 2020 он, 12 дахь тал.

20 ГБХТхуульд зааснаар ГБХ нь сэтгэл санааны; эдийн засгийн; бие махбодийн; бэлгийн хүчирхийлэл гэсэн 4 хэлбэртэй.

2. Шийтгэлийн үр нөлөөтэй байдал

Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдэгчид оноож буй “Шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино.”²¹ хэмээн тодорхойлсон байдаг. Хуулийг зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг хуульчилж олон нийтэд хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг таниулах замаар урьдчилан сэргийлэх ба хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх замаар хууль, шударга ёсыг тогтоодог.²² Ийнхүү шударга ёсыг тогтоохдоо зөрчил үйлдэгчийн хүлээж буй хариуцлага нь тухайн үйлдсэн зөрчилдөө тохирсон бөгөөд гэмт хэргийн шинжтэй зөрчлийн хэргийн хувьд дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг арилгах, үйлдлийнхээ хор уршгийг ойлгосон байх ёстой.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон зөрчлийн хууль мөрдөгдөхөөс өмнө 2015-2016 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг болон захиргааны хариуцлагын тоо төдийлөн буураагүй. 2017 онд өмнөх онд 1886 байсан зөрчил 4369 болж огцом өссөн. 2018 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 197, зөрчил 4270²³, 2019 оны байдлаар 8229 болж өссөн. Судлаачид энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн тоо өсөлттэй байгааг ГБХТхууль батлагдаж, гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг иргэд, цагдаагийн байгууллагад шуурхай дамжуулдаг болж иргэний үүргээ биелүүлж байгаатай, цагдаагийн зүгээс дээрх дуудлага, мэдээллүүдийг нэн тэргүүнд шалгаж хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэл бүрд хуулийн хариуцлага ногдуулж байгаатай холбоотой²⁴ хэмээн тайлбарладаг хэдий ч бодит байдалд ГБХ-ийн зөрчлийг давтан үйлдэгчдийн тоо их байгаагаас харахад зөрчилд оноож буй шийтгэл үр нөлөө багатай, нөгөөтэйгүүр зарим тохиолдолд тохирсон шийтгэл болж чадахгүй байгаа юм.

Зөрчлийн тухай хуулиар ГБХ-ийн зөрчил үйлдэгчид 7-30 хоног баривчлах, баривчилгаанд байгаа хугацаанд албадан сургалтад хамруулах шийтгэл ногдуулдаг. Энэхүү шийтгэлийн оновчтой байдлыг судлахын тулд баривчлах болон албадан сургалтын талаар задлан авч үзье.

А) Баривчлах шийтгэлийн тухайд

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гаргасны улмаас баривчлагдсан иргэдийн тоо сүүлийн 3 жилийн үзүүлэлтийг Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтсийн гаргасан статистик мэдээнээс авч үзэхэд тогтмол өссөн буюу тухайлбал, нийслэлийн хэмжээнд ГБХ-ийн зөрчил хамгийн ихээр бүртгэгддэг Баянзүрх дүүргийн хувьд зөвхөн ГБХ-ийн зөрчил үйлдэн баривчлагдсан хүмүүсийн тоо 2019 онд өмнөх оныхоос 2,3 дахин өсчээ.


21 Зөрчлийн тухай хууль, 3.1 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

22 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь сургалтын гарын авлага, УБ, 2019 он, 14 дэх тал.

23 Шүүхийн судалгаа, мэдээллийн хүрээлэн “Монгол Улсын шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан” УБ, 2018 он, 28 дахь тал.

24 ХЗДХЯ, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар танилцуулга, УБ, 2018 он.

График 2. Баянзүрх дүүрэг дэх баривчлах байрны баривчлагдсан этгээдийн мэдээ



ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэрэг нэмэгдэх, давтан үйлдэгдэх, түүний улмаас гэр бүлийн гишүүдийн эрх зөрчигдөж, хохирогчдын тоо даган нэмэгдэж байгаа нь урьдчилан сэргийлэх ажлыг цаашид эрчимжүүлэх, зан үйлд нөлөөлөх сургалтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хууль бол нэг талаас иргэн бүр эрхээ чөлөөтэй эдлэх боломж нөхцөл, баталгааг бүрдүүлж буй төрийн үүргийн үндсэн хэлбэр болох тул хуулийн үйлчлэл буюу үйлчилгээ нь нэгдмэл, цогц, шуурхай хэрэгжих, нэг мөр ойлгогдох ёстой, иргэдэд цаг хугацаа алдах, нэмэгдэл зардал чирэгдэл үүсгэх, зөрчил гаргаж болох нөхцөл байдалд зориуд хүргэхээр байх ёсгүй.²⁵

Вард Фарнсвортын Эрх зүйн аналитист номонд дурдагдсан нэгэн онол нь “Thinking at the margin” буюу дараагийн алхмынхаа талаар бодох гэсэн үг юм. Халуун өдөр уусан эхний аяга нимбэгний ундаа таны цангааг тайлдаг бол дараагийн аяга ундаа нь тийм ч их биш байх магадлалтай. Хэрэв та захын зайд бодож байгаа бол дараагийн эсвэл нэмэлт үйлдэл нь таны хувьд ямар утга учиртай болохыг бодно”²⁶. Үүнээс үзвэл ГБХ үйлдсэн хүнд эхний удаад нь шууд баривчлах ял оноож байгаа нь түүнийг хийсэн үйлдлээ ухамсарлаж дахин үйлдэхгүй байхыг анхааруулж байгаа хэлбэр боловч дахин хүчирхийлэл үйлдэн ирж байгаа нь түүнд уг шийтгэлийн арга хэмжээ хүрч ажиллахгүй байгааг харуулж байна. Эхний удаад баривчлагдан гарч ирээд 2 дахь удаагаа баривчлагдахад түүнд уг шийтгэл нь тийм ч хүндээр тусахгүй бөгөөд түүнийг ямар ч айх айдасгүй болгож байж магадгүй юм. Тиймээс эхний үйлдэл дээр нь баривчлах арга хэмжээ авах нь оновчтой биш гэж үзэх боломжтой байна. Баривчлах арга хэмжээ нь хамгийн сүүлийн буюу дахин хүчирхийлэл үйлдэж байгаа хүнд чиглэсэн хатуу арга хэмжээ байх нь зүйтэй.

Судалгааны ажлынхаа хүрээнд 2021 оны 09 дүгээр 01-ний өдөр Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр ГБХ-ийн үйлдсэн зөрчлийн хэргийн шүүх хуралд ажиглагчаар оролцсон бөгөөд дараах нөхцөл байдал ажиглагдсан.

25 Г.Ганбаатар, Л.Оюунчимэг, “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” Шүүх эрх мэдэл №4(2017), 103 дахь тал.

26 Ward Farnsworth, The Legal Analyst, University of Chicago press, 2007, Chapter 3.

1. Зөрчлийн хэрэг 1-д, зөрчилд холбогдогч эхнэрийгээ зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан ба удаа дараа ГБХ-ийн болон өөр бусад зөрчлийн хэрэгт холбогдож байсан. Өмнө нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдэж, 1 жилийн хорих ял эдэлсэн. Гэсэн хэдий ч 2021 оны 08 дугаар сард ГБХ-ийн давтан зөрчил үйлдэж, шүүхээс 15 хоног баривчилж, 20 цагийн албадан сургалтад хамруулах шийтгэл оноосон.
2. Зөрчлийн хэрэг 2-т, зөрчилд холбогдогч удаа дараа архидан согтуурч, нийтийн амгалан тайван байдал алдагдуулах зөрчил үйлдэж байсан бөгөөд хамтран амьдрагчийнхаа биед халдсан, бага насны хүүхдийн дэргэд хүчирхийлэл үйлдэн, ГБХ-ийн зөрчилд холбогдсон. Шүүх хуралдааны үеэр хохирогч “Би айлгая гэж бодоод цагдаа дуудсан, тухайн үедээ худал мэдүүлэг өгсөн юм” хэмээн мэдүүлгээ буцаасан. Уг зөрчлийн хэрэгт ГБХ үйлдсэн нь нотлогдож байх тул шүүхээс 20 хоног баривчлах, 30 цаг албадан сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн.
3. Зөрчлийн хэрэг 3-т, зөрчилд холбогдогч эхнэрээ зодсон, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдэл нь нотлох баримтаар тогтоогдож байгаа тул шүүх 7 хоног баривчлах, 10 цагийн албадан сургалтад суух шийтгэл оноосон. Тус зөрчлийн хэргийн хувьд зөрчил үйлдэгч өөрийгөө өмгөөлөн тус үйлдэл нь эхнэрийн буруутай үйлдлээс болсон, “би гэрээсээ хол, олон хоногоор явдаг ажилтай, тэр хооронд эхнэр хүүхдүүдийг өөр айлд аваачиж, гэртээ өөр хүмүүс дагуулан ирдэг” зэрэг тайлбарыг хэлсэн боловч шүүх зөрчил үйлдсэн нь нотлогдож байгаа учир шийтгэлийг оногдуулсан.
4. Зөрчлийн 4-т, хамтран амьдрагчийнхаа биед халдаж, шүүхээс 7 хоногийн баривчлах шийтгэл оногдуулахад ГБХ үйлдсэн зөрчил үйлдэгч “Би хийсэн үйлдэлдээ гэмшиж байна. Би өвчтэй ээжийгээ асардаг, намайг баривчилгаанд байх хугацаанд ээжийг маань асрах хүн өөр байхгүй” хэмээн тайлбар хэлж байсан.

Дүгнэхэд:

Зөрчлийн тухай хуулийн эрүүгийн хуулиас ялгагдах онцлог нь тухайн зөрчлийн хэрэг үйлдэгчийн санаа, сэдэл, учир холбогдлыг харгалзан үздэггүй, хуулиар хориглосныг үйлдсэн үйлдэл, эс үйлдэхүй үйлдэгдсэн тохиолдолд зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг явдал юм. Гэтэл эрүүгийн шинжтэй энэ төрлийн зөрчлийн хэргүүд нь тохиолдол бүрийн нөхцөл байдал өөр өөр шинжтэй байх нь олонтаа бөгөөд анх тухайн зөрчил үйлдэгчид хийгээд, хохирогчийн буруутай үйлдлээс болж ГБХ үйлдэж байгаа тохиолдолд ч хуулиар өөр сонгох шийтгэлийн төрөл байхгүй, зөвхөн баривчлах шийтгэлийг хуульчилж буй нь, ГБХТхуулийн зорилгод нийцэхгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж буй баривчлах шийтгэл үр дүн муутай, хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлж чадахгүй, гэр бүлд эргээд сэтгэл санаа, эдийн засгийн хохирол учруулж байгаа учир тухайн хохирогч мэдүүлгээсээ буцах, торгуулийн дүн бага зөрчлөөр шийдүүлэх, улмаар цагдаагийн байгууллагад гомдол мэдүүлэхээ болих шийдэлд хүрч байгаа нь хүчирхийллийг даамжруулах эрсдэлтэй²⁷ байна.

27 Нээлттэй нийгэм форум, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдал орон нутагт, УБ, 2021 он, 3 дахь тал.

Түүнчлэн ГБХ үйлдэгч нь хүчирхийлэл давтан үйлдсээр байгаагаас дүгнэхэд зөрчил үйлдэгчтэй тулж ажиллах албадан сургалтын хөтөлбөрийн агуулга, чанарыг сайжруулах, энэ талаар илүү анхаарах, өөр төрлийн шийтгэл, арга хэмжээ үгүйлэгдэж байна. Гэр бүлийн анх тутам үйлдсэн хүчирхийллийг хүчирхийллийн аргаар шийдвэрлэх нь оновчтой арга зам биш²⁸ болох нь шүүхийн практикаас харагдаж байна. ГБХ- шууд баривчилснаар гэр бүлийн хүчирхийллийг хязгаарлах, зогсоох бус эсрэгээр гэр бүлийн гишүүдийн харьцаа, хоорондын итгэлцлийг үгүйсгэх, сөрөг, ноцтой үр дагаварт хүргэж болох нөхцөл байдал шүүхийн практикаас ажиглагдаж байгааг анхаарах нь чухал юм.²⁹

Жишээ болгон шүүхийн шийдвэрээс дурдвал 2021 оны 5-р сарын 21-ний өдрийн 2021/ДШМ/510 дугаартай Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн хохирогчийн мэдүүлэгт “чи намайг 7 хоног баривчилгаанд явуулаагүй байсан бол би энэ хэргээс мултарчих байсан юм хэмээн цохиж зодсон”, “ингээд тэр эд мөрийн баримт гээд байгаа юмаа сонсгоорой хэмээн утсыг авч шидэн эвдэлсэн”³⁰ гэснээс харахад хүчирхийлэл үйлдсэн этгээдийг баривчлах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бус харин бүр өш хонзонгийн улмаас дахин гэмт хэрэг үйлдэх сэдлийг бий болгодог болох нь харагдаж байна. Үүнээс үзэхэд ГБХ үйлдсэн хүнийг шууд баривчилснаар уг хүн нь дуудлага өгч гомдол гаргасан хохирогчид өс хонзон санан улмаар дахин хүчирхийлэл үйлдэх сэдэл болдог нь практикаас харагдаж байна. Хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хийсэн үйлдэлдээ гэмших, дахин хүчирхийлэл үйлдэхгүй байх санаа сэдлийг өгөх нь чухал байгаа боловч Зөрчлийн тухай хуулиар шууд баривчилж байгаа нь уг зорилгод хүрэхэд саад болж байна.

Б) Албадан сургалтын тухайд

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу зохих шийтгэл авсан этгээдэд албадлага болгон хэрэглэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5 дахь хэсэгт баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна гэж заасан. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэгчийг албадан сургалтад хамруулахын гол зорилго нь давтан зөрчил гаргуулахгүй байх юм. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалт нь гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, амьдралын эерэг хандлагатай иргэн болгон төлөвшүүлэх зорилготой хэдий ч үр дүн нь зорилгоо бүрэн хангаж чадахгүй байна.³¹

28 Г.Ганбаатар, Л.Оюунчимэг, “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” Шүүх эрх мэдэл №4(2017), 100 дахь тал.

29 Г.Ганбаатар, Л.Оюунчимэг, “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” Шүүх эрх мэдэл №4(2017), 108 дахь тал.

30 Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан / www.shuukh.mn/-аас түүвэрлэн авав.

31 Ц.Алтанцэцэг, С.Эрдэнболор “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал” Хууль дээдлэх ёс сэтгүүл №1 (2020).

Тухайлбал, ННФ-аас хийсэн судалгаагаар Цагдаагийн газрын Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын сэдэв, хөтөлбөрөөс харахад тухайн хүмүүст ихэвчлэн хууль, дүрмийн талаарх мэдлэг, архи тамхины хэрэглээ буюу хорт зуршлын сөрөг үр дагаврын талаар сургалт хийдэг нь төдийлөн үр дүнтэй биш байна³² хэмээн дүгнэжээ.

"Зөрчлийн хэрэг үйлдэн баривчлах шийтгэл авсан хүмүүст ордог албадан сургалт нь үнэхээр үр нөлөөгүй, хүнд нөлөөлж ч чаддаггүй. Ялангуяа 7 хоногийн баривчилгаагаар ирсэн хүмүүс бол харгалзагч, нийгмийн ажилтнуудтай зүй бусаар харьцдаг, тэнд байгаа хүмүүстэй маазарч байгаад л гараад явдаг. Албадан сургалтын агуулга нь хувь хүнд чиглэсэн бус хууль тогтоомжоор болох, болохгүй гэсэн зүйлсийг л заадаг. Давтан зөрчил үйлдээд орж ирсэн хүмүүст ч өнөө л нэг сургалтаа дахин дахин давтсаар байгаад гаргадаг."³³

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь:

- Сайн дурын
- Албадан гэсэн хэлбэртэй байна.³⁴

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулах ба уг сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална гэсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/73 тушаалаар баталсан.

Тус «Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр»-ийн 9.2-т "Сургалт тус бүрийн үргэлжлэх хугацаа, сургалтын нийт цаг 23-56 цаг байна" гэж заасан бөгөөд сургалтын төрлийг дараах байдлаар ангилан тусгажээ.

1. Сэтгэл зүйн сургалт
 - Архинд донтолт, болон түүний хор уршгийн талаар
 - Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах
 - Уур бухимдлыг хэрхэн зохицуулах
 - Харилцах ур чадвараа дээшлүүлэх
 - Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх
 - Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх
 - Хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүй
 - Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх
2. Эрх зүйн сургалт
 - Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль
 - Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль
 - Бясалгалын сургалт

32 Нээлттэй нийгэм форум, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдал орон нутагт, УБ, 2021 он, 3 дахь тал.

33 Баривчлах байрны ажилтантай хийсэн ярилцлагын хэсгээс.

34 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 44.1.

Дээрх сургалтын төрлүүдийг авч үзвэл хэрэг, зөрчил үйлдэгчдийн зан үйлд нөлөөлж, үйлдлийнх нь хор уршгийг ойлгуулж, дахин хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой өргөн хүрээний сургалтын агуулгатай журам боловсруулан гаргасан байна. Гэвч бодит нөхцөл байдал дээр албадан сургалтын үйл ажиллагаа бодит үр дүнтэй байх хийгээд сургалтын зорилгодоо³⁵ ч бүрэн нийцэж чадахгүй байгаа нь энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн тоо буурахгүй байгаагийн томоохон нэг хүчин зүйл болж байна.

Албадан сургалттай холбоотойгоор судлаачдын шүүмжлэл дагуулсан нэг зүйл нь Зөрчлийн тухай хуулийн 4.5-т “албадан сургалт 10-50 цагийн хугацаатай байна” гэж заасан байх ба уг журмаар сургалтын нийт цаг 23-56 цаг байдаг. Практикт сургалтыг хэрэгжүүлэх нэгжүүд сургалтын цагийг шийтгэвэрт заасан хугацаатай уялдуулахдаа агуулгын залгамж холбоог алдагдуулах, сургалтын хөтөлбөрт тусгагдсан агуулгыг хасах, хамааралгүй сэдэв оруулах, агуулгыг гүйцэт орохгүй байх зэрэг нөхцөл байдлыг үүсгэдэг гэсэн байна. Түүнчлэн манай орны хувьд мэргэжилтнүүдийн бэлтгэгдсэн байдал хангалтгүй, боловсон хүчин цөөн, төсөв, санхүүжилт муу зэрэг олон асуудлын улмаас сургалтын чанар маш муу, сургалтад хамрагдагчдад нөлөөлөх чадваргүй байна. Мөн уг журамд заасны дагуу сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран зохион байгуулах бөгөөд зөвхөн нийслэлийн хэмжээнд баривчлах байрны ажилтнаас мэдээлэл авахад албадан сургалт нь үр нөлөөгүй, сайжруулах шаардлага байгааг дурдаж байхад орон нутагт зан үйлд нөлөөлөх сургалт орох мэргэжилтэн хомс, хамтран ажиллах байгууллага хүрэлцээгүй байдаг байна.

Зарим тохиолдолд ГБХ нь харилцан хоёр хүний буруутай үйлдэл, таагүй харилцаа, хохирогчийн буруугаас болж үйлдэгддэг тул энэ тохиолдолд сайн дурын сургалтад хэрэг, зөрчилд холбогдогч нарыг хамтад нь суулгадаг эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй. ГБХТхуульд заасан уг сайн дурын сургалтыг ямар тохиолдолд, хэнд, хэрхэн орох тухай зохицуулалт байхгүй, зөвхөн зөрчил үйлдэгчид баривчлах хугацаанд нь үр нөлөөгүй албадан сургалт ороод эргээд л нөгөө хүн нь хуучин нөхцөл байдал, гэр бүлийн таарамжгүй харилцаатай ахуйдаа очдог энэ байдлыг анхааран авч үзэх нь зүйтэй.

Хууль зөрчигдөхгүйгээр амьдралд шууд хэрэгжих, үйлчлэх үндсэн нөхцөл, арга зам нь тухайн хууль дахь иж бүрэн зохицуулалт буюу хамгийн гол нь хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангах хариуцлагын оновчтой механизм, түүний тодорхой, ойлгомжтой байдал билээ. Иймд асуудлаа өргөн хүрээгээр нь харан системээр нь засаж, сайжруулах, хууль тогтоомж, дүрэм журамдаа нарийвчилсан зохицуулалтаа нэмж, өөрчлөх, эргээд уг хуулийнхаа хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, албадан сургалтын хөтөлбөрт заасан эдгээр сургалтуудыг бодит нөхцөл байдалд хэрхэн орж байгааг өөрчлөх, сургалт орж байгаа хүмүүсийг чадавхжуулах, илүү мэргэжлийн хүмүүсээр сургалт оруулахын тулд төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

35 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, 3 дугаар зүйлийн 3.1. Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг гэмт, хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын эерэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.1.1 ГБХ-ийн зөрчил ба гэмт хэргийн уялдаа холбоо

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн ГБХ үйлдэх зөрчлөөс ялгагдах гол шинж нь гэмт хэргийг “байнга” үйлдэх объектив шинж болон учирсан хохирол, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл үр дагавар нь энэ төрлийн зөрчлөөс үлэмж их байдаг. Гэмт хэргийн “байнга” гэх объектив шинж нь гэмт этгээдээс гэр бүлийн хамаарал бүхий хүний эсрэг хүчирхийллийн үйлдлийг тодорхой хугацааны завсарлагатайгаар гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байх, тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй байх, гэмт зан төлөв нь амьдралд хэвшин тогтсон дадал зуршил болсон байх, үйлдэл бүр бие даасан гэмт хэрэг, зөрчлийн шинжийг агуулсан байх зэрэг болно.³⁶ Зөрчлийн тухай хуулийг Эрүүгийн хуультай нягт уялдуулах асуудал маш чухал атал уг асуудал зарим талаар дутмаг байна. Гэмт үйл явдал буюу зөрчлийн нийгмийн аюул, үнэт зүйлс, эрх ашигт учруулсан гэм хор (хохирол, хор уршиг)-ын шинж байдал зэргийг харгалзан гэмт хэрэг эсхүл зөрчилд тооцох шалгууртай, түүнчлэн Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зарим шинж хангагдаагүй эсхүл Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцоогүй бусад зарим зөрчлийг Зөрчлийн хуулиар зөрчилд тусгайлан тооцсон байх нь гэмт хэрэг, зөрчилтэй иж бүрэн тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, зохицуулалт болдог.³⁷

Зөрчлийн тухай хуульд ГБХ үйлдэх зөрчил нь дотроо 4 шинжтэйгээр хуульчлагдсан байх ба тэдгээр 4 шинжийн 2 нь Эрүүгийн хуульд хуульчлагдаагүй. Тодруулбал, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, эс үйлдэх, бусадтай харилцахыг хязгаарласан гэх үйлдлүүд нь Эрүүгийн хуульд байхгүй. “Заавал нэг хүчирхийллийн шинж нь байнгын байхыг шаардахгүй, өөр өөр шинж нь давтагддаг бол байнгын гэж үзэж болох”³⁸ бөгөөд Зөрчлийн тухай хуулиар уг Эрүүгийн хуульд тусгагдаагүй зөрчлөөр 2-3 удаа баривчлах шийтгэл ногдуулаад дараагийн удаад нь эрүүгийн хэрэг үүсгэх гэхээр уг зөрчлийн шинж нь гэмт хэрэгт тооцогддоггүй асуудал практикт бий болоод байна.

Шүүхээр шийдвэрлэсэн зарим хэргүүдийн шийтгэх тогтоолтой танилцахад уг гэмт хэргийн зүйлчлэлийг ялгамжтай байдлаар хийж, хүний эрхийг зөрчих эсхүл ял завшуулж буй нь харагдсан юм. Энэ нь нэг талаас эрүүгийн хуулийн зохицуулалт учир дутагдалтай, хийдэл, зөрчилдөөнийг агуулсан нөгөө талаас шинэ төрлийн гэмт хэрэг утгаар практикт тогтсон жишиг, уламжлал ялгамжтай байгаатай холбоотой. Үүний бодит жишээг доорх шүүхийн шийдвэрийн жишээнээс харж болно.

36 Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO), Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ Мэргэжилтнүүд болон өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага, УБ, 2020 он, 82 дахь тал.

37 Г.Ганбаатар, Л.Оюунчимэг, “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” Шүүх эрх мэдэл №4 (2017), 106 дахь тал.

38 Бодлогын судлаачтай хийсэн ярилцлагын хэсгээс.

Хүснэгт 3. Шүүхийн шийдвэрийн жишээ³⁹

№	Шүүх	Шийдвэрийн огноо, дугаар	Шүүхийн шийдвэрийн агуулга, үндэслэл
1	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2021.07.19 Дугаар 2021/ДШМ/69	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгт авагдсан нотлох баримтуудаас үзвэл Ж.Д нь архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Төв аймгийн Зуунмод сумын 3 дугаар багийн 4-15 тоотод байх гэртээ 2020 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хамтран амьдрагч Б.Цэнддоог “айлд хаяж явлаа” гэх шалтгаанаар зодож хамрыг нь хугалж эрүүл мэндэд нь хөнгөн хохирол санаатай учруулсан, мөн гэр бүлийн хамаарал бүхий харьцаатай хүн болох хамтран амьдрагч Б.Цэнддоог 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “айлд хоолоо” гэх шалтгаанаар хэрүүл маргаан үүсгэж, улмаар ёс бус үг хэлж, галын дэгээ төмөр хэрэглэн зодсон, 2021 оны 01 дүгээр сарын 21-22-нд шилжих шөнө ёс бус үг хэрэглэж, цамцтай, хөл нүцгэн гэрээсээ хөөж гаргасан, 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хэрүүл маргаан үүсгэж, ёс бус үг хэрэглэж, куртикийн малгайнаас нь болон үснээс нь зулгааж чирэн байнга зодож, харгис хэрцгий харьцан, догшин авирлаж гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрийн үйл баримт тогтоогдож байна. Давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон шүүгдэгчийн өмгөөлөгч С.Сувдмаа шүүх хуралдаанд гаргасан саналдаа: Шүүхээс Ж.Дгийн нэг удаагийн үйлдэлд нь давхардуулан Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулиар давхардуулан хариуцлага тооцсон гэх саналыг хэлсэн. Б.Батцэнгэлийн үйлдсэн дээрх гэмт үйлдлийг Төв аймгийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-т тус тус зааснаар зүйлчилсэн хэргийн зүйлчлэл зөв байна. Анхан шатны шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана” гэж заасны дагуу хуульд зааснаар шүүх хуралдаанд оролцогч нарын дүгнэлт, тайлбар, шинжлэн судалсан бичгийн нотлох баримтуудад үндэслэн хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт хийжээ. Иймд шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Ж.Д-гийн өмгөөлөгч С.Сувдмаагийн гаргасан “...мөрдөн байцаалтын шатанд хэт нэг талыг баримтлан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчиж нотлох баримт цуглуулсан тул шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж өгнө үү...” гэх агуулга бүхий давж заалдсан гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүхээс дүгнэв.

39 Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан /www.shuukh.mn/-аас түүвэрлэн авав

Уг шүүхийн шийдвэрээс харахад давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон шүүгдэгчийн өмгөөлөгч С.Сувдмаа шүүх хуралдаанд гаргасан саналдаа: Шүүхээс Ж.Дгийн нэг удаагийн үйлдэлд нь давхардуулан Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулиар давхардуулан хариуцлага тооцсон гэсэн нь Эрүүгийн хуулийн 1.3.5-р зүйлд заасан “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн шударга ёсны зарчмыг зөрчиж байх магадлалтай байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан “Хүнийг алах” гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл болох “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж” гэх ойлголтыг, мөн эл нөхцөлийг иш татсан диспозици хэлбэртэйгээр хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулсан гэмт хэргүүдэд хүндрүүлэх нөхцөл болгон хуульчилсан бөгөөд ийм хэргүүдийг зүйлчлэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дахь хэсэгт заасан гэмт хэрэгтэй нийлмэлээр, зарим тохиолдолд тухайн хүндрүүлэх нөхцөлийг дангаар хэрэглэн зүйлчилж байна.

Нэг үйлдэл, эс үйлдэхүйгээр Эрүүгийн хуулийн хоёр буюу түүнээс дээш өөр өөр зүйлд заасан гэмт хэргийг бие даасан бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэнийг ойлгох бөгөөд шалтгаант холбоо нь онолын үүднээс эдгээр гэмт хэрэг нь хоёул материаллаг бүрэлдэхүүнтэй байх боломжгүй. Дээрх тохиолдол нийлмэлээр зүйлчлэгдэж буй гэмт хэргүүд төгс үйлдэгдсэн буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн диспозицид заасан объектив, субъектив бүх шинжүүдийг бүрэн хангасан байх ёстой.

Харин нэг удаагийн үйлдлээр буюу зөрчил үйлдэх явцдаа гэр бүлийн хамаарал бүхий хүнийг санаатай алсан, хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулсан бол дангаар буюу Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8, 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгүүдээр тус тус зүйлчилнэ. Гэр бүлийн гишүүдийн хоорондын таарамжгүй харьцаа, хохирогчийн илтэд буруутай үйлдэл, үйл ажиллагаа, эр эмийн бодитой хардалт зэргээс улбаалан үйлдэгдэн гарсан хэргийг ийнхүү хүндрүүлэн зүйлчлэх нь хуулийн үндэслэлгүй зүйлчлэл болно.

Гаднын орнуудын нийтлэг жишиг хандлагаас харахад тухайн гэмт хэрэг Эрүүгийн хуульд бие даасан гэмт хэрэг болон хуульчлагдаагүй, ихэнх тохиолдолд тодорхой төрлийн гэмт хэргийн “энэ гэмт хэргийг гэр бүлийн хамаарал бүхий хүний эсрэг үйлдсэн” гэх хүндрүүлэх нөхцөлөөр, Англи-Саксони эрх зүйн бүлд хамаарах орнууд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусдаа хуулиар зохицуулсан байдаг.⁴⁰ Мөн тухайн гэмт хэргийг эхлээд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусгайлсан хуулиараа зохицуулж хариуцлагын арга хэмжээ аваад улмаар дахин хүчирхийлэл үйлдвэл Эрүүгийн хуулиараа хариуцлага тооцдог байна. Үүнтэй холбоотой зүйлчлэлийг дараагийн бүлэг болох Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтаас харж болно.

Зөрчлийн тухай хуулиар зөрчил үйлдэгч ГБХ үйлдсэн зөрчлийнхөө төлөө захиргааны хариуцлага хүлээсэн гэж үзнэ. Захиргааны хариуцлага хүлээсэн гэдэг нь тухайн захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болж, улмаар зөрчил үйлдэгч этгээд шүүхээс оногдуулсан захиргааны тухайн шийтгэлийг эдэлж дууссан байхыг ойлгоно. Энэ үндэслэлээр авч үзвэл “гэр бүлийн хүчирхийлэл” үйлдэх зөрчлийг 2 удаа буюу давтан үйлдэж, захиргааны хариуцлага хүлээсэн этгээд дахин гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн тохиолдолд шууд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдаж байгаа нь Эрүүгийн хуульд заасан хууль ёсны зарчимтай нийцэхгүй байна.

40 Д.Бадам, У.Буянтогтох “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал” Хууль дээдлэх ёс сэтгүүл №4, УБ, 2019 он.

ГБХ үйлдэх гэмт хэргийн объектив шинжийн “байнга” гэдэгт гэмт этгээдээс гэр бүлийн хамааралтай хүний бие махбодод хүч хэрэглэн халдаж зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрхэд халдсан хэд хэдэн удаагийн идэвхтэй үйлдэл бөгөөд үйлдэл бүр бие даасан гэмт хэрэг, зөрчлийн шинжийг агуулсан байхыг ойлгоно.

Гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд үйлдэгдэн гардаг гэмт хэргүүдэд хүндрүүлэх нөхцөл болгон хуульчлах нь практикт зүйлчлэл хийхэд хамгийн ойлгомжтой бөгөөд хүндрэл бэрхшээл гарахгүй гэж үздэг байна. Иргэн, хуулийн этгээд өөрт зайлшгүй хэрэгцээтэй салбарын хуулиа дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэхэд тухайн хуульд эрх үүрэг, түүнчлэн эрх, үүргийн хэмжээ хязгаар буюу зөрчвөл хүлээлгэх хариуцлагын механизм нь нэг мөр тодорхой, ойлгомжтой, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх боломжийг нэг мөр, иж бүрэн олгосон, ойлгуулсан мэдрүүлсэн байх ёстой.⁴¹

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив заавал байх шинжийг хууль тогтоогч тухайн үйлдлийг “байнга” үйлдсэн байхаар хуульчилсныг практикт янз бүрээр ойлгож хэргийн зүйлчлэлийг хийжээ. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл хэмээн тооцогдох үйлдлийг байнга үйлдсэн, энэ нь нотлогдсон тохиолдолд л гэмт хэрэг хэмээн тооцогдож, зохих арга хэмжээг авч байна. Хоёр дахь удаагийн үйлдэл нь цагдаад өгсөн хоёр дахь дуудлага эсвэл хоёр дахь шүүхийн шийдвэрээр тодорхойлогдох уу гэдэг дээр нэгдсэн байр сууринд хүрээгүй байна.⁴² Ийнхүү “байнга” гэх ойлголтыг энэ гэмт хэргийн тухайд хасах шаардлагатай. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг харгалзан зөрчлөөс ялган зүйлчлэл хийх боломжтой учраас үйлдлийн давтамж бус шинжээр хуульчилж тухайн зүйлийн диспозид тусгах нь зүйтэй.

2.3. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны энэ хэсэгт гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн эрх зүйн зохицуулалтаа хэрхэн боловсронгуй болгож болох талаар олон улсын сайн жишгийг судлах зорилго дэвшүүлэн БНХАУ, Япон, БНСУ-ын зэрэг улсын хууль тогтоомжид судалгаа хийж, тойм байдлаар харуулахыг зорилоо.

2.3.1. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх эрх зүйн зохицуулалт

БНХАУ

1930-аад оноос Хятад улсад гэр бүлийн хүчирхийлэл нь тулгамдсан асуудал болсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч⁴³, энэ нь 1980-аад оны эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөөс шалтгаалан чухал асуудлын нэг болоод байна.

41 Г.Ганбаатар, Л.Оюунчимэг, “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” Шүүх эрх мэдэл №4(2017), 103 дахь тал.

42 Монголын Криминологичдын Холбоо, Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь, УБ, 2020 он, 9 дэх тал.

43 Milwertz, Cecilia (2003). “Activism Against Domestic Violence in the People's Republic of China”. Violence Against Women. 9 (6).

Гэр бүлийн хүчирхийллийг 2015 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2 дугаар зүйлд тодорхойлж заасан байна. Үүнд «гэр бүлийн гишүүд нэгнийгээ зодох, хязгаарлах, айлган сүрдүүлэх, тахир дутуу болгох, бие махбодийн эрх чөлөөг хязгаарлах, хэл амаар доромжлох зэргээр бие махбодь, сэтгэл зүйн болон бусад зөрчил гаргах»⁴⁴ гэж тодорхойлжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн талаар анх 1995 онд “Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т дурдсан бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ажлыг нэн тэргүүнд тавихыг уриалжээ.⁴⁵ Хэдийгээр энэ нь гэр бүлийн хүчирхийллийн талаар анх удаа дурдсан боловч, хууль эрх зүйн зарим баримт бичигт хууль бус үйлдэл гэж заасан байна. “БНХАУ -ын Үндсэн хууль”, “БНХАУ -ын Иргэний хуулийн ерөнхий зарчим”, 1980 оны “Гэрлэлтийн тухай хоёр дахь хууль”, “Эмэгтэйчүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах тухай хууль”-д эмэгтэйчүүдийг болон гэр бүлийн гишүүдийг хүчирхийлэхийг хориглосон заалтууд тусгагдсан байдаг. Гэр бүлийн хүчирхийлэл нь ил тод, албан ёсоор хууль бус болсон хэдий ч, 20-р зуунд бодит байдал дээр хүчирхийлэлд өртөгсөд хууль ёсны нөхөн төлбөр нэхэх механизм байгаагүй юм.

Дээр дурдсанчлан Хятад улсын хувьд гэр бүлийн хүчирхийллийг “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”⁴⁶-иар тодорхойлсон бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгт дараах хариуцлагыг хүлээлгэхээр заажээ. Үүнд:

33-р зүйл: Хэрэв хүчирхийлэл үйлдэгч нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явцдаа нийтийн аюулгүй байдлын удирдлагыг зөрчсөн гэж үзвэл хуулийн дагуу захиргааны шийтгэл оногдуулах бөгөөд хэрэв гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлагыг хуулийн дагуу хүлээлгэнэ.

34-р зүйл: Хэрэв хариуцагч нь хувийн аюулгүй байдлыг хамгаалах журмыг зөрчиж гэмт хэрэгт холбогдсон бол түүнийг хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шийднэ.

Хэрэв энэ нь гэмт хэрэгт тооцогдохгүй бол Ард түмний шүүх сануулга өгч, нөхцөл байдлыг харгалзан нэг мянган юань хүртэлх торгууль ногдуулах, 15 хоногоос бага хугацаагаар цагдан хорино.

44 Domestic Violence Law of the People's Republic of China.

45 Zhao, Yuhong (2000). “Domestic Violence in China: In Search of Legal and Social Responses”. UCLA Pacific Basin Law Journal.

46 Domestic Violence Law of the People's Republic of China.

Хүснэгт 4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бүх талуудын хэрэгцээ⁴⁷

Хэрэгцээний төрлүүд	Хэрэгцээний агуулга	Нийлүүлэгч	Шаардагч
Хууль эрх зүйн	Цагдаагийн оролцоо	Олон нийтийн аюулгүй байдлын байгууллага	Хохирогч
	Шүүх эмнэлэгийн шинжилгээ	Шүүх эмнэлэг	Хохирогч
	Хувийн аюулгүй байдлын хамгаалалтын тушаал	Ардын шүүх	Хохирогч
	Хууль ёсны байцаан шийтгэх ажиллагаа (Гэр бүл цуцлуулах, Эрүүгийн гэмт хэргийг өөрөө шийтгэх, Хохирлыг нөхөн төлүүлэх)	Ардын шүүх	Хохирогч ба гэмт хэрэгтэн
	Хууль зүйн туслалцаа	Шүүхийн захиргааны Хэлтэс	Хохирогч ба гэмт хэрэгтэн
	Хууль эрх зүйн туслалцаа, зөвлөгөө	Эмэгтэйчүүдийн холбоо	Хохирогч ба гэмт хэрэгтэн
Аюулгүй байдал	Хамгаалах байр	Иргэний хэргийн газар	Хохирогч
	Аюулгүй байдлын-төлөвлөлт ба сэтгэл хөдлөлийн дэмжлэг	Эмэгтэйчүүдийн холбоо ба Нийгэмлэг	Хохирогч ба гэмт хэрэгтэн
	Эмнэлгийн эмчилгээ	Эмнэлгийн хэлтэс	Хохирогч ба гэмт хэрэгтэн
Эрүүл мэнд	Сэтгэлзүйн эмчилгээ	Сэтгэлзүйн үйлчилгээний газар	Хохирогч ба гэмт хэрэгтэн

БНСУ

1998 онд Солонгосын засгийн газар гэр бүлийн хүчирхийллийн тухай хоёр хуулийг батлан хэрэгжүүлсэн. “Гэр бүлийн хүчирхийллийн хариуцлагын тухай тусгай хууль”(Хариуцлагын тухай хууль)-д гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн шийтгэлийг хуульчилсан байдаг. “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль” (Хамгаалалтын тухай хууль) нэртэй хоёр дахь хууль нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах зорилготой.

“Хариуцлагын тухай хуулийн” зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлээс үүдэн гэр бүл салсан бол тэдний арга хэмжаа авахтай холбогдох харилцааг зохицуулдаг.⁴⁸ (Шийтгэлийн тухай хуулийн 1 дүгээр зүйл).

“Хамгаалалтын тухай хуулийн” зорилго нь хохирогчдыг хамгаалах явдал бөгөөд шийтгэл гэхээсээ илүү гэр бүлийн орчин, боловсролыг дээшлүүлэх замаар эрүүл гэр бүлийг бий болгох зорилготой. (Хамгаалалтын тухай хууль 1-р зүйл).⁴⁹

2009 онд Солонгосын Засгийн газар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг шийтгэх, урьдчилан сэргийлэх ажилд улсын төсвөөс 27.1 тэрбум вон зарцуулсан байна.⁵⁰

47 Sources: Data from Manual 2014, 40.

48 Act on special cases concerning the punishment, etc. of crimes of domestic violence, 2011.

49 Act on the Prevention of Domestic Violence, etc of Victims Thereof.

50 Refugees, United Nations High Commissioner for. “Refworld | Korea, Republic of: Domestic violence, including legislation, availability of state protection and support services for victims”. Refworld. Retrieved 2019-06-07.

Солонгос улсын хувьд гэр бүлийн хүчирхийллийг “Гэр бүлийн хүчирхийллийн хариуцлагын тухай тусгай хууль”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль»-иар тодорхойлсон бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгт дараах хариуцлагыг хүлээлгэхээр заажээ. Үүнд:

63 дугаар зүйл (Хамгаалалтын дэглэмийг дагаж мөрдөхгүй байх)

- (1) Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн дараах гэмт хэрэгтнүүдийг 2 жилээс илүүгүй хугацаагаар хорих эсвэл 20 сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна.
1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтэн нь 40 (1) зүйлийн 1-ээс 3-р дэд хэсгийн аль нэгэнд хамаарах хамгаалалтын дэглэмийг сахин биелүүлэх шийдвэр эцэслэн гарсны дараа хамгаалалтын дэглэмийг дагаж мөрдөөгүй бол;
2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь 55-2 дугаар зүйлд заасны дагуу хохирогчийг хамгаалах тушаал, 55-4 дүгээр зүйлд заасан түр хамгаалалтын даалгаврыг хүлээн авсны дараа хохирогчийг хамгаалах журам, түр хамгаалалтын даалгаврыг биелүүлээгүй бол;
- (2) Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтэн (1) дэх хэсэгт заасан зөрчлийг байнга үйлддэг бол гурван жилээс илүүгүй хугацаагаар хорих эсвэл 30 сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна.

Мөн Солонгос улсын гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлж буй дэмжлэг, хамгаалж буй байдал нь онцлог харагдаж байна. Үүнээс жишээ болгон үзвэл:

“Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль”-ийн 7-5 дугаар зүйлд (Хамгаалах байрны хамгаалалтын зардлыг дэмжих)

- (1) Хамгаалах байранд хүлээн авсан хохирогчийг эсвэл хохирогчийн хамт түүний гэр бүлийн гишүүдийг хамгаалах шаардлагатай бол төр, орон нутгийн засаг захиргаа нь хамгаалах байрны даргад эсвэл хохирогчид шаардлагатай дараах зардлыг олгоно. Үүнд:
 1. Амьжиргааны өртөг;
 2. Хүүхдийн боловсролд зориулсан тэтгэмж;
 3. Хүүхэд харах үйлчилгээний зардал;
 4. Мэргэжлийн сургалттай холбоотой гарсан зардал;
- 4-2. Хамгаалах байрнаас халагдсаны дараа бие даах санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
5. Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад зардал гэж тусгасан нь бусад орноос илүү давуу харагдаж байна.

Мөн тус улсад амьдарч буй гадны иргэд, цагаач, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг мөн адилаар хамгаалахаар тусгасан нь сайшаалтай.

Япон Улс

1990-ээд оны турш олон судалгаа хийсний дараа Япон улс “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль”-ийг 2001 онд баталсан.⁵¹ Тус хуульд гэр бүлийн хүчирхийллийг «Үндсэн хуулиар хүйс хоорондын тэгш эрхийн зарчмыг зөрчсөн» гэж заасан байдаг. Энэхүү хуулиар хүчирхийлэлд өртсөн гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авч, муж болгонд дэмжлэг үзүүлэх төвийг байгуулсан боловч эмэгтэйчүүд тэдний өгсөн мэдүүлгийг хүчирхийлэгч нь олж мэднэ гэж айж уг төвүүдэд хандаж эмчид үзүүлэхээс зайлсхийж байсан.

2013 онд 100,000 эмэгтэй гэр бүлийн хүчирхийллийн талаар хоргодох байранд ирсэн байна.⁵² Хамгаалах байранд ирсэн 10 мянган эмэгтэйн бараг тал хувь нь хүүхдүүд эсвэл гэр бүлийн бусад гишүүдтэйгээ хамт иржээ.

Японд иргэдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах боломжтой хууль байдаг нь “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ба хохирогчдыг хамгаалах тухай хууль” юм. Тус хууль нь гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх, зөвлөгөө өгөх, хамгаалах, бие даах дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох замаар эхнэр, нөхрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах зорилготой. Үүнийг ихэвчлэн “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль” гэж нэрлэдэг. Энэ хууль нь Японд амьдардаг бүх гадаадын иргэдэд ижил хэрэгждэг.

Япон улсад “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай хууль”-иар дүүргийн шүүхэд хүчирхийлэгчдийг зургаан сарын хугацаагаар таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчирхийлэгчдийг хоёр долоо хоногийн хугацаатай гэрээс нь хөөж гаргахыг зөвшөөрсөн. Шүүхийн шийдвэрийг зөрчсөн хүмүүст нэг жил хүртэл хугацаагаар шоронд хорих эсхүл 1 сая иен (8000 орчим доллар) торгууль төлөх хариуцлага тооцдог. Гэр бүлийн хүчирхийллийн талаар худал мэдээлэл өгсөн хүн 100,000 иен (800 орчим доллар) хүртэл торгууль төлөхөөр заасан.

Гэвч уг хууль нь хохирогчыг хамгаалах зүйл заалтыг агуулдаг боловч гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцдоггүй байна. Япон улсын Эрүүгийн хуульд мөн гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцоогүй байна.⁵³

2.3.2. Гэр бүлийн хүчирхийлэлд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

Хятад улсын хувьд БНХАУ-ын Эрүүгийн хууль⁵⁴ 4-р бүлгийн 260 дугаар зүйлд “Гэр бүлийн гишүүдтэйгээ зүй бусаар харьцаж ноцтой нөхцөл байдалд хүргэсэн бол хоёр жил ба түүнээс бага хугацаагаар хорих ял, цагдан хорих, эсхүл ажиглалтад байлгана. Дээрх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж, хохирогчдод хүнд гэмтэл учруулж, амь насыг нь хохироосон бол хоёроос долоон жилийн хорих ял онооно.

51 Nemoto, Keiko; Rodriguez, Rachel; Valhmu, Lucy Mkandawire (May 2006). “Exploring the Health Care Needs of Women in Abusive Relationships in Japan”. Health Care for Women International. 27 (4): 290–306. doi:10.1080/07399330500511774. PMID 16595363. S2CID 275052.

52 Cabinet Office, Gender Equality Bureau. “Violence against Women”.

53 Penal code of Japan, 1907 <http://www.gender.go.jp/>.

54 Criminal law of the People’s Republic of China.

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд шалгана.” гэж заажээ.

Солонгос улсын хувьд Эрүүгийн хууль⁵⁵ 25 дугаар бүлгийн 257 дугаар зүйлд:

- (1) Бусдын бие махбодид гэмтэл учруулсан этгээдэд долоон жилээс дээшгүй хугацаагаар хорих, арван жилээс дээшгүй хугацаагаар мэргэших эрхийг түдгэлзүүлэх эсвэл арван сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. <1995 оны 12-р сарын 29 -ний өдрийн 5057 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан>
- (2) (1) дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь гэмт хэрэгтэн ба түүний ураг төрлийн хүн, эхнэр / нөхөр-ийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгдсэн бол нэг жилээс дээшгүй хугацаагаар хорих эсвэл арван таван сая воноос хэтрэхгүй торгууль оногдуулна. <1995 оны 12 -р сарын 29 -ний өдрийн 5057 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан>
- (3) Өмнөх хоёр зүйлийн гэмт хэргийг үйлдэхээр завдсан бол дээрх шийтгэлийг оногдуулна.

258 дугаар зүйл

- (1) Бусдын бие махбодид гэмтэл учруулж, амь насанд нь аюул учруулсан этгээдийг нэг жилээс арван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.
- (2) Бусдыг гэмтээсний улмаас тахир дутуу, эмчлэх боломжгүй, өвчтэй болсон хүнд хамаарна.
- (3) Гэмт хэрэг нь гэмт хэрэгтэн ба түүний ураг төрлийн хүн, эхнэр / нөхөр-ийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгдсэн бол хоёр жилээс доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

259 дүгээр зүйл (Гэмтэлээс үүдэн нас барах)

- (1) Бусдын бие махбодид гэмтэл учруулж, улмаар үхэлд хүргэсэн этгээдийг гурваас дээш жилийг хорих ялаар шийтгэнэ. <1995 оны 12 -р сарын 29 -ний өдрийн 5057 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан>
- (2) Гэмт хэрэг нь гэмт хэрэгтэн ба түүний ураг төрлийн хүн, эхнэр / нөхөр-ийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгдсэн бол түүнийг бүх насаар эсхүл таван жилээс доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

260 дугаар зүйл (Хүчирхийллийн гэмт хэрэг)

- (1) Бусдын эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ял, таван сая воноос доош торгууль оногдуулна. <1995 оны 12 -р сарын 29 -ний өдрийн 5057 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан>
- (2) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь гэмт хэрэгтэн ба түүний ураг төрлийн хүн, эхнэр, нөхөр хоёрын хооронд үйлдэгдсэн бол таван жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл долоон сая вон хүртлэх торгууль оногдуулна. <1995 оны 12 -р сарын 29 -ний өдрийн 5057 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан>

55 Criminal code of South Korea, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG.

- (3) (1), (2) дахь хэсэгт заасан гэмт хэргийг хэрэв хохирогч эсэргүйцсэн бол шалгаж болохгүй. <1995 оны 12 -р сарын 29 -ний өдрийн 5057 тоот хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан> гэж заажээ. Үүнээс харахад Солонгос улс нь гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл үйлдэхийг Эрүүгийн хуульдаа хүндрүүлэх нөхцөлөөр тодорхойлж заасан байна.

Харин Япон улсын хувьд гэр бүлийн хүчирхийллийг “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль”-иар зохицуулж тус хуульд ял, шийтгэлийг нь заасан талаар дээр дурдсан. Япон улс гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үздэггүй бөгөөд Эрүүгийн хуульд тусгаагүй байна.

2.3.3. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зохицуулалт

БНХАУ

Гэр бүлийн хүчирхийллийн талаар анх 1995 онд “Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т дурдсан бөгөөд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг нэн тэргүүнд тавихыг уриалжээ.⁵⁶ Хятад улс нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдэд ял шийтгэл оноож, хариуцлага хүлээлгэхээ урьтал болгохгүй харин урьдчилан сэргийлэх арга хэмжээнд илүү ач холбогдол өгдөг байна. Үүний тод жишээ нь “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”-ийн 2-р бүлэгт: Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар зохицуулалт оруулсан.

6-р зүйл: Тус улс нь гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сургалт, сурталчилгааг явуулж, иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн эсрэг мэдлэгийг нэмэгдүүлэх үүрэгтэй.

Үйлдвэрчний эвлэл, Коммунист залуучуудын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо нь тус тусын чиг үүргийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулах үүрэгтэй.

Радио, телевиз, сонин хэвлэл гэх мэт мэдээллийн хэрэгсэл нь гэр бүлийн харилцаа, хүчирхийллийн эсрэг сурталчилгаа явуулах ёстой.

Сургууль, цэцэрлэг нь хүүхдүүдэд гэр бүлийн харилцаа, хүчирхийллийн эсрэг боловсрол олгох үүрэгтэй.

7-р зүйл: Аймгийн түвшний болон түүнээс дээш түвшний Ард түмний засгийн газрын холбогдох хэлтэс, шүүх эрх мэдэл, Эмэгтэйчүүдийн холбоо статистикийн хороо нь гэр бүлийн хүчирхийллийг зогсооход тодорхой үүрэг хүлээнэ.

Эрүүл мэндийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүний оношлогоо, эмчилгээний бүртгэлийг хөтлөх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдолд сургалт хийх.

8-р зүйл: Хот суурин газрын ард түмний засаг захиргаа, дүүргийн харьяа байгууллагууд, оршин суугчдын хороод гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах бөгөөд Хороо, тосгоны нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

56 Zhao, Yuhong (2000). “Domestic Violence in China: In Search of Legal and Social Responses”. UCLA Pacific Basin Law Journal.

- 9-р зүйл: Бүх шатны Ард түмний засгийн газар нь нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага болох сэтгэл зүйн болон эрүүл мэндийн зөвлөгөө өгөх үйлчилгээ, гэр бүлийн харилцааны удирдамж, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах талаар боловсрол олгох үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
- 10-р зүйл: Ардын эвлэрүүлэн зуучлалын байгууллага нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх түүнийг бууруулах зорилгоор гэр бүлийн маргааныг шийдвэрлэх үүрэг хүлээнэ.
- 11-р зүйл: Ажил олгогч нь албан хаагчдад зориулан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай сургалт хийх ёстой. Хэрэв ажил олгогч нь алба хаагчид гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгааг олж мэдвэл хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ авч, гэр бүлийн маргааныг шийдвэрлэх тал дээр зөвлөгөө өгөх үүрэгтэй.
- 12-р зүйл: Насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалагч нь гэр бүлийн тухай боловсролыг олгож, асран хамгаалах үүргээ хуулийн дагуу биелүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхгүй байх үүрэгтэй гэж тодорхой зааж өгчээ.

БНСУ

“Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай хууль”⁵⁷-д урьдчилан сэргийлэх талаар тусгасан байдаг. Уг хуулийг 2007 оны 10-р сард шинэчлэн найруулж, бүх сургуульд гэр бүлийн хүчирхийллийн талаар заавал сургалт оруулахаар тусгасан. Мөн тус хуулийн 4-7 дугаар зүйлд:

- (1) Ерөнхийлөгчийн зарлигаар гэр бүлийн хүчирхийллийн талаарх нийгмийн мэдлэгийг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор жилд нэг долоо хоногийг “Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох” долоо хоног болгоно.
- (2) Мужийн болон орон нутгийн засаг захиргаа нь “Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох” долоо хоногийг өнгөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх долоо хоногт зориулсан арга хэмжээг дээрх арга хэмжээтэй хамтарсан эрхион байгуулж болно гэж заасан байдаг.

Солонгос улс нь “Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг дэмжих тухай бодлого”⁵⁸ боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд:

57 Act on the Prevention of Domestic Violence, etc of Victims Thereof
<https://evaw-global-database.unwomen.org/-/media/files/un%20women/vaw/full%20text/asia/act%20on%20the%20prevention%20of%20domestic%20violence%20and%20the%20protection%20of%20its%20victims%20as%20amended%202006/republic%20of%20korea%20%20act%20on%20the%20prevention%20of%20domestic%20violence%20and%20protection%20etc%20of%20victims%20thereof.pdf?vs=2044>.

58 Prevention of Violence against Women Children and Support for the Victim Policy, 2015 Ministry of Gender Equality & Family.
http://www.mogef.go.kr/eng/pc/eng_pc_f011.do.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үзүүлэх дэмжлэг:

(Эмэгтэйчүүдийн яаралтай тусламжийн дуудлага 1366) Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн наймааны хохирогчдод яаралтай зөвлөгөө өгөх, холбогдох байгууллагуудтай холбоо тогтоох.

(Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд зориулсан зөвлөгөө өгөх төв, хамгаалалтын байгууламжийн үйл ажиллагааг дэмжих) Хүчирхийллийн үр дагаврын талаар зөвлөгөө өгөх, хохирогчдыг хамгаалах, орон байраар хангах, хохирлыг арилгах хөтөлбөр, өөрийгөө дэмжих боловсрол олгох хөтөлбөр гэх мэт зөвлөгөө өгөх.

(Хохирогчдын үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээг дэмжих) Хууль ёсны төлөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ гэх мэт хууль зүйн тусалцаа үзүүлэх

(Хохирогчдын эмчилгээ, хамгаалалт) Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй бие махбодийн болон сэтгэлзүйн гэмтлийн оношлогоо, эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх

(Хохирогч эмэгтэйчүүдэд орон сууцны дэмжлэг үзүүлэх) Хохирогчид болон тэдний ар гэрийнхэнд түрээсийн байр өгөх.

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боловсрол:

(Зорилго) Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нийгмийн ухамсрыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор олон нийтийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх боловсролын хэрэгжилтийн бүртгэлд хяналт, шалгалт хийх; төрөл бүрийн агуулга боловсруулах; мэргэжлийн багш бэлтгэх замаар урьдчилан сэргийлэх боловсролыг дэмжих.

(Зорилтот) Төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагууд, хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэг

(Цагны тоо) Хүчирхийллийн төрөл тус бүрт жилд нэгээс илүү цаг (бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл)

(Боловсролын арга) Мэргэжлийн багшийн хамтын боловсролын янз бүрийн аргуудыг хэрэгжүүлэх, аудиовизуал материал ашиглан хамтын боловсрол олгох, кибер лекц гэх мэт.

Япон улс

Япон улсад гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль”-д тусгасан байна. Тус хуулийн 2-р бүлэгт “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг зөвлөгөө өгөх, дэмжих төв нь

(3) Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалахын тулд Гэр бүлийн хүчирхийллийн талаар зөвлөгөө өгөх, дэмжих төвүүд дараах ажлуудыг хийх ёстой.

- (i) хохирогчдод тодорхой асуудлын талаар мэргэжлийн байгууллагаар дамжуулан зөвлөгөө өгөх;
- (ii) хохирогчид тэдэнтэй холбох зориулсан удирдамж гаргах, бие махбодь болон сэтгэл зүйн эмчилгээг хийх;

- (iii) яаралтай үед аюулгүй байдлыг хангах, хохирогчдыг түр хамгаалалтад авах (хохирогч гэр бүлийн гишүүнийг хамт дагуулж явах тохиолдолд 5 -р зүйл, 8-3 дугаар зүйл мөн адил хамаарна);
- (iv) мэдээлэл, зөвлөгөө өгөх, холбоо тогтоох, зохицуулах, хохирогчдын бие даах чадварыг дээшлүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орон сууц худалдан авах, нийгмийн туслалцааны системийг ашиглах болон бусад хэлбэрийн тусламж, арга хэмжээний талаархи холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах гэж заажээ.

Дээрх 3 орны жишээнээс харахад гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлд иргэдэд мэдлэг, мэдээлэл өгч улмаар нийтээр нь соён гэгээрүүлэх тал дээр анхаардаг болох нь харагдаж байна. Гэр бүлийн талаарх зөв ойлголтыг цэцэрлэг, бага сургуулиас нь эхэлж зааж, сургаж буй нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүнийг эхний ээлжид сануулга өгөөд засаж залруулж зөв чиглүүлж, хүмүүжүүлэн улмаар бат бөх, эрүүл харилцаатай гэр бүлийг бий болгоход зорьдог байна. Харин уг сануулга, шүүхээс өгсөн үүрэг даалгаврыг үл тоомсорлож дахин хүчирхийлэл үйлдсэн этгээдэд зохих шийтгэлийг өгөхөөр хуульчилжээ.

Хүчирхийлэлд өртсөн хохирогчыг хамгаалах, тэдний эрх ашгийг нэн тэргүүнд тавих, зөрчигдсөн эрхийг сэргээх, сэтгэл зүй болон бие махбодийн эрүүл мэндэд нь анхаарч нөхөн сэргээх тал дээр ажиллаж, тэднийг бие даан амьдрах тал дээр дэмжлэг үзүүлж буй явдал нь тун магтууштай. Хүчирхийлэлд өртсөн, хүчирхийллийн гэрч болсон эсхүл хүчирхийлэлтэй орчинд өсөж торниж байгаа хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэнд, зөв хүн болж хүмүүжих түүгээр зогсохгүй сурч боловсрох тал дээр маш сайн анхаардаг байна.

Манай улсын эрх зүйн зохицуулалтад дээрх орнуудын сайн жишгийг харгалзан хохирогчийг хамгаалах арга хэмжээг дараах байдлаар сайжруулж болно:

- Хамгаалах байрны нөхцөл бололцоог сайжруулах
- Хамт оршин суудаг хаягнаасаа нүүж, хуульд хугацаанд ойртохыг хориглох
- Хохирогчийн байнга очдог газраас хол байхыг анхааруулах (ажил, сургууль, цэцэрлэг гэх мэт)
- Хохирогчтой холбоо барихыг хязгаарлах (и-мэйл, утас, шуудан гэх мэт)
- Хохирогчид сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн төлөв байдлыг судлахдаа Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэргийн нөхцөл байдлыг судалж, хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлуудыг дараах байдлаар тодорхойллоо.

1. Цагдаа, шүүх, прокурорын байгууллага гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг шалган шийдвэрлэхэд гэр бүлийн хамаарал бүхий этгээд гэсэн ойлголтыг нэг мөр ойлгоогүйгээс гэмт хэрэг, зөрчлийн хэргийн зүйлчлэл хийхэд бэрхшээл тулгарч байна.
2. ГБХ-ийн зөрчлийг давтан үйлдэгчдийн тоо их байгаагаас харахад зөрчилд оноож буй шийтгэл үр нөлөө багатай, зарим тохиолдолд тохирсон шийтгэл болж чадахгүй байна. Энэ төрлийн зөрчлийн хэргүүд нь тохиолдол бүрийн нөхцөл байдал өөр өөр шинжтэй байх нь олонтаа бөгөөд анх тухайн зөрчил үйлдэгчид хийгээд, хохирогчийн буруутай үйлдлээс болж ГБХ үйлдэж байгаа тохиолдолд ч хуулиар өөр сонгох шийтгэлийн төрөл байхгүй, зөвхөн баривчлах шийтгэлийг хуульчилсан нь Зтх, ГБХТхуулийнхаа зорилгод нийцэхгүй байна. Энэ нь гэр бүлд эргээд сэтгэл санаа, эдийн засгийн хохирол учруулж байгаа учир тухайн хохирогч мэдүүлгээсээ буцах, торгуулийн дүн бага зөрчлөөр шийдүүлэх, улмаар цагдаагийн байгууллагад гомдол мэдүүлэхээ болих шийдэлд хүрч байгаа нь хүчирхийллийг даамжруулах эрсдэлтэй байна.
3. Манай улсын хувьд ГБХ-тэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ хууль тогтоогчид гэмт хэрэг, зөрчил үйлдэгчид баривчлах шийтгэл оногдуулснаар үүсэн гарах үр дагаврыг бүрэн тооцоолоогүй, хохирогч болон гэр бүлийн гишүүдэд үүсэх сэтгэл санаа, эдийн засгийн дарамтыг хэрхэн шийдвэрлэх зохицуулалт дутмаг байна. БНСУ-ын жишээн дээр авч үзвэл “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль”-аар төр, орон нутгийн засаг захиргаа нь хамгаалах байрны даргад эсвэл хохирогчийг амьжиргааны өртөг; хүүхдийн боловсролд зориулсан тэтгэмж; хүүхэд харах үйлчилгээний зардал; мэргэжлийн сургалттай холбоотой гарсан зардал; хамгаалах байрнаас халагдсаны дараа бие даах санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр олон талын дэмжлэг үзүүлдэг. Бид олон улсын эдгээр сайн жишгийг хууль тогтоомждоо боломжит нөхцлөөр тусгаж өгөх шаардлагатай.
4. Албадан сургалт нь бодит нөхцөл байдал дээр ямар ч үр дүнгүй, зөрчил үйлдэгчийн зан төлөвийн онцлогт тохируулах хийгээд сэтгэл зүйн сургалтууд ордоггүй, сургалтын зорилгодоо бүрэн нийцэхгүй байгаа нь энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн тоо буурахгүй байгаагийн томоохон нэг хүчин зүйл болж байна. Мөн уг сургалтын явц, чанарт хяналт тавьж ажиллах механизм дутагдаж байна.
5. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив заавал байх шинжийг хууль тогтоогч тухайн үйлдлийг “байнга” үйлдсэн байхаар хуульчилсныг практикт янз бүрээр ойлгож хэргийн зүйлчлэлийг хийж байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл хэмээн тооцогдох үйлдлийг байнга үйлдсэн, энэ нь нотлогдсон тохиолдолд гэмт хэрэг хэмээн тооцогдож, зохих арга хэмжээг авч байна. Хоёр дахь удаагийн үйлдэл нь цагдаад өгсөн хоёр дахь дуудлага эсвэл хоёр дахь шүүхийн шийдвэрээр тодорхойлогдох уу гэдэг дээр нэгдсэн байр сууринд хүрээгүй байна.

САНАЛ

1. Гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүд хоорондын маргаан бүрийг ГБХ-ийн зөрчил хэмээн үзэлгүйгээр, зөрчлийн хэргийн дуудлага бүр дээр цагдаагийн алба хаагч нар мэдрэмжтэй ажиллах шаардлагатай. Иймд хуульчдын үргэлжилсэн сургалт болон хууль сахиулагчдын мэргэжлийн сургалтад ГБХ-ийн зөрчилтэй холбоотой сургалтын хөтөлбөр боловсруулж, нэгдсэн ойлголт, ур чадвар олгох;
2. ГБХ нь зарим тохиолдолд харилцан хоёр хүний буруутай үйлдэл, таагүй харилцаа, хохирогчийн буруугаас болж үйлдэгддэг тул энэ тохиолдолд сайн дурын болон албадан сургалтад хэрэг, зөрчилд холбогдогч нарыг хамруулдаг эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй. Хууль зөрчигдөхгүйгээр амьдралд шууд хэрэгжих, үйлчлэх үндсэн нөхцөлийг бий болгохын тулд ГБХ-ийн зөрчлийн асуудлыг өргөн хүрээгээр нь харан системээр нь засаж, сайжруулах, хууль тогтоомж, дүрэм журамдаа нарийвчилсан зохицуулалтаа нэмж, өөрчлөх, эргээд уг хуулийнхаа хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, албадан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч, төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, сургагч багшийг чадавхжуулах, нарийн мэргэшсэн сургагч нараар сургалт оруулах;
3. Гэр бүлийн маргаанаас үүдэн гарсан зөрчилд Зөрчлийн тухай хуулиар юун түрүүнд баривчлах шийтгэл оногдуулалгүйгээр уян хатан зохицуулалтыг бий болгож, гэр бүлийн асуудлыг эвээр шийдвэрлэх гэж оролдох нь оновчтой байна. Зарим улс орны ГБХ-ийн эрх зүйн зохицуулалтыг судалсны үндсэн дээр дараах арга хэмжээнүүдийг ГБХ-ийн гэмт хэргийн шинжгүй үйлдэлд хариуцлага оногдуулахдаа баривчлахаас гадна доорхи хариуцлагын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, ГБХ үйлдсэн этгээдэд хүрч ажиллах, дахин хүчирхийлэл үйлдэхгүй байх тал дээр дэмжлэг үзүүлж анхаарч ажиллавал зохистой. Үүнд:
 - Сануулга өгөх
 - Баривчлахгүйгээр албадан сургалтад хамруулах
 - Хэрэгт холбогдогч нарыг хамтад нь сургалтад хамруулах
 - Сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх
 - Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авахХэрэв эдгээр хариуцлагын арга хэмжээг зөрчсөн эсвэл ГБХ олон дахин үйлдсэн нь нотлогдож байгаа тохиолдолд Эрүүгийн хуулиар шийтгэх нь оновчтой. Эдгээрийг холбогдох хууль, дүрэм журам уялдуулан нарийн зохицуулах хэрэгтэй байна.
4. Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “байнга” гэх ойлголтыг энэ гэмт хэргийн тухайд хасах шаардлагатай. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг харгалзан зөрчлөөс ялган зүйлчлэл хийх боломжтой учраас үйлдлийн давтамж бус шинжээр хуульчилж тухайн зүйлийн диспозид тусгах зэрэг арга хэсжээг авч болно.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1.
2. Зөрчлийн тухай хууль, 2017
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2004
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (Шинэчилсэн найруулга), 2016
5. Гэр бүлийн тухай хууль, 1999
6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019
7. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 2016
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017
9. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/73 тушаал, Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр

Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага, УБ, 2017.
2. Цагдаагийн ерөнхий газар, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, УБ, 2020 он.
3. Гэр бүлийн хүчирхийлэл, www.cccp.mn/гэр-бүлийн-хүчирхийлэл/
4. Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага, УБ, 2017 он
5. Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль Монгол улс Хүний эрхийн тайлан, УБ, 2014 он
6. НҮБ-ын Хүн Амын сан, Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа, УБ, 2018 он
7. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай цагдаагийн албан хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт, УБ, 2018 он
8. Монголын Криминологичдын Холбоо, Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь, УБ, 2018 он
9. Цагдаагийн ерөнхий газар, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2019, УБ, 2020 он
10. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь сургалтын гарын авлага, УБ, 2019 он
11. Шүүхийн судалгаа, мэдээллийн хүрээлэн “Монгол Улсын шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан” УБ, 2018 он
12. ХЗДХЯ, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар танилцуулга, УБ, 2018 он
13. Г.Ганбаатар, Л.Оюунчимэг, “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” Шүүх эрх мэдэл №4(2017)

14. Нээлттэй нийгэм форум, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдал орон нутагт, УБ, 2021 он
15. Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан. Холбоос: www.shuukh.mn
16. Ц.Алтанцэцэг, С.Эрдэнболор “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал” Хууль дээдлэх ёс сэтгүүл №1 (2020)
17. Д.Бадам, У.Буянтогтох “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчэлийн асуудал” Хууль дээдлэх ёс сэтгүүл №4 (2019), УБ, 2019 он
18. Монголын Криминологичдын Холбоо, Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь, УБ, 2020 он

Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Ward Farnsworth, The Legal Analyst, University of Chicago press, 2007
2. Black's law dictionary, (7th ed. 1999).
3. Act on special cases concerning the punishment, etc. Of crimes of domestic violence, 2011 https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=28039&type=new&key
4. Irako, Keiko, and Koji Ono. “The Prevention of Spousal Violence and the Protection of Victims in Japan.” Int'l Surv. Fam. L. (2005).
https://www.gender.go.jp/policy/no_violence/e-vaw/law/pdf/sv.pdf
5. Domestic violence act (2021)
<https://law.moj.gov.tw/Eng/LawClass/LawAll.aspx?PCode=D0050071>
6. Milwertz, Cecilia (2003). “Activism Against Domestic Violence in the People's Republic of China”. Violence Against Women
7. Domestic Violence Law of the People's Republic of China
8. Zhao, Yuhong (2000). “Domestic Violence in China: In Search of Legal and Social Responses”. UCLA Pacific Basin Law Journal.
9. Act on special cases concerning the punishment, etc. Of crimes of domestic violence, 2011
10. Refugees, United Nations High Commissioner for. “Refworld | Korea, Republic of: Domestic violence, including legislation, availability of state protection and support services for victims”. Refworld. Retrieved 2019-06-07.
11. Nemoto, Keiko; Rodriguez, Rachel; Valhmu, Lucy Mkandawire (May 2006). “Exploring the Health Care Needs of Women in Abusive Relationships in Japan”. Health Care for Women International. doi:10.1080/07399330500511774. PMID 16595363. S2CID 275052
12. Cabinet Office, Gender Equality Bureau. “Violence against Women”
13. Penal code of Japan, 1907 <http://www.gender.go.jp/>
14. Criminal law of the People's Republic of China
15. Criminal code of South Korea,
https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG
16. Act on the Prevention of Domestic Violence, etc of Victims Thereof
<https://evaw-global-database.unwomen.org/-/media/files/un%20women/vaw/full%20text/asia/act%20on%20the%20prevention%20of%20domestic%20violence%20and%20the%20protection%20of%20its%20victims%20as%20amended%202006/republic%20of%20korea%20%20act%20on%20the%20>

prevention%20of%20domestic%20violence%20and%20protection%20etc%20of%20victims%20thereof.pdf?vs=2044

17. Prevention of Violence against Women Children and Support for the Victim Policy, 2015 Ministry of Gender Equality & Family. http://www.mogef.go.kr/eng/pc/eng_pc_f011.do

ХОЁР. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ХАРЬАЛАЛ

Судалгааг удирдсан:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D) С.Сүхбаатар
Эрдэм шинжилгээний ажилтан Б.Дүүрэнжаргал,
Дадлагажигч, МУИС ХЗС-ийн 5 дугаар курсын
оюутан Б.Батсүрэн

УДИРТГАЛ

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 2017 онд батлагдсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Зөрчлийн тухай хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны журмыг хуульчилсан байдаг. Тодруулбал, тус хуулийн 2.1 дүгээр зүйлд зөрчлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тодорхойлсон бөгөөд өдгөө эрүүгийн хэргийн шүүх болон захиргааны хэргийн шүүх нь зөрчлийн хэргийг харьяалан шийдвэрлэж байна.

Хууль батлагдахаас өмнө зөрчилд холбогдох харилцаа нь Захиргааны хариуцлагын тухай хууль /2002/-аар зохицуулагддаг байсан бөгөөд уг хуулиар зөрчил шалган шийдвэрлэхтэй холбогдох маргааныг шүүх иргэний байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэдэг байжээ.

Уг хууль нь захиргааны хэргийн шүүх байгуулагдахаас өмнө батлагдсан хууль байсан тул зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг харьяалан шийдвэрлэх тухай зохицуулалт нь өдгөө үйлчилж буй Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тодорхойлсон шиг нарийвчлан зохицуулагдаагүй байжээ.

2017 онд хууль батлагдсанаас хойш зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг захиргааны хэргийн шүүх болон эрүүгийн хэргийн шүүх хэрэгжүүлдэг болсон нь өмнөх хуультай харьцуулахад шүүхийн харьяаллыг нарийвчлан зохицуулах оролдлого хийсэн шинэлэг зохицуулалт мэт боловч хэргийн харьяаллын хувьд давхардал үүссэн байдал ажиглагдаж байна. Үүнээс үүдэн нэг төрлийн зөрчлийг өөр өөр албан тушаалтан шалган шийдвэрлэсэн тохиолдолд, тухайн зөрчлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал өөр байхаас гадна шүүхийн харьяаллаас хамаарч зөрчил хянан шийдвэрлэх журам нь ялгаатай байна.

Иймд уг судалгаагаар зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн харьяаллын талаарх асуудлыг судалж, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхийг зорилгоо.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Зөрчил шалган шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тодорхойлохын тулд зөрчлийн талаарх ойлголт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны онцлогийг судлах шаардлагатай байна. Учир нь зөрчил хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал нь тухайн зөрчлийг шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтнаас хамаарч тодорхойлогддог. Харин тухайн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн онцлогоос хамаардаг.

“Зөрчил гэдэг нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ” гэж Зөрчлийн тухай хуульд¹ тодорхойлжээ.

Харин судлаач С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг”²-т зөрчлийг (лат. Culpa levis; англ. Fault, misdemeanour, offence) эрх зүйн онол, захиргааны, хөдөлмөрийн эрх зүйд хууль тогтоомжийн дагуу захиргааны болон хөдөлмөрийн хариуцлага хүлээвэл зохих эрх зүйн зөрчлийг тэмдэглэсэн хам нэр томъёо; эдгээр нь гэмт хэргээс хамаагүй бага эрх зүйн зөрчил; зөрчилд захиргааны эрх зүйн зөрчил, иргэний эрх зүйн зөрчил, түүнчлэн сахилгын зөрчил хамаарагдана хэмээн тодорхойлжээ. Зөрчил хэмээх ойлголтыг нөгөө талаас эрх зүйн зөрчил хэмээн тайлбарласан байх бөгөөд Эрх зүйн зөрчлийг дараах байдлаар тодорхойлжээ.

“Өөрийнхөө зөрчлийг бие даан хариуцах чадвартай этгээдийн үйлдсэн гэм буруутай, эрх зүй зөрчсөн үйлийг эрх зүйн зөрчил гэнэ. Эрх зүйн зөрчлийн үндсэн шинж нь:

1. эрх зүй зөрчсөн – хууль зөрчсөн буюу эрх зүйн хэм хэмжээгээр хориглосон үйл;
2. хүний хүсэл зоригоор илэрсэн – эрх зүйн чадамжтай ба хэрэг хариуцах чадвартай этгээдийн үйл;
3. гэм буруутай.

Эрх зүйн зөрчлийг дараахь байдлаар ангилна:

1. гэмт хэрэг;
2. зөрчил:
 - a. захиргааны,
 - b. сахилгын,
 - c. иргэний хэмээн тодорхойлж ангилсан байна.

Эрх зүйн ном, сурах бичгүүдэд зөрчлийг эрүүгийн, захиргааны, иргэний хэмээн ангилдаг гэснээс үзвэл өнөөгийн зөрчлийн тухай хуульд тодорхойлсон зөрчил нь захиргааны зөрчилд хамаарахаар байх бөгөөд эрүүгийн зөрчлийг гэмт хэрэг хэмээн үзэж эрүүгийн эрх зүйгээр, иргэний зөрчлийг буюу деликтийг гэм хорын эрх зүйгээр тус тус зохицуулдаг байна.

Дээрхээс дүгнэвэл, Зөрчлийн тухай хуульд тодорхойлсон зөрчил нь гэмт хэргээс аюул багатай буюу Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий

1 Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, (2017)

2 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2021, Адмон, 166 дахь тал

агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.” хэмээн заасан гэмт хэрэгт тооцогдохгүй боловч хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд хамааруулан ойлгож болохоор байна. Гэмт хэрэг нь тухайн нийгэмд тогтсон ёс суртахуун, соёл иргэншилд аюултай байх нь нэн чухал байдаг ба энэхүү шинжээрээ бусад эрх зүйн зөрчлөөс ялгагдах ач холбогдолтой³ тул гэмт хэрэгт хамаарахгүй боловч хууль, хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл нь зөрчил байна.

Өмнө үйлчилж байсан захиргааны хариуцлагын тухай хуульд зөрчил хэмээн ерөнхийд нь тодорхойлох бус захиргааны зөрчил хэмээн тодорхойлдог байжээ. Тодруулбал, Захиргааны хариуцлагын тухай хууль /1992/-ийн гуравдугаар зүйлд захиргааны зөрчил гэж томъёолж “Монгол улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж үзнэ” хэмээн тодорхойлсон байжээ.⁴

1992 оны захиргааны хариуцлагын тухай хууль батлагдахаас өмнөх үеийн ном, сурах бичгийг үзэхэд мөн л захиргааны зөрчлийн тухай дурдсан байх ба захиргааны зөрчилд хүлээлгэх хариуцлагыг захиргааны хариуцлага хэмээн тодорхойлж байжээ.

“Төрийн удирдлагын явцад үүссэн нийгмийн харилцааг хөндөж уг харилцаанд нийтээр дагаж биелүүлбэл зохих журмыг зөрчсөн нийгмийн хор аюултай, гэм буруутай үйл явдлыг захиргааны эрх зөрчилт гэнэ.”⁵ Захиргааны эрх зөрчил гаргасан гэм буруутай хүнд захиргааны болон түүнийг төлөөлсөн эрх бүхий байгууллага албан тушаалтнаас хүлээлгэх хариуцлагыг захиргааны хариуцлага гэнэ.”⁶ гэснээс үзвэл захиргааны хариуцлага хүлээлгэдэг зөрчил нь захиргааны зөрчил байжээ.

Процессын хувьд захиргааны зөрчил нь гэмт хэргийн шинжтэй тохиолдолд эрүүгийн хэрэг мөн эсэхийг шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлдэг байсан бөгөөд зөрчил анх удаа үйлдсэн, зөрчил гаргагчийн хувийн зан төлөв зэргийг харгалзан шийтгэлээс чөлөөлөх, эсхүл тохирох шийтгэлийг оногдуулах зэрэг арга хэмжээг авдаг байжээ. Захиргааны зөрчил гаргасан этгээдэд эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэдэг байсан бөгөөд тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл ардын шүүх болон дээд шатны байгууллагад давж заалдах гомдлыг хуулиар тогтоосон хугацааны дотор гаргадаг байсан.⁷ Тухайн цаг үеийн нөхцөл байдал, шүүхийн тогтолцооноос хамаарч зөрчлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг ардын шүүх хэмээн тогтоосон ерөнхий зохицуулалт үйлчилж байжээ.

1992 оны Захиргааны хариуцлагын тухай хууль үйлчилж байх үед мөн л зөрчилд холбогдох маргааныг шүүх шийдвэрлэдэг байсан бөгөөд иргэний байцаан шийтгэх хуульд тогтоосон журмын дагуу буюу иргэний процессын журмаар зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэдэг байв.

3 Т.Золбоо, Эрүүгийн эрх зүй ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц, 2018, Соёмбо принтинг, 49 дэх тал.

4 Хууль зүйн үндэсний хүрээлэн, судалгааны тайлан, 2007, 388 дахь тал.

5 Чимид, БНМАУ-ын захиргааны эрх, 1973, Улсын хэвлэлийн газар, 329 дахь тал.

6 Мөн тэнд, 323 дахь тал.

7 Мөн тэнд, 346 дахь тал.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ШҮҮХИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Уг судалгаагаар зөрчлийн харьяаллыг шалган шийдвэрлэх шүүхийн харьяаллыг судлахыг зорьсон билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлд “шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно” хэмээн зааснаар өдгөө Монгол Улсад эрүү, иргэн, захиргааны шүүхүүд ажиллаж байна. ЗШШТХ-ийн 2.1 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хэргийн шүүх болон захиргааны хэргийн шүүх нь зөрчлийн хэргийг харьяалан шийдвэрлэхээр байх тул эрүүгийн хэргийн шүүх болон захиргааны хэргийн шүүхийн онцлогийг судлах шаардлагатай байна.

1. Эрүүгийн хэргийн шүүхийн онцлог

Эрүүгийн хэргийн шүүх гэдэг нь ЭХХШТХ-ийн 3.1 дүгээр зүйлд зааснаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх, гэм буруутай бол түүнд эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.⁸ Эрүүгийн хэргийн шүүхийн зорилго нь гэмт хэрэгт шалгагдаж буй этгээд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх, хэрэв буруутай бол түүнд зохих ял шийтгэлийг ногдуулах явдал байдаг.⁹ Тодруулбал, эрүүгийн хэргийн шүүхийн онцлогийг эрүүгийн хэргийн хариуцлагын үндсэн зорилгоор тодорхойлж болно. Эрүүгийн хариуцлагын үндсэн зорилго нь Кантын тодорхойлсон “Нийтийн эрх ашиг”-ийг хамгаалах, төлөөлөх, хууль зөрчсөн этгээдийг хорих, шийтгэх онцлогтой байдаг.¹⁰ Өөрөөр хэлбэл, Эрүүгийн шүүхийн үндсэн онцлог нь субъектив гэм буруугийн асуудлыг чухалчлан шалгадагт оршиж байна.

2. Захиргааны хэргийн шүүхийн онцлог

Захиргааны хэргийн шүүх бол нийтийн эрх зүйн субъект болох захиргааны байгууллага, албан тушаалтны хууль дээдлэн бэхжүүлж, хүний эрхийг хангаж байгаа эсэхийг иргэд, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр шалгаж, тэдгээр байгууллага, албан тушаалтны хууль бус акт, дур зоргын үйл ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох зорилготой эрх мэдэл бүхий дагнасан шүүх юм.¹¹

Шүүхийн ач холбогдол нь нийгмийн чиг үүргээрээ тодорхойлогдоно. Товчхондоо хүний эрхийг захиргааны байгууллагын дур зоргын ажиллагаанаас хамгаална.¹² Захиргааны үйл ажиллагаанд хуулийг сахин хангуулна. Төрийн нэрийн өмнөөс гэмтнийг гэсгээн цээрлүүлэх, хоёр иргэний хоорондын маргааныг шийдэх уламжлалт шүүх ажиллагаанаас хальж засаг, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан гажуудлыг иргэн хүний эрх, ашиг сонирхолын үүднээс шүүн тунгааж зөрчигдсөн эрхийг нь сэргээх өөр чиглэлтэй байгаад захиргааны шүүхийн онцлог оршиж байгаа юм.¹³

8 Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, “Төрийн мэдээлэл”, 2017 он, №23.

9 Т.Мөнх-Эрдэнэ, Х.Баттулга, Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга) болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмж., 4 дэх тал, <http://legaldata.mn/b/177>. 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр хандав.

10 С.Асланбек, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба прокурорын хяналт, 4 дэх тал, <http://legaldata.mn/b/804>. 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр хандав.

11 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, (УБ, 2017), 305 дахь тал.

12 Б. Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, УБ хот, 2004 он, 162 дахь тал.

13 Мөн тэнд, 161 дэх тал.

Мөн захиргааны хэргийн шүүхийн бас нэгэн онцлог нь эрх зүйн түр хамгаалалтыг хэрэгжүүлэх нь ЗХШ-ийн чиг үүрэгт хамаарах бөгөөд уг ажиллагаа нь ЗХШ-ийн мөн чанар, хуулиар хүлээсэн үүрэгтэй нийцдэг. Эрх зүйн түр хамгаалалт нь маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх болон эс түдгэлзүүлэх үндэслэл, журмаар дамжин хэрэгжинэ.¹⁴


Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14/-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ..., хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

14 А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ хот, 2014 он, 268 дахь тал,

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ХАРЬАЛАЛ

Зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг юм. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь ЗШШТХ-д зааснаар зөрчлийн хэрэг бүртгэл, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ. Уг тодорхойлолтоос үзвэл зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатыг дараах байдлаар ойлгож болох юм.

Бүдүүвч 1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үе шат



Зөрчлийг эрүүгийн хэргийн шүүх болон захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоосон байна. Ийнхүү шүүхийн харьяаллыг тогтоохдоо зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаар нь ангилсан ба дараах байдлаар байна.

Хүснэгт 1. Зөрчил шалган шийдвэрлэх шүүхийн харьяалал

№	Эрүүгийн хэргийн шүүх	№	Захиргааны хэргийн шүүх
1	6.1.консулын эрх бүхий албан тушаалтан	1	6.7.гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч
2	6.2.хилийн төлөөлөгч, орлогч, туслагч	2	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч
3	6.3.төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан	3	6.11.гаалийн улсын байцаагч
4	6.4.аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга	4	6.12.татварын улсын байцаагч
5	6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	5	6.14.оюуны өмчийн улсын байцаагч
6	6.6.олон нийтийн цагдаа	6	6.15.нийгмийн даатгалын байцаагч
7	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	7	6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч
8	6.9.ахлах шийдвэр гүйцэтгэгч	8	6.17.гал түймрийн улсын хяналтын байцаагч
9	6.13.гадаадын иргэний хяналтын улсын байцаагч	9	6.18.Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч
10	6.26.хүүхдийн эрхийн улсын байцаагч	10	6.19.Монголбанкны хянан шалгагч
11	6.29.хорих ангийн эрх бүхий албан тушаалтан	11	6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
12	6.30.Авлигатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан	12	6.21.архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч
		13	6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч
		14	6.23.статистикийн улсын байцаагч
		15	6.24.нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч
		16	6.25.төмөр замын тээврийн улсын байцаагч
		17	6.27.улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
		18	6.28.Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч
		19	6.31.санхүүгийн мэдээллийн улсын байцаагч

Дээрх хүснэгтээс үзэхэд, консулын эрх бүхий албан тушаалтан, олон нийтийн цагдаа, хилийн төлөөлөгч зэрэг эрх бүхий 12 төрлийн албан тушаалтны шийдвэрлэсэн хэргийг ЭХШ харьяалан шийдвэрлэдэг бол мэргэжлийн хяналтын улсын байцаагч, татварын улсын байцаагч, гаалийн байцаагч зэрэг эрх бүхий 19 төрлийн албан тушаалтны шалган шийдвэрлэсэн хэргийг ЗХШ харьяалан шийдвэрлэдэг байна.

ЭХШ болон ЗХШ-ээр зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх журмыг ЗШШТХ болон ЗХШХШТХ мөн ЭХХШТХ-д тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл шүүхийн харьяалал ямар байхаас хамаарч тухайн зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх журам нь ялгаатай байна. Тодруулбал ЭХШ болох ЗХШ-ийн алинд нь харьяалагдахаас хамаарч зөрчлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны гомдол гаргах болон гомдлыг шийдвэрлэх журам, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, давж заалдах боломж нь дараах байдлаар байна.¹⁵

Хүснэгт 2. Шүүхээр зөрчил хянан шийдвэрлэх журам

	Эрүүгийн хэргийн шүүх	Захиргааны хэргийн шүүх
Гомдол гаргах журам	Шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Эрүүгийн хэргийн шүүхэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана. Гомдол гаргахад УТХ төлөхгүй.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана: - Хуульд тусгайлан заасан бол УША хийгдсэн байхыг шаардана. - Гомдол гаргахад УТХ төлнө.
Гомдлыг шийдвэрлэх журам	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг журмыг удирдлага болгоно.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.
Хугацаа	Дүгнэлт, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ. /ЗШШТХ-ийн 8 дугаар бүлэг/	Энэ төрлийн маргааныг захиргааны хэргийн анхан шатны шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. /ЗХШХШТХ-ийн 112 дугаар зүйл/
Давж заалдах	Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна. /ЗШШТХ-д зааснаар/	Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй /ЗХШХШТХ-д зааснаар/

Зөрчлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн харьяаллаас хамаарч дээрх байдлаар ялгаатай байгаа учраас ийнхүү хуульчилсны үр дагаврыг үнэлэх, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг судлахын тулд зөрчил хянан шийдвэрлэж буй шүүхийн онцлог нь ЗШША-тай уялдаж байгаа эсэхийг цааш дэлгэрүүлэн судлая.

¹⁵ Монгол улсын зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /Сургагч багш нарт зориулсан гарын авлага/, ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 2017, 98 дахь тал.

1. Эрүүгийн хэргийн шүүх зөрчил шалган шийдвэрлэх нь

Эрүүгийн хэргийн шүүхээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан ЗШША-ны харьяалал, 2.1 дүгээр зүйлд заасан зөрчил хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал зэрэг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байна.

Эрүүгийн хэргийн шүүх зөрчлийг хянан шийдвэрлэхдээ ЗШШТХ-ийн наймдугаар бүлэгт тодорхойлсон журмын дагуу хянан шийдвэрлэх бөгөөд тухайн зохицуулалтаас гадна ЭХШХШТХ-д заасан нийтлэг журмыг удирдлага болгоно.

Судалгааны явцад зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн хэргийн шүүхийн хэрэгжүүлэх чиг үүргийг эрх зүйн зохицуулалтаар нь хүснэгт хэлбэрт орууллаа.

Хүснэгт 3. Эрүүгийн хэргийн шүүхийн чиг үүрэг

Чиг үүрэг		Эрүүгийн хэргийн шүүх	Эрх зүйн зохицуулалт
1	Хуульд заасан зөрчлийг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх	Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл, 8.6, 8.7, 10.5 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна	ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэг
2	Хуульд заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.13, 6.26, 6.29, 6.30 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр анхан шатны журмаар, оролцогчийн гомдол, прокурорын эсэргүүцлээр давж заалдах шатны журмаар зөрчил хянан шийдвэрлэнэ.	З Ш Ш Т Х - ийн 2.1, 7.6 дугаар зүйл
3	Хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр шийтгэл оногдуулсан шийдвэрийг ШШГ-ийн журмаар албадан гүйцэтгүүлэх эсэхийг шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчлийг харьяаллын дагуу, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.13, 6.26, 6.29, 6.30 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу	ЗШШТХ-ийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэг
4	Эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Зөрчлийн тухай хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээ оногдуулах эсэхийг шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчлийг харьяаллын дагуу, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.13, 6.26, 6.29, 6.30 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг /зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах/, 4.4 дүгээр зүйлд /албадан эмчлэх/ тус тус заасан албадлагын арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг
5	Саатуулах, эрх хязгаарлах арга хэмжээ авах	гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол эрүүгийн хэргийн шүүх тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг саатуулах эсэхийг шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 5.2 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэг

Эрүүгийн хэргийн шүүх нь субъектив гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх онцлогтой, гэм буруутай этгээдэд тохирох хариуцлагыг оногдуулах чиг үүрэгтэй байдаг тул зөрчлийн хэргийг харьяалан шийдвэрлэх нь нэг талаараа зохистой байж болох юм. Гэхдээ шүүхийн харьяаллыг ЗШШТХ-д тогтоохдоо тухайн зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэсэн албан тушаалтнаас нь хамааруулж, консулын эрх бүхий албан тушаалтан, хилийн төлөөлөгч, орлогч, туслагч, төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга, тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан, олон нийтийн цагдаа, цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хорих ангийн эрх бүхий албан тушаалтан, Авлигатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан нарын шийдвэрт гомдол гаргаж буй тохиолдолд эрүүгийн хэргийн шүүхэд хандахаар хуульчилсан нь учир дутагдалтай байх магадлалтай. Шүүхийн статистик болон прокурорын байгууллагын статистик мэдээллийг харвал зөрчлийн хэргийг зөвхөн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн тухай мэдээлэл байх бөгөөд 2021 оны эхний хагас жилийн байдлаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан хэргийн 97.1 /737673 хэрэг/ хувийг цагдаагийн байгууллага шийдвэрлэсэн байна.¹⁶ Харин цагдаагийн байгууллагын шийдвэрлэсэн зөрчлийн талаарх тоо баримтыг авч үзвэл 2021 оны эхний хагас жилийн байдлаар 731604 зөрчил шийдвэрлэснээс, ердийн журмаар шийдвэрлэсэн 670436 зөрчил, Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шалгасан 61168 зөрчил байна.¹⁷ Эдгээр тоон мэдээллийг харахад хоорондоо зөрүүтэй байдлаар байгаа нь учир дутагдалтай байна.

2. Захиргааны хэргийн шүүх зөрчил шалган шийдвэрлэх нь

Захиргааны зөрчил гаргасан тухай буюу зөрчилтэй хэргийг шийдвэрлэх явдал бол захиргааны хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг мөн.¹⁸ Захиргааны зөрчилтэй хэрэг шийдвэрлэх ажиллагааны явцад үүссэн харилцаа бол захиргааны процессын эрхийн харилцааны өвөрмөц хэсэг юм.¹⁹

Захиргааны хэргийн шүүхээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан ЗШША-ны харьяалал, 2.1 дүгээр зүйлд заасан зөрчил хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал зэрэг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байна.

Захиргааны хэргийн шүүхээс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн зарчим зохицуулалтын тухайд:

1. Манай улсын хувьд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмыг анх 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын 18 дугаар хуралдаанаар баталсан “Цагдан цээрлүүлснийг зөрчигсөдийг яллах хууль”-иар тогтоож байсан уламжлалтай.²⁰

16 Прокурорын байгууллагын статистик, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналтын ажлын тоон мэдээ, <http://prokuror.mn/blog/ME/4298>.

17 ЦЕГ-аас гаргасан статистик мэдээлэл, <https://information.police.gov.mn/resource/information/File/2021/07/05/sr1mq1b21m8jes6r/2021.06%20sar%20medee-Zurchil.sait.pdf>.

18 Б.Чимид, БНМАУ-ын захиргааны эрх, 1973, Улсын хэвлэлийн газар, 342 дахь тал.

19 Мөн тэнд, 339 дахь тал.

20 Ж.Долгосүрэн, Монгол Улсын захиргааны эрх зүй, УБ, 2000. 328 дахь тал.

2. Үүний дараа 1936 онд “Цагдан сэргийлэх байгууллагаас аливаа торгууль ногдуулах ба хураах журам”-ыг Засгийн газраас, 1952 онд “БНМАУ-ын аймаг, хот, сум, хороодын хөдөлмөрчдийн депутатуудын хурлууд ба тэдгээрийн гүйцэтгэх захиргаадаас заавал биелүүлэх шийдвэр гаргах, зөрчвөл захиргааны журмаар арга хэмжээ авах дүрэм”-ийг Сайд нарын зөвлөлийн тогтоолоор, 1973 онд “БНМАУ-ын сум, район, хороо, орон нутгийн хотын АДТ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх захиргааны комиссын дүрэм”-ийг Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар тус тус батлан мөрдүүлж байсан тухай доктор Д. Дашцэдэн “Монгол Улсын захиргааны эрх зүй” сурах бичигтээ тэмдэглэж үлдээжээ.²¹
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө мөрдөгдөж байсан Захиргааны хариуцлагын тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмыг тодорхойлж байсан байна.

2017 оны 07 дугаар сарын 01-нээс хүчин төгөлдөр болон мөрдөгдөж буй Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт Захиргааны хэргийн шүүх нь зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч байхаар заасан ба тус хуулийн зохицуулалтын дагуу захиргааны хэргийн бүх шатны шүүхүүд нь зөрчилд шийтгэл ногдуулах эсэхийг шийдвэрлэх чиг үүрэгтэй бол захиргааны хэргийн анхан шатны шүүх нь:

1. Эрх бүхий албан тушаалтнаас тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх эсэхийг шийдвэрлэх;
2. Эрх бүхий албан тушаалтны шийтгэл ногдуулсан болон шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг оролцогчдийн гомдол болон прокурорын дүгнэлтээр хянаана.
3. Зөрчилд шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 8-д “Иргэний болон захиргааны хэргийн шүүхээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд тухайн шүүх шийтгэл оногдуулна” гэж заасан.²²

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн найм болон есдүгээр бүлэгт эрүүгийн хэргийн шүүхийн зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, түүний хугацаа, шүүхээс гарах шийдвэр, түүнд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх арга хэлбэр зэрэг процессыг зохицуулсан боловч эдгээр ажиллагаа нь захиргааны хэргийн шүүхийн хувьд хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна.²³

Хуулийн бүтцийг авч үзвэл, “Эрүүгийн хэргийн шүүхийн зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа” гэсэн нэртэй бүлэгт хамаарах зохицуулалтыг захиргааны хэргийн шүүх удирдлага болгох боломжгүй.²⁴

21 Ц.Мөнхзул, Захиргааны хэргийн шүүхээс Зөрчил хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн зарим асуудал, Монголын төр эрх зүй сэтгүүл. УБ. 2020 №2 (95), 59 дэх тал.

22 Ц.Мөнхзул, Захиргааны хэргийн шүүхээс Зөрчил хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн зарим асуудал, Монголын төр эрх зүй сэтгүүл. УБ. 2020 №2 (95), 59 дэх тал.

23 Мөн тэнд.

24 Мөн тэнд.

Мөн захиргааны хэргийн шүүхэд эрх бүхий албан тушаалтны шийтгэл ногдуулсан болон шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг оролцогчийн гомдол болон прокурорын дүгнэлтээр хянах процессыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хэрэгжихээр зааснаас үүдэн тус эрх бүхий албан тушаалтны шийдвэрт үндсэндээ 5 удаа, тодруулбал, захиргааны хэргийн анхан шатны шүүхэд, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид тус тус гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломж бүрдсэн, энэ нь шүүхийн ажлын ачааллыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байна.²⁵

Хүснэгт 4. Захиргааны хэргийн шүүхийн чиг үүрэг

Чиг үүрэг		Эрүүг Захиргааны хэргийн шүүх	Эрх зүйн зохицуулалт
1	Хуульд заасан зөрчлийг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх	Хэрэг маргаан хянан шийдвэрлэх явцад Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.32 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд тухайн шүүх шийтгэл оногдуулна.	ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 8 дахь хэсэг
2	Хуульд заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэх	Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27, 6.28, 6.31 дэх заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.	ЗШШТХ-ийн 2.1 зүйлийн 2.1.2 дэхь хэсэг 7.6. д у г а р з ү й л и й н 7.6.2 дахь хэсэг
3	Хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр шийтгэл оногдуулсан шийдвэрийг ШШГ-ийн журмаар албадан гүйцэтгүүлэх эсэхийг шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27, 6.28, 6.31 дэх заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу	ЗШШТХ-ийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэг
4	Эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Зөрчлийн тухай хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээ оногдуулах эсэхийг шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27, 6.28, 6.31 дэх заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг /зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах/, 4.4 дүгээр зүйлд /албадан эмчлэх/ тус тус заасан албадлагын арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх	ЗШШТХ-ийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

Эрх зүйт төрийн суурь зарчмаар бол захиргааны байгууллагын шийдвэрийг захиргааны хэргийн шүүхээс хянан шийдвэрлэх; эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хор хэмжээ нь эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг нь гэмт хэрэгт тооцогдохгүй зөрчилд өөрөөр хэлбэл зөрчлийн тухай хуульд заасан эрүүгийн шинжтэй зөрчлийг эрүүгийн хэргийн шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд бүрэн нийцэх учиртай.

25 Мөн тэнд.

Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуульд заасан захиргааны эрх зүйн шинжтэй зөрчлийг захиргааны хэргийн шүүх, эрүүгийн эрх зүйн шинжтэй зөрчлийг эрүүгийн хэргийн шүүхэд харьяалуулан шийдвэрлэх нь ёстой.

Гэвч Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн зохицуулалтаас үзвэл нэг төрлийн зөрчлийг хоёр өөр төрлийн албан тушаалтан шалган шийдвэрлэх эрхтэй байх бөгөөд ямар албан тушаалтан шалган шийдвэрлэснээс хамаараад тухайн зөрчлийн хэрэг нь эрүүгийн хэргийн шүүх эсвэл захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах боломжтой байна. Үүнээс нэг төрлийн зөрчилд хоёр өөр төрлийн шалган шийдвэрлэх ажиллагаа явагдах үр дагавартай байна. Мөн эрүүгийн эрх зүйн харилцаанд хамаарахгүй байж болохуйц зөрчлийн хэргийг эрүүгийн хэргийн шүүхэд харьяалуулан шийдвэрлэх үр дагавартай /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/. Эсрэгээрээ мөн эрүүгийн эрх зүйн харилцаанд хамаарч болохуйц зөрчлийн хэргийн эрүүгийн хэргийн шүүхэд харьяалуулсан харагддаг. Тодруулбал, ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 8-д заасны даагуу захиргааны хэргийн шүүхд ЗТХ-ийн 15.4-д заасан “Шүүгчийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдсон, эсхүл шүүх, шүүгчийн аюулгүй байдлын журам зөрчих” буюу шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхийг оролдох зөрчлийг харьяалуулан шийдвэрлэхээр заасан.

Захиргааны хэргийн шүүхийн хяналтын объект нь хууль тогтоомжоор эрх олгогдсон захиргааны байгууллагын зөвхөн нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр, үйл ажиллагаа байдаг. Иймд захиргааны хэргийн шүүхээс шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэхээр заасан шүүгчийн хараат бус байдал нөлөөлөхийг оролдох зөрчлийн субъект нь заавал хэргийн эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байхыг шаардахгүй дурын этгээд байх боломжтойн дээр субъектив талын элемент нь гэм буруугийн санаатай хэлбэрээр илэрч байх тул энэхүү зөрчлийг хянан шийдвэрлэх эрх хэмжээ тухайн шүүгчийн харьяалагдаж буй шүүхэд бус эрүүгийн хэргийн шүүхийн харьяалалд байх нь илүү оновчтой байх тухай Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Мөнхзул, “Захиргааны хэргийн шүүхээс зөрчил хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн зарим асуудал” эрдэм шинжилгээний өгүүлэлдээ дурдсан байдаг.

3. Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаан дахь харьяаллын давхардал

Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоохдоо ЗШШТХ-ийн 2.1 дүгээр зүйлд зааснаар хэргийг шалган шийдвэрлэх албан тушаалтнаас нь хамааруулсан байна. Харин зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд хамаарах зөрчлийг ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлд тусгасан. Ийнхүү хэргийг шалган шийдвэрлэх албан тушаалтанд зөрчлийг харьяалуулахдаа хэд хэдэн албан тушаалтанд тухайн зөрчлийг шалгах эрх олгосон буюу харьяаллын давхардал үүссэн байна. Тодруулбал, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан дараах зөрчлүүдэд шүүхийн харьяаллын давхардал үүссэн байна.

5 дугаар бүлэг:

5.6 дугаар зүйл /Хууль бусаар зэвсэг эзэмших/,

5.10 дугаар зүйл /Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих/,

- 5.11 дүгээр зүйл /Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих/,
- 5.12 дугаар зүйл /Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих/,
- 5.13 дугаар зүйл /Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих/,
- 5.18 дугаар зүйл /Онц байдлын тухай хууль зөрчих/,
- 6 дугаар бүлэг:
- 6.5 дугаар зүйл /Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих/,
- 6.6 дугаар зүйл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих/,
- 6.10 дугаар зүйл /Донорын тухай хууль зөрчих/,
- 6.18 дугаар зүйл /Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих/,
- 6.20 дугаар зүйл /Хүүхдийн эрхийг зөрчих/,
- 6.24 дүгээр зүйл /Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх/,
- 6.26 дугаар зүйл /Бэлгийн дарамт учруулах/,
- 7 дугаар бүлэг:
- 7.3 дугаар зүйл /Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих/,
- 7.15 дугаар зүйл /Усны тухай хууль зөрчих/,
- 10 дугаар бүлэг:
- 10.8 дугаар зүйл /Аж ахуйн үйл ажиллагааны нууцад халдах/,
- 11 дүгээр бүлэг:
- 11.7 дугаар зүйл /Төрийн бус байгууллагын тухай хууль зөрчих/,
- 11.15 дугаар зүйл /Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих/,
- 11.29 дүгээр зүйл /Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих/,
- 13 дугаар бүлэг:
- 13.5 дугаар зүйл /Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх журам зөрчих/,
- 14 дүгээр бүлэг:
- 14.1 дүгээр зүйл /Харилцаа холбооны тухай хууль зөрчих/,
- 14.3 дугаар зүйл /Шуудангийн тухай хууль зөрчих/,
- 14.4 дүгээр зүйл /Авто замын тухай хууль зөрчих/,
- 14.5 дугаар зүйл /Авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах/,
- 14.6 дугаар зүйл /Автотээврийн тухай хууль зөрчих/,
- 16 дугаар бүлэг:
- 16.1 дүгээр зүйл /Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих/,
- 16.4 дүгээр зүйл /Чөлөөт бүсийн тухай хууль зөрчих/

Дээр дурдсан зөрчлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоохдоо шалган шийдвэрлэсэн албан тушаалтнаас хамааран тухайн зөрчлийг шийдвэрлэх шүүхийн харьяаллын давхардлыг үүсгэж байна.


Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 10.8 дугаар зүйлд тусгасан “Аж ахуйн үйл ажиллагааны нууцад халдах” зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нь ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дугаар зүйлд зааснаар цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, 6.16 дугаар зүйлд зааснаар шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч нар байна. Дээрх албан тушаалтнуудын шүүхийн харьяалал нь өөр өөр буюу цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шалгасан зөрчлийн хэргийг ЭХШ, шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын байцаагчийн шалгасан зөрчлийн хэргийг ЗХШ хянан шийдвэрлэхээр байна. Үүнээс үүдэн хэрэг хянан шийдвэрлэж буй шүүхээс хамаарч тухайн зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх журам нь өөр байна. Өөрөөр хэлбэл, зөрчил шалган шийдвэрлэсэн албан тушаалтнаас хамаарч ижил төрлийн зөрчлийн хэргийг шүүхээр шийдвэрлэх журам ялгаатайгаар хуульчилснаас үүдэн Монгол Улсын үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд тусгасан хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 10.8 дугаар зүйлд зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллага, банк, санхүүгийн үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээ, баримтыг хариуцсан ажилтан, албан тушаалтан, эсхүл хууль ёсны дагуу танилцсан этгээд, эсхүл уг мэдээ, баримтыг хууль бусаар олж авсан этгээд ашигласан, эсхүл бусдад тараасан, задруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” хэмээн зөрчлийг тодорхойлж хариуцлага хүлээлгэхээр заасан.

Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж, байгууллага, банк, санхүүгийн үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээ, баримтыг ашигласан, эсхүл бусдад тараасан, задруулсан үйлдлийг хийснээрээ зөрчил үйлдсэнд тооцогдох эрх зүйн үр дагавар үүсэхээр байна.

Хэрвээ Иргэн “А” нь дээр дурдсан зөрчлийг үйлдсэн тохиолдолд Зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтнаас хамааран иргэн “А”-ын үйлдсэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны шүүхийн харьяалал ялгаатай байх бөгөөд үүнээс үүсэх үр дагавар, тэдгээрийн ялгаатай байдлын талаар дараах схемээр авч үзье.

Бүдүүвч 2. Зөрчил хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын давхардал



4. Зөрчил шалган шийдвэрлэсэн шүүхийн статистик

Зөрчлийн хэргийг эрүүгийн болон захиргааны хэргийн шүүх нь хэрхэн харьяалан шийдвэрлэх тухай эрх зүйн хэм хэмжээ болон онолын үзэл баримтлал, судлаачдын байр суурийг өмнөх хэсэгт авч үзсэн билээ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар шүүхийн практикийг судлахын тулд 2021 оны эхний хагас жилийн статистик²⁶ мэдээлэлтэй танилцлаа.

26 Монгол Улсын шүүхийн 2021 оны эхний хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, https://www.judcouncil.mn/site/news_full/11367.

Анхан шатны шүүхийн статистик мэдээлэл

Анхан шатны шүүх 2021 оны эхний хагас жилд эрүүгийн 5824 хэрэг, иргэний 20602 хэрэг, захиргааны 864 хэрэг нийт 27290 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, 10999 зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулж, 782 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох болон ялаас чөлөөлж, 639 хүнд цагдан хорих арга хэмжээ авч, 972 хүний цагдан хорих хугацаа сунгажээ.


График 1. Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг



Давж заалдах шатны шүүхийн статистик мэдээлэл

Давж заалдах шатны шүүх 2021 оны хагас жилд эрүүгийн 1113, зөрчлийн 288 хэрэг, иргэний 1383, захиргааны 660 хэрэг, нийт 3444 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэжээ.

График 2. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг




Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс нийт 252 зөрчлийн хэргийг хүлээн авснаас 228 зөрчлийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэж 114 зөрчлийн хэрэгт буюу 50.0 хувьд нь анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрийг хэвээр үлдээж, 59 зөрчлийн хэрэгт буюу 25.6 хувьд нь өөрчлөлт оруулж, 55 зөрчлийн хэрэгт буюу 24.1 хувьд нь хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 60 зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд 32 зөрчлийн хэргийг хэвээр үлдээж, 18 зөрчлийн хэрэгт өөрчлөлт оруулж, 10 зөрчлийн хэргийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэсэн статистик


Шүүхийн тайланд тусгагдсан статистикийн мэдээлэлд захиргааны хэргийн шүүхээр зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн талаар тусгасан байх боловч хангалттай тодорхой мэдээлэл байгаагүй тул шүүхийн шийдвэрийн цахим сан дахь шийтгэлийн хуудастай холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 96 шийдвэрүүдийг гомдол гаргагч болон хариуцагчаар ангилвал:

График 3. ЗХАШШ-д зөрчлийн хэргээр гомдол гаргасан байдал



Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох гомдлын шаардлага бүхий 96 хэргээс 31 хэрэгт буюу 32 хувь нь иргэн, 61 буюу 64 хувь нь хуулийн этгээдийн гаргасан гомдлоор үүссэн байсан бол прокурорын дүгнэлтээр 4 хэрэг буюу 4 хувь нь захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

ЗХАШШ-ийн шийдвэрүүдээс үзэхэд хариуцагчаар татварын байцаагч оролцсон маргаан 44,47 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна.

График 4. ЗХАШШ-д зөрчлийн хэрэгт хариуцагчаар татагдсан байдал

Эдгээрийн тоон мэдээллийг хүснэгтээр үзвэл:

Д/д	Хэрэгт оролцогч эрх бүхий албан тушаалтны нэр	Хамаарах шийдвэрийн тоо
1	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч	15
2	Татварын улсын байцаагч	44
3	НББ-ийн улсын байцаагч	16
4	Монгол банкны улсын байцаагч	6
5	ШӨХТГ-ын улсын байцаагч	6
6	Оюуны өмчийн улсын байцаагч	2
7	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	3
8	Гал түймрийн улсын байцаагч	3
9	Улсын бүртгэлийн улсын байцаагч	1

Зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулаагүйгээс үүдэн эрүүгийн хэргийн шүүх болон захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргааны талаарх тоо баримт цуглуулах, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байлаа. Цаашид эдгээр шүүхийн харьяалан шийдвэрлэсэн хэргүүдийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим санд төвлөрүүлснээр хэргийн шийдвэрлэлт, ач холбогдол, шүүхийн харьяаллын талаар дүгнэхэд тустай байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Уг бүлгээр манай улстай ижил Эх газрын эрх зүйн бүлд хамаарах эрх зүйн тогтолцоотой орон болох Бүгд найрамдах Болгар улс, ХБНГУ болон ОХУ-ыг сонгон тэдгээрийн зөрчлийн талаарх зохицуулалтыг харьцуулан судлахыг зорилоо.

1. Бүгд Найрамдах Болгар улсын эрх зүйн зохицуулалт

Захиргааны зөрчилтэй холбогдсон харилцааг 1969 онд батлагдсан Захиргааны зөрчил ба хариуцлагын тухай хуулиар (Law for Administrative offences and sanctions)²⁷ зохицуулдаг бөгөөд уг хуулийн 6 дугаар зүйлд зааснаар “Захиргааны зөрчил гэж захиргааны эрх зүйн хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан захиргааны байгууллагын шийдвэрийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ” хэмээн тодорхойлжээ. Захиргааны зөрчилд хариуцлага тооцохдоо зөрчлийн хэрэг үүсгэсний дараа прокурорт хүргүүлнэ (Art 33). Зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх албан тушаалтнууд нь тухайн хуулийн 47 дугаар зүйлд зааснаар тодорхойлогдох бөгөөд эдгээрт захиргааны байгууллага, нутгийн удирдлагын байгууллагын удирдах албан тушаалтан, холбогдох хууль тогтоомжид зааснаар эрх олгогдсон албан тушаалтан, шүүх болон прокурор гэх мэт байгууллагын гэх мэт албан тушаалтан хамаарч байна. Тус хуулийн 59 дүгээр зүйлд зөрчилд хариуцлага тооцсон шийдвэрт гомдол гаргах эрхийг хуульчилжээ. Зөрчлийн хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх нь захиргааны хэргийн анхан шатны шүүх байх бөгөөд Захиргааны хэргийн дээд шатны шүүхийн шийдвэр нь эцсийнх байна (regional court – district court- Supreme Administrative court).

2. ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-д зөрчлийг захиргааны зөрчил хэмээн тодорхойлсон бөгөөд Захиргааны зөрчлийн тухай хууль (Act on Regulatory Offences, Gesetz über Ordnungswidrigkeiten)²⁸-аар зохицуулах бөгөөд тус хуульд зааснаар зөрчил гэдэг нь “Хуульд хариуцлага хүлээлгэхээр тогтоосон хууль бус, гэм буруутай үйлдлийг хэлнэ.” хэмээн тодорхойлсон байна.

Шүүхийн тогтолцооны хувьд ХБНГУ-д ердийн болон тусгай шүүх хэмээн ангилдаг. Ердийн шүүх нь иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэдэг бол тусгай шүүхэд захиргааны, татварын, хөдөлмөрийн, нийгмийн шүүхүүд хамаардаг.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн шүүхийн оролцоо байдаг ч зорилго, материаллаг болон процессын хууль, зарчим, эрх зүйн үр дагавраар эрүүгийн эрх зүйгээс асар том ялгаатай байна.²⁹ Зөрчлийг шалгахдаа Захиргааны зөрчлийн тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулах бөгөөд цагдаагийн байгууллага зөвхөн эрүүгийн зөрчил буюу гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг. Хэрвээ цагдаагийн байгууллага захиргааны зөрчлийг илрүүлсэн тохиолдолд шийдвэр гаргах эрх

27 “Law for the administrative offences and sanctions” <https://www.refworld.org/cgi-bin/texis/vtx/rwmain/opendocpdf.pdf?reldoc=y&docid=52848b4c4>.

28 Act on Regulatory offences https://www.gesetze-im-internet.de/englisch_owig/englisch_owig.pdf.

29 С.Асланбек, “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба прокурорын хяналт”, <https://legaldata.mn/buteel/pdf?id=804>.

бүхий албан тушаалтанд шилжүүлдэг байна.³⁰ Зөрчилд хариуцлага оногдуулсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхэд хандах эрх нээлттэй байх бөгөөд ХБНГУ-ын Зөрчлийн тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаар шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд хандах бөгөөд 68 дугаар зүйлд зааснаар орон нутгийн шүүх буюу Local court нь тухайн хэргийг харьяалан шийдвэрлэнэ /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан журмыг баримтална/.

3. ОХУ-ын эрх зүйн зохицуулалт

ОХУ-ын зөрчлийн тухай хууль (Code of Administrative offences of the Russian Federation, Кодекс российской федерации Об административных правонарушениях)-д захиргааны зөрчлийг тодорхойлсон байх бөгөөд захиргааны зөрчил гэдэг нь тус хууль болон бусад хуульд захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан хүн, хуулийн этгээдийн гэм буруутай, хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.³¹ ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 28.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 86 эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхээр заажээ. Энэ нь манай улсын зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны харьяалалтай төстэй байдлаар хуульчлагдсан байна. Зөрчилд хариуцлага ногдуулсан талаарх шийдвэрийг давж заалдах эрхийг мөн хуульчилсан бөгөөд ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 30.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгчийн шийдвэрт давж заалдах шатны шүүхэд, хамтын байгууллага (коллегиальный орган)-аас гаргасан шийдвэрт тухайн байгууллагын оршин байгаа газрын шүүхэд³², захиргааны шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны дээд шатны харьяалан удирдах албан тушаалтанд, бусад байгууллага шийдвэрлэсэн тохиолдолд хуульд зааснаар дүүргийн шүүхэд тус тус харьяалан шийдвэрлүүлэхээр заажээ.

30 Захиргааны зөрчлийн тухай хууль "Gesetz über Ordnungswidrigkeiten", 53 дугаар зүйл.

31 ОХУ-ын Захиргааны хариуцлагын тухай хууль, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/.

32 Нутаг дэвсгэрийн харьяаллаар тухайн байгууллагын оршин байгаа газрын шүүхэд нэхэмжлэл гаргана хэмээн хуульчилжээ.

ДҮГНЭЛТ

Өдгөө хэрэгжиж буй зөрчлийн тухай хуулийн зохицуулалт болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтад дүгнэлт хийвэл:

1. ЗШШТХ-ийн 2.1 дүгээр зүйлд зааснаар албан тушаалтнаар нь шүүхийн харьяаллыг тогтоосон байна./Хүснэгт 1-ийг харна уу/
2. Мөн тус хуулийн 1.8 дугаар зүйлд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 32 албан тушаалтны харьяалан шийдвэрлэх маргааныг Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан зөрчилд тооцогдох хэргүүдээр харьяалуулсан байна. Ийнхүү хэргийг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын хэргийн харьяаллыг тогтоохдоо хэд хэдэн албан тушаалтанд давхар харьяалуулсан нөхцөл байдал бий болжээ. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 5.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчлийг ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар 6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан, 6.18. Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч, 6.19.Монголбанкны хянан шалгагч, 6.31.санхүүгийн мэдээллийн улсын байцаагч нар тус тус харьяалан шийдвэрлэхээр байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/.
3. Хэргийг хянан шийдвэрлэх албан хаагчийн давхардсан харьяаллаас үүдэн ижил төрлийн зөрчлийг өөр өөр албан тушаалтан хянан шийдвэрлэсэн тохиолдолд Эрүүгийн хэргийн шүүх болон Захиргааны хэргийн шүүхийн аль аль нь тухай зөрчлийг шийдвэрлэхээр нөхцөл бий болж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан “Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим” алдагдсан байна.
4. Дээрх зөрүүтэй байдлаас үүдэн, ижил төрлийн зөрчил үйлдсэн хүн нь тухайн зөрчилд хэрэг бүртгэлт явуулсан албан тушаалтнаас хамааран шүүхэд хандахад шүүхийн харьяалал өөрчдөгдөх боломжтой буюу хэд хэдэн асуудал тулгарч байна.
 - a. Шүүхийн үйл ажиллагааны журам - Эрүүгийн хэргийн шүүх зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байдаг бол захиргааны хэргийн шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа нь ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхээс хугацааны хувьд л өөр болохоос биш давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрх нээлттэй байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэргийн шүүхээр зөрчлийн хэргийг шийдвэрлэхэд 2 шатны шүүхээр явах боломжтой бол захиргааны хэргийн шүүхээр зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд дээд шатны албан тушаалтанд хандах, УДШ-д гомдол гаргах буюу 3 шатны шүүхээр явах боломжтой байна.
 - b. Улсын тэмдэгтийн хураамж – Эрүүгийн хэргийн шүүхэд хандахад УТХ төлдөггүй бол Захиргааны хэргийн шүүхэд хандахад УТХ төлдөг.
 - c. Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа – Эрүүгийн хэргийн шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх хугацаа ЗШШТХ-д зааснаар гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэдэг бол Захиргааны хэргийн шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь ЗХШХШТХ-д зааснаар тусгай ажиллагааны журмаар 30 хоног байна.

САНАЛ

Дүгнэлтэд дурдсан зөрүүтэй нөхцөл байдлыг залруулахын тулд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Зөрчил хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг илүү боловсронгуй байдлаар хуульчлах,
 - хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тухайн зөрчлийг шалган шийдвэрлэсэн албан хаагчаар бус, зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн онцлогоос хамааруулан харьяалуулах, /жишээ нь зөрчлийн тухай хуулийн 10.8 дугаар зүйлд заасан зөрчлийг зөвхөн нэг шүүх нь харьяалан шийдвэрлэдэг байхаар хуульчлах/
 - эсхүл эрүүгийн хэргийн шүүх, захиргааны хэргийн шүүх аль аль нь зөрчлийг хянан шийдвэрлэх бус аль нэг шүүх нь зөрчлийг харьяалан шийдвэрлэдэг байх замаар харьяаллын асуудлыг шийдвэрлэх,
2. Зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхдээ нэгдсэн байдлаар шүүхийн үйл ажиллагааны журмыг тогтоох,
 - гомдол гаргах журам,
 - хэрэг хянан шийдвэрлэх хугацаа,
 - улсын тэмдэгтийн хураамж төлөх зэрэг асуудлыг ижил байдлаар зохицуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэргийн шүүх зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ ЭХХШтХ-д заасан нийтлэг журмаас гадна ЗШШтХ-ийн наймдугаар бүлэгт заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмыг баримталдаг бол Захиргааны хэргийн шүүх зөвхөн ЗХШХШтХ-д заасан журмыг баримталж байгаа нь дээрх шүүхүүдийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хувьд ялгаатай байдлыг үүсгэж байна.
3. ЗШШтХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан албан тушаалтны шийдвэрлэх хэргийн харьяаллыг давхардуулалгүйгээр хуульчлах нь оновчтой байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

1. Монгол улсын үндсэн хууль (1992)
2. Зөрчлийн тухай хууль (2017)
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)

Монгол хэл дээрх эх сурвалж

1. Б.Чимид, БНМАУ-ын захиргааны эрх, 1973
2. Ж.Долгорсүрэн, Монгол Улсын захиргааны эрх зүйн удиртгал, 2006
3. П.Одгэрэл, Захиргааны эрх зүй ерөнхий анги 2016
4. Ж.Долгорсүрэн, Монгол Улсын захиргааны эрх зүй ба процессын ажиллагаа, 2001
5. Захиргааны хэргийн харьяалал №2, 2005
6. С.Нарангэрэл Эрх зүйн эх толь бичиг, 2021
7. Т.Золбоо, Эрүүгийн эрх зүй ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц, 2018
8. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, УБ хот, 2004 он
9. Монгол улсын зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /Сургагч багш нарт зориулсан гарын авлага/, ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 2017
10. А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, 2014

Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. С.Асланбек “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба прокурорын хяналт” <https://legaldata.mn/buteel/pdf?id=804>
2. Ц.Цогт “Захиргааны хариуцлага” ба “эрүүгийн хариуцлага” (англо-саксоны эрх зүйн системийн жишээ <https://legaldata.mn/b/395>)
3. Д.Сүнжид “Захиргааны ерөнхий хууль, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүхийн хяналтын үзэл баримтлал” [HTTPS://LEGALDATA.MN/BUTEEL/PDF?ID=728](https://LEGALDATA.MN/BUTEEL/PDF?ID=728)
4. З.Ганзориг, Зөрчлийн хэргийг захиргааны хэргийн шүүхэд анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд анхаарвал зохих зарим асуудал, «Монголын төр, эрх зүй сэтгүүл» (2020 №1, 94), 39-60 дахь тал
5. Ц.Цогт, Захиргааны процессын эрх зүйн шинэчлэл: захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл, <https://legaldata.mn/b/119>
6. Ц.Цогт, Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу прокурорын хяналт, “Эрх зүй сэтгүүл” (2018, 11-р сар)
7. Т.Мөнх-Эрдэнэ, Х.Баттулга, Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга) болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмж, <http://legaldata.mn/b/177>.

Судалгааны тайлан

1. ХЗҮХ Захиргааны хариуцлагын тухай хуультай холбоотой судалгаа 2004 он <https://legaldata.mn/b/230>
2. ХЗҮХ Монгол улсын эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийг харьцуулан судлах нь 2007 он <https://legaldata.mn/b/247>

Гадаад эх сурвалж

1. Бүгд найрамдах Болгар улсын захиргааны зөрчлийн тухай хууль
2. ХБНГУ-ын захиргааны зөрчлийн тухай хууль
3. ОХУ-ын захиргааны зөрчлийн тухай хууль

Хавсралт 1. Зөрчил хянан шийдвэрлэх харьяалал

Доорх хүснэгтэд:

- Эрүүгийн хэргийн шүүхээр харьяалан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг – налуу байдлаар,
- Захиргааны хэргийн шүүхээр харьяалан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг – тодруулсан байдлаар,
- Харьяалал давхцсан зөрчлийн хэргийн зүйл, хэсгийг – доогуур зураастай хэлбэрээр тус тус тэмдэглэв.

5.1 дүгээр зүйл 1 дэхь хэсэг	6.6.олон нийтийн цагдаа			6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
5.5 дугаар зүйл	6.6.олон нийтийн цагдаа			6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
5.6 дугаар зүйл	5.6 дугаар зүйл 7 дахь хэсэг	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.11.гаалийн улсын байцаагч
	5.6 дугаар зүйл 9, 10 дахь хэсэг	6.2.хилийн төлөөлөгч, орлогч, туслагч	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	6.11.гаалийн улсын байцаагч
5.10 дугаар зүйл	1 дэхь хэсэг	6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан		6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
	2, 4, 5 дахь хэсэг	6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.18. Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч	6.19. Монголбанкны хянан шалгагч
				6.31.санхүүгийн мэдээллийн улсын байцаагч
5.11 дүгээр зүйл 1.5 дахь заалт	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч			6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч
5.12 дугаар зүйл	5.12 дугаар зүйл 1, 3 дахь хэсэг, 2.1 дэхь заалт	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч
	5.12 дугаар зүйл 4 дэх хэсэг	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.11.гаалийн улсын байцаагч
5.13 дугаар зүйл 1, 3 дахь хэсэг	6.7.гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	
5.18 дугаар зүйл	6.7.гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч			6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
6.1 дүгээр зүйл 4.2 дахь заалт	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч			6.11.гаалийн улсын байцаагч
6.3 дугаар зүйл	6.6.олон нийтийн цагдаа			6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
6.4 дүгээр зүйл 1.1, 2.8 дахь заалт	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч			6.11.гаалийн улсын байцаагч

6.5 дугаар зүйл	1.4, 5, 11, 12, 15, 16 дахь хэсэг	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч
	7.2 дахь заалт, 9 дэх хэсэг	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.11.гаалийн улсын байцаагч
	13 дахь хэсэг	6.6.олон нийтийн цагдаа	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч
6.6 дугаар зүйл 8 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.13.гадаадын иргэний хяналтын улсын байцаагч	
6.10 дугаар зүйл 4 дэх хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.13.гадаадын иргэний хяналтын улсын байцаагч	
6.18 дугаар зүйл 6 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.13.гадаадын иргэний хяналтын улсын байцаагч	
6.20 дугаар зүйл	1.2, 1.3 дахь заалт	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.26.хүүхдийн эрхийн улсын байцаагч	
	6 дахь хэсэг	6.9.ахлах шийдвэр гүйцэтгэгч	6.26.хүүхдийн эрхийн улсын байцаагч	7.Эрүүгийн хэргийн шүүх
	7 дахь хэсэг	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.26.хүүхдийн эрхийн улсын байцаагч
6.24 дүгээр зүйл 1, 2 дахь хэсэг		6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч
6.26 дугаар зүйл 2 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	7.Эрүүгийн хэргийн шүүх	
7.3 дугаар зүйл		6.2.хилийн төлөөлөгч, орлогч, туслагч	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.11.гаалийн улсын байцаагч
7.7 дугаар зүйл 1, 2 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.27.улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч	
7.8 дугаар зүйл 2 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.27.улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч	
7.9 дүгээр зүйл	1, 3, 4, 5, 7, 8, 10, 11 дэх хэсэг	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.17.гал түймрийн улсын хяналтын байцаагч	
	9 дэх хэсэг	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.17.гал түймрийн улсын хяналтын байцаагч	
7.15 дугаар зүйл 8 дахь хэсэг		6.6.олон нийтийн цагдаа	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.27.улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
7.16 дугаар зүйл 2 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.27.улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
7.17 дугаар зүйл		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.27.улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
8.1 дүгээр зүйл 4 дэх хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
8.2 дугаар зүйл 2, 6, 7 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
8.3 дугаар зүйл 2 дахь хэсэг		6.11.гаалийн улсын байцаагч		6.14.оюуны өмчийн улсын байцаагч
9.7 дугаар зүйл 1.4 дэх заалт		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.11.гаалийн улсын байцаагч

9.10 дугаар зүйл	2.2, 2.3 дахь заалт	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		
	2.4 дэх заалт	6.14.оюуны өмчийн улсын байцаагч		6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		
	3 дахь хэсэг	6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.12. татварын улсын байцаагч	6.16. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч	6.21.архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч	6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч
10.1 дүгээр зүйл		6.14.оюуны өмчийн улсын байцаагч		6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		
10.2 дугаар зүйл		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		
10.3 дугаар зүйл	1.2 дахь заалт	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.14.оюуны өмчийн улсын байцаагч		
	1.5 дахь заалт	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.14.оюуны өмчийн улсын байцаагч	6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		
10.4 дүгээр зүйл		6.6.олон нийтийн цагдаа		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		
10.8 дугаар зүйл		6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		
10.9 дүгээр зүйл 1 дэх хэсэг		6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч		
10.17 дугаар зүйл		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.15.нийгмийн даатгалын байцаагч		
10.19 дүгээр зүйл		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.15.нийгмийн даатгалын байцаагч		
10.27 дугаар зүйл		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч		
11.2 дугаар зүйл 2 дахь хэсэг		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч		
11.7 дугаар зүйл 3 дахь хэсэг		6.13.гадаадын иргэний хяналтын улсын байцаагч		6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч		
11.12 дугаар зүйл		6.14.оюуны өмчийн улсын байцаагч		6.28.Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч		
11.13 дугаар зүйл		6.18.Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч		6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч		
11.15 дугаар зүйл 7 дахь хэсэг		6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.18.Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч		
11.24 дүгээр зүйл 1.1, 1.4, 1.5, 1.6 дахь заалт		6.11.гаалийн улсын байцаагч		6.12.татварын улсын байцаагч		
11.25 дугаар зүйл		6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч		
11.26 дугаар зүйл 2 дахь хэсэг		6.14.оюуны өмчийн улсын байцаагч		6.18.Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч		

11.29 дүгээр зүйл	1.1, 1.2 дахь заалт, 2-7, 9, 12 14-19 дэх хэсэг	6.18.Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч	6.19.Монголбанкны хянан шалгагч	6.31.санхүүгийн мэдээллийн улсын байцаагч	
	10, 11 дэх хэсэг	6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.18. Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч	6.19. Монголбанкны хянан шалгагч	6.31.санхүүгийн мэдээллийн улсын байцаагч
	21 дэх хэсэг	6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.19.Монголбанкны хянан шалгагч	6.31.санхүүгийн мэдээллийн улсын байцаагч	
	22 дахь хэсэг	6.11.гаалийн улсын байцаагч	6.19.Монголбанкны хянан шалгагч	6.31.санхүүгийн мэдээллийн улсын байцаагч	
11.30 дугаар зүйл		6.18.Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч	6.19.Монголбанкны хянан шалгагч		
13.5 дугаар зүйл		6.6.олон нийтийн цагдаа	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		
14.1 дүгээр зүйл 7 дахь хэсэг		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		
14.3 дугаар зүйл 2 дахь хэсэг		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		
14.4 дүгээр зүйл		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		
14.5 дугаар зүйл		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		
14.6 дугаар зүйл 5, 6, 7, 9 дэх хэсэг		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч		
14.7 дугаар зүйл	5 дахь хэсэг	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	7.Эрүүгийн хэргийн шүүх		
	20-29, 33-41, 44, 46, 47, 50, 53 дахь хэсэг	6.6.олон нийтийн цагдаа	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		
15.1 дүгээр зүйл 1.1, 1.5, 1.6 дахь заалт		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		
15.3, 15.4, 15.6 дугаар зүйл		7.Эрүүгийн хэргийн шүүх	8.Иргэний болон захиргааны хэргийн шүүх		
15.7 дугаар зүйл		6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	7.Эрүүгийн хэргийн шүүх	8.Иргэний болон захиргааны хэргийн шүүх	
15.10 дугаар зүйл		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		
15.20 дугаар зүйл		6.2.хилийн төлөөлөгч, орлогч, туслагч	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		
15.21 дүгээр зүйл 3, 4 дэхь хэсэг		6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		

15.22 дугаар зүйл	<u>1 дэх хэсэг</u>	6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч		6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч	
	2.2 дахь заалт	6.5.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан		6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	
15.24 дүгээр зүйл	<u>1, 2, 4 дэх хэсэг</u>	6.1.консулын эрх бүхий албан тушаалтан		6.20.улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч	
	3 дахь хэсэг	6.1.консулын эрх бүхий албан тушаалтан		6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	
<u>16.1 дүгээр зүйл 2, 3 дахь хэсэг</u>		6.2.хилийн төлөөлөгч, орлогч, туслагч		6.11.гаалийн улсын байцаагч	
<u>16.4 дүгээр зүйл</u>	6.2.хилийн төлөөлөгч, орлогч, туслагч	6.10. мэргэжлийн хяналтын улсын байцаагч	6.11.гаалийн улсын байцаагч	6.12. татварын улсын байцаагч	6.13.гадаадын иргэний хяналтын улсын байцаагч

Хавсралт 2. Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн зөрчлийн хэргүүд /Шүүхийн шийдвэрийн цахим санаас хайлт хийхэд гарч ирсэн шийдвэрүүд/

д/д	Гомдлын шаардлага	Гомдол гаргагч	Хариуцагч	ШИЙДВЭРЛЭСЭН байдал	ШИЙДВЭРИЙН дугаар	Холбогдох хуулийн зүйл, заалт
1	Гомдлын шаардлага: "Баянзүрх дүүргийн Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ц.Өсөхбаярын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1452756 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай" шаардлага бүхий зөрчлийн хэргийг хянан хэлэлцэв.	иргэн Д.Б	Баянзүрх дүүргийн Санхүү, бүртгэлийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ц.Өсөхбаяр	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 2 /хоёр/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ ШШ2021/0638	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1, 3.1 дүгээр зүйл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3, 106.3.11, 107 дугаар зүйлийн 107.6 дахь хэсэг
2	Нэхэмжлэлийн шаардлага: "ХУДТХ-ийн татварын улсын байцаагч Д.Н. Т.Б нарын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 0309888 дугаар шийтгэлийн хуудаснаас 2008 оны Татварын ерөнхий хуулиар тооцсон нийт 16,700,737.30 төгрөгийн нөхөн татвар, торгууль, алдангийг хүчингүй болгуулах" тухай шаардлага бүхий захиргааны хэргийг хянан хэлэлцэв.	Нэхэмжлэгч: Э.Г ХХК	ХУДТХ-ийн татварын улсын байцаагч Д.Н. Т.Б.	Э.Г ХХК-ийн гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	128/ ШШ2021/0623	Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.1, 1.2, 2, 4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн /2008 оны / 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг
3	Гомдлын шаардлага: Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого, хяналтын газрын татварын орлого, хяналтын газрын татварын улсын байцаагч Т.Баасан, Л.Нарантуяа, М.Алтангэрэл нар нь ... дугаар шийтгэлийн хуудасаар тус банканд шийтгэл ногдуулсан бөгөөд тус маргаан бүхий захиргааны актын торгууль, алдангитай хэсгийг хүчингүй болгуулах.	Гомдол гаргагч: Худалдаа, хөгжлийн банк ХХК	Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого, хяналтын газрын татварын хяналт, шалгалтын байцаагч нар	гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0616	Татварын ерөнхий хууль /шинэчлэн найруулга-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйл, Татварын ерөнхий/ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.1.4, Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг мөн хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.2, 2 дэх хэсэг
4	Монгол банкны хянан шалгагч, улсын байцаагч ын 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 0050206 дугаар шийтгэлийн хуудасыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Чингисхаан банк	Хариуцагч: Монголбанкны ахлах хянан шалгагч, улсын байцаагч	гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0606	Зөрчлийн тухай хуулийн 11.3 дугаар зүйлийн 7, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.19, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2

5	ШӨХТГ-ын улсын байцаагч С.Г-ийн 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 0005676 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Э ХХК	Хариуцагч: ШӨХТГ-ын ӨЗЗЗСГ-ын улсын байцаагч С.Г	гомдлын шаардлагыг хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон	128/ШШ2021/0589	Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 4, 10.7 дугаар зүйлийн 4.1 дэх хэсэг
6	Оюуны өмчийн газрын хяналтын улсын байцаагчийн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 1453217 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Н ХХК	Хариуцагч: Оюуны өмчийн газрын хяналтын улсын байцаагч Ч.Э	гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.	128/ШШ2021/0586	Зохиогчийн эрх түүнд хамаарах эрхийн тухай (2006) хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12 дахь хэсгийн 12.2.3, 12.3, 24 дүгээр зүйлийн 24.1.4, Зөрчлийн тухай хуулийн Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 3, 8.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
7	"Хан-Уул дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.М 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 0069252 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай	Гомдол гаргагч: "Д Д Э Т" ХХК	Хариуцагч: Хан-Уул дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.М.	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг гурван /3/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ШШ2021/0580	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6
8	Нэхэмжлэлийн шаардлага: Б дүүргийн Татварын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 260297392 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Нэхэмжлэгч: Д ХХК	Хариуцагч: Б дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Г.Э, У. нар	нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ШШ2021/0578	Татварын ерөнхий (2008 оны) хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3, 74 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай (2006 оны) хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.7, 8 дугаар зүйлийн 8.3, Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг
9	Гомдлын шаардлага: Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Оюунтуяагийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 0176909 дүгээр шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Долоонууд овогт Ринзааны Булгاماа	Хариуцагч: Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Оюунтуяа	гомдлын шаардлагыг хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон	128/ШШ2021/0511	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.15 дугаар зүйлийн 1, 7.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг

10	Гомдлын шаардлага: "Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Я.Х-гийн 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 0069152 дугаартай 10000000 /арван сая/ төгрөгийн шийтгэлийг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: "И М О" ХХК	Хариуцагч: Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Я.Х	нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0495	Зөрчлийн тухай хуулийн 6.14 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалт
11	Гомдлын шаардлага: Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч Д.*****, ийн 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 0033747 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай	Гомдол гаргагч: ***** ХХК	Хариуцагч: Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн хяналтын улсын байцаагч Д.*****	гомдлын шаардлагыг хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон	159/ ШШ2021/0012	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг
12	Нэхэмжлэлийн шаардлага: Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2018 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 242018025 тоот шийтгэлийн хуудасны хоёрт заасан нийт 12,641,112.30 төгрөгийн шийтгэлийг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Шинэ Зууны өргөө ХХК	Хариуцагч: Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Чулуунцэцэг, Б.Сэрчмаа	нийт 12,641,112.30 төгрөгийн төлбөрийг 8,045,451.78 төгрөгөөр багасгасугай.	128/ ШШ2021/0473	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1, Татварын ерөнхий хууль /2008 оны/-ийн 74 дүгээр зүйлийн 74.1, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дох хэсэг
13	Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 22-01-001/05 дугаар актыг хүчингүй болгуулах	Нэхэмжлэгч: ХА АТТД Б.Г	Хариуцагч: ХА МХГ	нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, актыг хүчингүй болгосугай.	17	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8, 10.9.11, 10.12.2 дахь хэсэг,

14	Нэхэмжлэлийн шаардлага: "ОАТХ-ын ТУБ О.У. 3.М нарын хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл үйлдэж, хяналт шалгалтын тасгийн даргаар хянуулан баталгаажуулсан 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 0305014 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох	Гомдол гаргагч: "Э" ХХК	Хариуцагч: ОАТХ-ын ТУБ О.У. 3.М, Л.Т нар	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	18	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2, 6.1 дүгээр зүйлийн 1.1.1, 2.2.3, 6.6 дугаар зүйлийн 1.1.1, Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.1.1, 1.1.2, Татварын ерөнхий хуулийн / 2008 он/ 18 дугаар зүйлийн 18.1.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн /2006 он/ 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг
15	Гомдлын шаардлага: Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Т.*****ий 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 0066130 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-аар	Хариуцагч: Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Т.*****	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	159/ ШШ2021/0011	Зөрчлийн тухай хуулийн 12.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1
16	Гомдлын шаардлага: "Баянзүрх дүүрэг дэх Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ц.Ө-ын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1452765 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: У.М.	Хариуцагч: Баянзүрх дүүрэг дэх Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ц.Ө	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 2 / хоёр/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ ШШ2021/0462	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25, 27, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.4
17	Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч О.Болдбаатар, Ц.Цэвэлмаа, Ч.Энхтуяа нарын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 232201790 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: "У" ХХК	Хариуцагч: Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч О.Болдбаатар, Ц.Цэвэлмаа, Ч.Энхтуяа	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 3 / гурав/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ ШШ2021/0460	Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1.2.4 дүгээр зүйлийн 1

18	Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Д.А, Н.Г нарын 250295891 дүгээр шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: "ХЧ" ХХК	Хариуцагч: Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс, Сүхбаатар дүүргийн Татварын н хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Д.А, Н.Г	гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	128/ ШШ2021/0454	Татварын ерөнхий хуулийн /2008 оны/ 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн /2006 оны/ 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг,
19	Хан-Уул дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ч.Соддуламын 2020 оны 12 дугаар сарын 31 -ний өдөр гаргасан акт буюу №1451651 Шийтгэлийн хуудас-ыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Агваанпүрэвийн Дугармаа	Хан-Уул дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ч.Соддулам	гомдлын шаардлагыг хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон	159/ ШШ2021/0010	Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дугаар зүйлийн 25, мөн зүйлийн 27, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсэг
20	Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.*****гийн 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 500 нэгжээр торгосон 0066142 дугаар шийтгэлийн хуудас, 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 2031000106 дугаар Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авхуулах тухай даалгаар-ыг тус тус хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Х.*****	Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газар, тус газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.*****	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	159/ ШШ2021/0010	Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1, 2.1 дүгээр зүйлийн 1, 2, 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4
21	Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчийн 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 0303361 тоот актыг илт хууль бус болохыг тогтоолгох /шийтгэлийн хуудас/	Нэхэмжлэл гаргагч: БМ ХХК	Хариуцагч: БЗД-н ТХ-ын ур К.Н, О.Э	нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	128/ ШШ2021/0425	Татварын Ерөнхий хуулийн /2008 оны /74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг

22	Сонгинохайрхан дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Байгаль орчны улсын байцаагч гийн 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дугаартай шийтгэлийн хуудасны 1 ширхэг тарваганы мах худалдсан, 1 ширхэг тарвага зөвшөөрөлгүй худалдсан гэснийг 1 ширхэг тарваганы мах тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтуугийгээр худалдан авсан гэж тус тус өөрчлөлт оруулах	Дүгнэлт гаргагч: Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны хяналт тавих албаны хяналтын прокурор	Хариуцагч: Сонгинохайрхан дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч	өөрчлөлт оруулахыг хүссэн дүгнэлтийг хангасугай	128/ШШ2021/0427	Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг /Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3.1, 106.3.12/
23	Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1451206 дугаартай "Зөрчилд шийтгэл оногдуулах тухай" шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох	Гомдол гаргагч: К.Х	Хариуцагч: Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Б.Г	гомдлын шаардлагыг хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон	110/ШШ2021/0045	Зөрчлийн тухай хуулийн 2.5 дугаар зүйлийн 1.3.1 дүгээр зүйлийн 2, 17.1 дүгээр зүйлийн 25, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1
24	Нэхэмжлэлийн шаардлага: "Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Б 2020 оны 12 сарын 16-ны өдрийн 001 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Нэхэмжлэгч: "Э" ХХК,	Хариуцагч: Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Б	нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	123/ШШ2020/0013	Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2, 3, 9 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг
25	хэрэглэгчийн төлөө газрын Өрсөлдөөний бодлого зохицуулалтын газрын улсын байцаагч Г.Ариунжаргалын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 0059286 дугаартай Шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Монголын үндэсний их сургууль НУТББ	Хариуцагч:***** хэрэглэгчийн төлөө газар	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 2 /хоёр/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ШШ2021/0419	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1.4.4 дүгээр зүйлийн 1, 2, 4.15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг

26	Татварын Ерөнхий газрын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 0182501 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: "Х Б" ХХК	Хариуцагч: Татварын Ерөнхий газар	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	128/ШШ2021/0420	Татварын Ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4, 34.4.2, Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 7.3
27	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн ***** дугаар шийтгэлийн хуудсын зарим хэсгийг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: *****	Хариуцагч: Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч ***** , Л.Батсүх нар	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай	128/ШШ2021/0422	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9, 15 дугаар зүйлийн 15.9, Зөрчлийн тухай хуулийн /2017/11.19 дүгээр зүйлийн 1.2, 4
28	Гомдлын шаардлага: Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн улсын байцаагч нарын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 351730077 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: "Б П Р" ХХК	Хариуцагч: Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн улсын байцаагч нар	гомдлын шаардлагын зарим хэсгийг хангаж, нийт 4,564,162.25 төгрөгийг төлүүлэхээр өөрчилсүгэй	128/ШШ2021/0409	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.1, 14.6, 14.6.2, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн /2006/ 12 дугаар зүйлийн 12.1.36, Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3
29	"Татварын улсын байцаагчийн 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 0299719 дүгээр шийтгэлийн хуудсаар "Б Э" ХХК-ийн 2014 оны үйл ажиллагаанд хамааруулан тооцсон 568,564,867.80 төгрөгийн төлбөр ногдуулсан хэсгийг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: "Б Э" ХХК	Хариуцагч: Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Ц.Б, О.Д	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ШШ2021/0408	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2006 оны/-ийн 14 дүгээр зүйлийн 14.7, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1, 2
30	Гомдлын шаардлага: *****-ын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 1453212 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох	Гомдол гаргагч: *****	Хариуцагч: ***** Оюуны өмчийн улсын байцаагч	гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай	128/ШШ2021/0396	Зохиогчийн эрх түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.3, Зөрчлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
31	Гомдлын шаардлага: нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1452774 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Боржгон овогт Маамаагийн ...	Хариуцагч: Баянзүрх дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч	гомдлын шаардлагыг бүхэлд нь хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосугай.	128/ШШ2021/0391	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.15 дугаар зүйлийн 1, 7.1 дүгээр зүйлийн 1.1, 7.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

32	Гомдлын шаардлага: "Баянзүрх дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1452770 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: ЦХ	Хариуцагч: Баянзүрх дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ц.Ө	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 2 / хоёр/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ ШШ2021/0386	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25, 27, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.4
33	Гомдлын шаардлага: Ч дүүргийн Татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 0295195 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: М ГҮТББ	Хариуцагч: Ч дүүргийн Татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Ч.М, А.Б	гомдлын шаарлагыг бүхэлд нь хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосугай.	128/ ШШ2021/0378	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2, 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
34	Гомдлын шаардлага: Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн дарга татварын улсын ахлах байцаагч С.*****ийн 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 0176656 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Д.*****	Хариуцагч: Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн дарга татварын улсын ахлах байцаагч С.*****	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	159/ ШШ2021/0008	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4
35	Нэхэмжлэлийн шаардлага: Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч ***** нарын үйлдсэн 0297378 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Нэхэмжлэгч: *****	Хариуцагч: Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татвар, хяналт шалгалтын улсын байцаагч ***** , ***** нар	нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0370	Татварын ерөнхий хуулийн /2008оны/ 43 дугаар зүйлийн 43.5, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн /2006оны/ 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн /2006оны/ 28 дугаар зүйлийн 28.1, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1

36	Гомдлын шаардлага: "Баянзүрх дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1452770 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: ЦХ	Хариуцагч: Баянзүрх дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Ц.Ө	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 2 /хоёр/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ ШШ2021/374	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25, 27, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.4
37	Гомдлын шаардлага: улсын байцаагчийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1452755 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Боржигон овгийн Баярсайханы Пүрэвжав	Хариуцагч: Баянзүрх дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч	гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0367	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 27, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсэг
38	Гомдлын шаардлага: Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Цэвэлмаа, О.Төгсжаргал нарын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 0309896 дугаартай шийтгэлийн хуудсаар ногдуулсан нөхөн татвар, торгууль, алдангиас хүлээн зөвшөөрсөн болон Маргаан таслах зөвлөлийн тогтоолоор хүчингүй болгосноос үлдсэн 260,499,058.50 төгрөгийг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Кашмер холдинг ХХК	Хариуцагч: Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Цэвэлмаа, О.Төгсжаргал	гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0360	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2015 оны/-ийн 14 дүгээр зүйлийн 4.1.5 /нэмэлт, өөрчлөлт ороогүй/, Зөрчлийн хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.2, мөн зүйлийн 2 дахь хэсэг /нэмэлт, өөрчлөлт ороогүй/, Татварын ерөнхий хууль /2008 оны/-ийн 74 дүгээр зүйлийн 74.1
39	Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2021 оны 02 сарын 11-ний өдрийн 0064073 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	"Хүннү Эйр" ХХК	Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Болдбаатар	гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	126/ ШШ2021/0017	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8/, Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлийн 2 дахь заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэг

40	Гомдлын шаардлага: ...Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч***** нарын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн №0295945 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: *****	Хариуцагч: Сүхбаатар дүүргийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч***** нар	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0346	Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.2, Татварын ерөнхий хууль /2008 оны/-ийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2006 оны/ 14 дүгээр зүйлийн 14.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2015 оны/-ийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.6.1 дэх заалт
41	Нэхэмжлэлийн шаардлага: Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 351730071 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Монтрак групп ХХК	Хариуцагч: Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Цэвэлмаа, Б.Бат-Эрдэнэ	гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0344	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2, Татварын ерөнхий хууль /2008 оны/-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006 оны/-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2006 оны/-ийн 14.3, Үл хөдлөх эд дүгээр зүйлийн 7.1.1, 14 дүгээр зүйлийн 14.3, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 4 дүгээр зүйлийн 4.1.1, 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг
42	Гомдлын шаардлага: "НМХгЭчхуб М.Агийн 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 0069143 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: У овгийн Д-ийн А	Хариуцагч: НМХгЭчхубМ.А Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын эрүүл мэндийн чанарын улсын байцаагч	дахин шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 3 / гурав/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ ШШ2021/0340	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, Зөрчлийн тухай хуулийн 6.8

43	Гомдлын шаардлага: "Ш.О пийн 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 0173607 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч: Ж.Э	Хариуцагч: Ш.О,	шинэ акт гаргах хүртэл өмнөх шийтгэлийн хуудсыг 1 / нэг/ сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.	128/ ШШ2021/0334	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1, 2.4 дүгээр зүйлийн 1
44	Гомдлын шаардлага: эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 0067114 дүгээр шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	Гомдол гаргагч:***** ГҮТББ	Хариуцагч: Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч	гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	128/ ШШ2021/0332	Зөрчлийн тухай хуулийн 12.8 дугаар зүйлийн 3, Эрчим хүчний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалт

**ГУРАВ. ЗӨРЧИЛ ҮЙЛДЭГЧИД ОНОГДУУЛАХ
САНУУЛАХ БОЛОН ТОРГОХ ШИЙТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ
(ГАДААД ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)**

Судалгааг удирдсан:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D) С.Сүхбаатар
Эрдэм шинжилгээний ажилтан Т.Намуун
Эрдэм шинжилгээний ажилтан А.Намуунаа

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас ирүүлсэн захиалгын дагуу Зөрчил үйлдэгчид оногдуулах сануулах болон торгох шийтгэлийн төрлийн эрх зүйн зохицуулалт (Гадаад орнуудын харьцуулсан судалгаа) сэдвээр судалгааг хийж гүйцэтгэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн." гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж тус тус заасан. Монгол Улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгынхоо хүрээнд хууль тогтоомждоо дэвшилтэт өөрчлөлтүүдийг хийж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн¹ 1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт зөрчлийн шийтгэлийн төрөлд сануулах шийтгэлийг шинээр нэмж², мөн зүйлийн 4, 5 дахь хэсэгт торгуулийн хэмжээг хөнгөрүүлэх болон нэмэгдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг³ шинээр тусгаж өгсөн байна. Иймд энэхүү судалгааны ажлын зорилго нь Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн холбогдох зохицуулалттай холбогдуулан гадаадын зарим улсын хууль тогтоомж дахь зөрчлийн сануулах болон торгох шийтгэлийн эрх зүйн зохицуулалтыг судалж, шилжүүлэн авах буюу нутагшуулж болох зохицуулалт, дэвшилтэт санаа зэргийг тодруулан гаргах замаар хуулийн төслийг сайжруулах, үндэсний эрх зүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

1 Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (төсөл), <https://lawforum.parliament.mn/draft/65/>.

2 2/3.3 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1.1 дэх заалт:

"1.1. Сануулах шийтгэл"

3/3.4 дүгээр зүйл."Сануулах шийтгэл"

"1.Эрх бүхий албан тушаалтнаас зөрчил гаргасан этгээдэд уг зөрчлийг дахин гаргахгүй байхыг анхааруулсан мэдэгдлийг сануулах шийтгэл гэнэ."

"2.Сануулах шийтгэлийг зөвхөн энэ хуулийн тусгай ангид оногдуулж болохоор заасан тохиолдолд хэрэглэнэ."

"3.Сануулах шийтгэлийн хэлбэр нь цаасан болон цахим хэлбэртэй байж болох ба эрх бүхий албан тушаалтан хуульд заасны дагуу хэрэглэнэ."

3 4/3.10 дугаар зүйл."Шийтгэлийг хөнгөрүүлэх үндэслэл"

"1.Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд нь энэ хуулийн тусгай ангид дээд, доод хязгаартай байхаар заасан торгох болон баривчлах шийтгэлийг оногдуулахдаа зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс өөрийн буруутай үйлдлийг хүлээн зөвшөөрсөн, зөрчлийн үр дагавар, учруулсан хохирлыг арилгасан, нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанаас урьдчилан төлсөн байдлыг харгалзан хөнгөрүүлэн оногдуулж болно"

"2.Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдээс энэ хуулийн тусгай ангид заасан зөрчлийг үйлдсэнтэй холбоотойгоор эрх бүхий албан тушаалтнаас өмнө нь оногдуулсан торгуулийг тогтоосон хугацаанд төлөөгүй нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөнгөрүүлэх нөхцөлийг хэрэглэхээс татгалзах үндэслэл болно."

5/3.11 дүгээр зүйл. "Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх"

"1.Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгуулийг хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд торгуулийг төлөхгүй хожимдуулсан хугацаа, төлөх ёстой торгуулийн хэмжээ, бусад нөхцөл байдлыг харгалзан торгуулийн хэмжээг тавь хүртэл хувиар нэмэгдүүлж болно."

Гадаад орнуудын харьцуулсан судалгааг хийхдээ улс орон тус бүрээр, эсхүл судлах сэдвийг төрөлжүүлж бүлэг үүсгэн судлах боломжтой. Иймд улс орон тус бүрээр гадаад орнуудын холбогдох эрх зүйн зохицуулалтыг судалж дүгнэлээ. Энэхүү судалгаа нь эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад чиглэж байгаа тул судлахаар сонгох улс нь эрх зүйн хөгжлийн хувьд ололттой туршлага бүхий байх шалгуурыг тавин Дэлхийн шударга ёсны төслийн Улс орнуудын хуулийн засаглалын индексээр⁴ Монгол Улс (61 дүгээрт)-аас дээгүүр жагссан Финланд (3 дугаарт), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид ХБНГУ гэх) (5 дугаарт), Ирланд (10 дугаарт), Австрали (13 дугаарт), Англи (16 дугаарт) улсуудаас гадна хөрш Оросын Холбооны Улс (цаашид ОХУ гэх)-ыг сонгон зөрчлийн сануулах болон торгох шийтгэлийн эрх зүйн зохицуулалтыг судалсан болно.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНД

Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахтай холбогдсон харилцааг 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан Захиргааны хариуцлагын тухай хууль, түүний дараагаар 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Зөрчлийн тухай хуулиар зохицуулж ирсэн бөгөөд одоо 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилдэг. Эдгээр хуулиудад зөрчилд оноох шийтгэлийн төрлүүдийг дараах байдлаар хуульчилсан байх ба сануулах шийтгэлийн төрлийг хуульд тусгаагүй мөн торгууль төлөлтийн биелэлтийг хангуулах талаарх зохицуулалт хангалтгүй байна.

Захиргааны хариуцлагын тухай хууль (1992)	Зөрчлийн тухай хууль (2017)
4 дүгээр зүйл. Захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээ 1.Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулж болно: 1/ торгох; 2/ тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох; 3/ хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах; 4/ баривчлах; 5/ албадан сургалтад хамруулах. 2.Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлийг үндсэн болон нэмэгдэл, хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах, албадан сургалтад хамруулах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр хэрэглэнэ.	3.3 дугаар зүйл. Шийтгэлийн төрөл 1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараахь шийтгэл оногдуулна: 1.1.торгох шийтгэл; 1.2.баривчлах шийтгэл; 1.3.эрх хасах шийтгэл. 2.Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, эрх хасах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр оногдуулна. 3.4 дүгээр зүйл.Торгох шийтгэл 1.Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ. 2.Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэг торгуулийн нэгж /цаашид "нэгж" гэх/ нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. 4.Шүүх, эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно.

4 World Justice Project, Rule of Law Index 2021, <https://worldjusticeproject.org/sites/default/files/documents/WJP-INDEX-21.pdf> (Сүүлд үзсэн: 2021.11.23).

3.Хуульд өөрөөр заагаагүй бол зөрчил гаргасан иргэнийг торгох шийтгэл 100-50000, албан тушаалтныг торгох шийтгэл 1000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг торгох шийтгэл 50000-250000 төгрөгийн хэмжээтэй, баривчлах шийтгэл 7-30 хоног, тусгайлан олгосон эрх хасах шийтгэл 6 сараас 2 жил хүртэл хугацаатай байна.	5.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хөрөнгө, орлого, нөхөн төлбөр, хохирлын тодорхой хувиар тооцсон хэмжээгээр торгох шийтгэлийг оногдуулна. 6.Хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээнд энэ зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй. 7.Энэ хуулийн тусгай ангид заасны дагуу торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.
---	---

Харин БНМАУ-ын хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль тогтоомжид а. урьдчилан сануулах, б. сануулах, в. донгодох г. торгох д. баривчлах, е. эд хөрөнгийг хураах, ё. засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, ж. тусгай эрхийг түр хасах зэрэг захиргааны шийтгэлийн төрлүүдийг хуульчилсан байдаг байв.⁵ Урьдчилан сануулах, донгодох шийтгэлийг нийгмийн аюулаар ялимгүй зөрчил гаргасан, тухайн зөрчилдөө гэмшин, ухамсарлаж байгаа, анх ноцтой биш зөрчил гаргасан этгээдэд хуульд зааснаар хэрэглэнэ. Захиргааны зөрчил гаргасны улмаас сануулах буюу донгодуулсан хүн 1 жилийн дотор буюу шийтгэгдээгүйд тооцогдох хугацаа болоогүй байхад дахин тийм зөрчил гаргавал давтан үйлдсэн гэж хууль ёсоор хүндрүүлж үздэг байжээ.⁶ Ийнхүү энэ онд боловсруулагдаж байгаа Зөрчлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд сануулах шийтгэлийн төрлийг шинээр нэмж байгаа тул сануулах шийтгэлийн талаарх онолын ойлголтыг дэлгэрүүлэн авч үзье.

Орчин үеийн захиргааны эрх зүй болон захиргааны зөрчлийн эрх зүйн онолд аливаа захиргааны хариуцлага нь зөвхөн шийтгэх зорилгыг агуулах ёсгүй гэж үздэг бөгөөд захиргааны хариуцлага нь ирээдүйд хэн нэг этгээд аливаа хууль тогтоомжийг зөрчих хууль бус үйлдлийг таслан зогсоох, зөрчлийн шинж, хор уршгийн хэр хэмжээтэй дүйцэхүйц байх, зөрчил гаргасан этгээдийн хувьд оносон тохирсон байхыг шаарддаг.⁷ Түүнчлэн зөрчлийг эрүүгийн эрх зүйгээс тусгаарлах, зааглан тодорхойлох нь манай улсын өнөөгийн зохицуулалтад томоохон ач холбогдолтой ба захиргааны зөрчлийн эрх зүйд «сонгох боломжтой байх зарчим» буюу «principle of opportunity» хэрэгждэгээрээ эрүүгийн эрх зүйгээс ялгаатай хэмээн эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаарах орнуудын эрх зүйн онолд үздэг.⁸ Захиргааны хариуцлага гэдэг нь төрийн эрх бүхий байгууллагаас өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний учир захиргааны хууль тогтоомжийн дагуу хүлээлгэдэг хууль зүйн хариуцлагын төрөл бөгөөд эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчил гаргасан этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хуульд заасан албадлага хэрэглэх замаар зохих хэмжээгээр хязгаарлах явдал юм.⁹ Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан зарим зөрчлийн хэрэгт оноохоор хуульчилсан санкцууд нь огт сонгох боломжгүй, зарим тохиолдолд хэт хатуу шийтгэл оногдуулсан байдаг. Иймд хуулийн байгууллагын ачааллыг

5 ий зарим асуудал” Шүүх эрх мэдэл сэтгүүл №4(2017), 104 дэх тал.

6 Б.Чимид, БНМАУ-ын Захиргааны эрх, УБ, 1973 он, 326 дахь тал.

7 Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо, Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга) болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмж, <https://legaldata.mn/b/177> (Сүүлд үзсэн:2021.11.22).

8 Мөн тэнд.

9 Хууль зүйн үндэсний хүрээлэн “Захиргааны хариуцлагын тухай хуультай холбоотой судалгаа” 2004 он, <https://nli.gov.mn/?p=1937> (Сүүлд үзсэн:2021.11.23).

багасгах, мөн хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл баримтлалын үүднээс зөрчил үйлдэгч бүрт шийтгэл оногдуулах нь хамгийн оновчтой арга зам бус юм гэдгийг практик судалгаануудад дурдсан байдаг.

Ц.Цогт шүүгч “Захиргааны хариуцлага” ба “эрүүгийн хариуцлага” (англо-саксоны эрх зүйн системийн жишээ)¹⁰ өгүүлэлдээ “Захиргааны хариуцлагын зорилго нь хууль тогтоомжоор зохицуулагдсан харилцаанд оролцогчдыг ялангуяа зөрчил гаргагчийг “шийтгэх”-ээс илүүтэй уг зөрчлөөс сэргийлснээр хамгаалагдах ёстой нийтлэг эрхийг урьдчилан “хамгаалах” зорилготой (remedial rather than punitive) гэж үздэг байна” хэмээн дурдаад “захиргааны хариуцлагын зорилго нь «шийтгэх»-ээс илүүтэйгээр олон нийтэд халтай, эрсдэл бүхий зөрчлөөс хяналт шалгалт хийх замаар сэргийлснээр нийтлэг эрхийг урьдчилан «хамгаалах» зорилготой” гэжээ.

Г.Ганбаатар, Л.Оюунчимэг нар “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” өгүүлэлдээ “Төр өөрөө иргэдийн өмнө хүлээх Үндсэн хуулийн дагуух “үүрэг”-ийн хүрээнд иргэдэд баталсан “хуулиа мэдүүлэх” үүрэг хангалтгүй байхад “иргэд хууль мэдэхгүй байх нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэх хуулийн хийсвэр заалтын агуулгаар иргэдийг алдаа, хариуцлага руу хүчлэн түлхэх, шийтгэх ёсгүй”¹¹ хэмээсэн байдаг. Иймд зөвхөн зарим төрлийн зөрчилд зөрчил үйлдэгчийн нөхцөл байдлыг харгалзан сануулах, торгуулийн хэмжээг бууруулах зэрэг уян хатан шийтгэлийн төрлүүдийг хуульчлахаар нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасан нь ололттой юм. Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат “Шүүх эрх мэдэл, хууль сахиулах албан хаагчдын үндэсний чуулган”-д тавьсан илтгэлдээ¹² “Зөрчлийн тухай хууль батлагдсанаар иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага ихэслээ, торголоо, шийтгэлээ гэх шүүмжлэл сүүлийн жилүүдэд нийгэмд газар авч байгаа боловч үнэн хэрэгтээ сүүлийн 3 жилд үйлдэгдсэн 4.9 сая зөрчлийн 91.4 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчил байна. Гэвч Зөрчлийн тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд 2,8 сая зөрчилд оногдуулсан 66 тэрбум төгрөгийн торгууль биелэгдээгүй байгаа нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх гэсэн үзэл баримтлалтай нийцэхгүй байгааг бид анхаарах ёстой. Оногдуулсан шийтгэл бүр биелдэг байх нь нийгэмд шударга ёсны тогтолцоо бэхжих гол үндэс болно.” гэснээс дүгнэвэл Монгол Улс Зөрчлийн тухай хууль дахь торгуулийн шийтгэл оноох зохицуулалт, системээ өөрчлөн сайжруулах шаардлагатай байгаа нь тод харагдаж байна. Ийнхүү судалгааны дараагийн хэсэгт гадаад орнуудын сайн жишгийг судлах болно.

10 Ц.Цогт, “Захиргааны хариуцлага” ба “эрүүгийн хариуцлага” (англо-саксоны эрх зүйн системийн жишээ) <https://legaldata.mn/b/395> (Сүүлд үзсэн: 2021.11.23).

11 Г.Ганбаатар, Л. Оюунчимэг, “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” шүүх эрх мэдэл сэтгүүл №4(2017), 104 дэх тал.

12 М.Чинбат, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудал <http://prokuror.mn/blog/on/4408> (сүүлд үзсэн: 2021.11.23).

ХОЁР. ГАДААДЫН БУСАД ОРНЫ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНД

Хууль зүйн шинжлэх ухаан өндөр хөгжсөн улс орнуудад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд захиргааны байгууллага хийгээд хэв журам сахиулагч цагдаагийн албан хаагч нарт прокурорын хяналтгүйгээр эхний арга хэмжээ болох сануулах, бага дүнгээр торгох зэргээр бие даан анхны шийдвэр гаргах эрхийг өгдөг байна. Ингэснээр шүүх, прокурорын байгууллагуудын ачааллыг бууруулахаас гадна зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчилд холбогдогчийн цагийг хэмнэх, дахин зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд өндөр ач холбогдолтой байдаг ажээ. Иймд энэ хэсэгт зарим гадаад зарим орнуудын эрх зүйн зохицуулалтуудыг дэлгэрүүлэн авч үзлээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

1.1 Үндсэн ойлголт

ХБНГУ-д зөрчлийн захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахад 1968 онд батлагдсан Захиргааны зөрчлийн тухай хууль (OWiG) үйлчилдэг. Германы хууль тогтоомжид захиргааны зөрчил нь эрүүгийн эрх зүйн ял оноох агуулгад үл харьяалагдах хэдий ч шийтгэл оногдуулахуйц гэм буруутай үйлдэл юм. Энэ нь эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй, харин хуулиар торгууль ногдуулдаг (§1 Abs.1 OWiG) ба Захиргааны зөрчлийн тухай хуулийн дийлэнх хэсэг захиргааны эрх зүйд (захиргааны шийтгэл) харьяалагддаг.¹³ Захиргааны зөрчлийн тухай хууль нь хэд хэдэн догматик нарийн зүйлсийг эс тооцвол материаллаг эрүүгийн эрх зүйд загвартай байдаг ч тус хууль нь процедурын заалтуудыг мөн агуулдаг. Хэрэв зөрчлийн үйлдэл нь эрүүгийн болон захиргааны зөрчлийн шинжийн аль алиныг нь хангасан бол эрүүгийн хуулийг удирдлага болгож (§21 OWiG), прокурорын байгууллага хариуцдаг (§40 OWiG).¹⁴ Захиргааны зөрчлийн тухай хуулиар анх удаа зөрчлийн хэрэг үйлдсэн болон давтан гэмт хэрэг үйлдсэн хүмүүст ялгамжтай буюу давтан үйлдэгсдэд хүндрүүлсэн шийтгэл оногдуулахын тулд ялгаж байдгаараа онцлогтой.

1.2 Сануулах шийтгэл

ХБНГУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 56 дугаар зүйлд¹⁵ сануулах шийтгэл оногдуулах талаар дараах байдлаар хуульчилжээ.

(1) Ялимгүй шинжтэй зөрчил гаргасан тохиолдолд захиргааны байгууллага холбогдох этгээдэд анхааруулж, таваас тавин таван еврогийн торгууль оногдуулж болно. Сануулах шийтгэлийг торгууль оногдуулахгүйгээр өгч болно.

13 Administrative offences, <https://criminal-law-germany.lawyer/administrative-offences/> (Сүүлд үзсэн: 2021.11.23).

14 Мөн тэнд.

15 Act on Regulatory Offences in the version published on 19 February 1987 (Federal Law Gazette [Bundesgesetzblatt] I p. 602), last amended by Article 5 para. 15 of the Act of 21 June 2019 (Federal Law Gazette I, p. 846) https://www.gesetze-im-internet.de/englisch_owig/englisch_owig.html#p0329 (Сүүлд үзсэн: 2021.11.23).

(2) 1-р хэсгийн эхний өгүүлбэрт заасан сануулах шийтгэл нь зөвхөн татгалзах эрхийнхээ талаар мэдэгдсэн холбогдох этгээд сануулах шийтгэлийг зөвшөөрч, захиргааны байгууллагаас шаардсан торгуулийг нэн даруй буюу долоо хоногийн хугацаанд түүнд заасан агентлаг эсвэл шуудангийн газарт тухайн байгууллагад төлсөн тохиолдолд л хүчин төгөлдөр болно. Холбогдох этгээд сануулах шийтгэлийн торгуулийг нэн даруй төлөх боломжгүй эсвэл торгууль арваас дээш еврогийн хэмжээтэй бол хугацааг тогтоож болно.

(3) 1-р хэсгийн эхний өгүүлбэрт заасны дагуу сануулах шийтгэлийн торгууль, төлбөрийн хэмжээ, шаардлагатай бол төлбөрийн тогтоосон хугацааны талаар сануулга өгөх гэрчилгээг үнэ төлбөргүй олгож болно.

1.3 Торгох шийтгэл

Түүнчлэн ХБНГУ-ийн Захиргааны зөрчлийн тухай хуульд торгууль оноох, торгуулийг хялбар аргаар төлүүлэх талаар тус хуулийн 17, 18-р зүйлд дараах байдлаар хуульчилсан байна.¹⁶

(1) Торгуулийн хэмжээ нь таван еврогоос багагүй, хуульд өөрөөр заагаагүй бол нэг мянган еврогоос хэтрэхгүй байна.

(2) Санаатай болон болгоомжгүй зөрчлийн үйлдлийг ялгахгүйгээр хууль тогтоомжид заасан торгуулийн дээд хэмжээг оногдуулахаар бол болгоомжгүйгээр үйлдэгдсэн зөрчилд оноох торгуулийн дээд хэмжээ нь торгуулийн дээд хэмжээний хагасаас хэтрэхгүй байна.

(3) Захиргааны зөрчлийн нөхцөл байдал болон зөрчил үйлдэгчид оноох шийтгэл нь торгуулийн үнэлгээний үндэслэл болно. Зөрчил үйлдэгчийн санхүүгийн байдлыг мөн харгалзан үзнэ; гэвч хуульд заасны дагуу зарим тохиолдолд ялимгүй захиргааны зөрчилтэй холбоотой тохиолдолд хамаарахгүй.

(4) Торгууль нь зөрчил үйлдэгчийн захиргааны зөрчил үйлдэн олж авсан санхүүгийн ашиг орлогоос давсан байна. Хэрэв хуульд заасан дээд хэмжээ нь хүрэхгүй бол торгуулийн хэмжээг нэмэгдүүлж болно.

18-р зүйл. Зөрчлийн хэрэгт холбогдогч санхүүгийн нөхцөл байдлын улмаас торгуулийг нэн даруй төлөх боломжгүй бол түүнд төлөх хугацааг олгох буюу хэсэгчлэн төлөхийг зөвшөөрнө. Мөн тухайн этгээд хугацаандаа төлөөгүй тохиолдолд торгуулийг тогтмол хэсэгчлэн төлөх давуу эрхийг цуцалж болно.

Англи улс

2.1 Үндсэн ойлголт

Англи улсад бүх гэмт хэргийг шүүх шийдвэрлэдэггүй. Цагдаагийн офицерууд болон Crown Prosecution Service (CPS) нь яллахаас өөр арга хэмжээ болгон анхааруулах, сануулах, шийтгэх эрхтэй байдаг.¹⁷ Гэмт хэрэг үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн хүнд албан ёсны сануулгыг цагдаагийн байгууллагаас өгч болно. Сануулга нь харьцангуй хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүст энэхүү сануулга нь хэргийг түргэн шуурхай шийдвэрлүүлэх хэрэгсэл байж болно. Өөрөөр хэлбэл сануулгыг хүлээн авснаар тэд асуудлаа

16 Мөн тэнд.

17 Cambridgeshire constabulary <https://www.cambs.police.uk/information-and-services/Cautions-warnings-penalties>.

хурдан шийдэж, шүүхэд хандах шаардлагагүй болно гэсэн үг юм. Зөрчил үйлдэгч нь тодорхой, найдвартай мэдүүлэг өгч, сануулгын нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрсөн маягтад гарын үсэг зурах ёстой.¹⁸ Насанд хүрэгчдэд зориулсан энгийн сануулгын тогтолцооны хүрээг Хууль зүйн яам - Насанд хүрэгчдэд зориулсан энгийн сануулгын заавар (ХМЯ-ны удирдамж) -д багтаасан болно.¹⁹ Энэ нь гэмт хэрэг хэзээ үйлдэгдсэнээс үл хамааран 2015 оны 4-р сарын 13-ны өдрөөс эхлэн энгийн сануулгатай холбоотой бүх шийдвэрт хамаарах бөгөөд Даргын зааврын 6-р хэвлэл (DG6) болон Crown Prosecutors Code (прокурорын тухай хууль)-тэй хавсарган тусгасан байдаг. Энгийн сануулгыг болзолт сануулгатай андуурч болохгүй (нөхцөл тависан сануулга). Болзолт сануулгыг 2003 оны Эрүүгийн шүүхийн тухай хуулиар нэвтрүүлсэн. Болзолт сануулгын тогтолцооны удирдамжийг Насанд хүрэгчдийн болзолт сануулгын практикийн тухай хууль болон Насанд хүрэгчдийн болзолт сануулгын талаарх удирдамжид багтаасан.

2.2 Сануулах шийтгэлийн ойлголт ба төрөл²⁰

Хууль зүйн яамны удирдамжийн дагуу сануулга нь шударга ёсыг түргэн шуурхай, үр дүнтэй тогтоох, цагдаа, шүүхийн ачааллыг бууруулахын зэрэгцээ зохих зөрчлийг таслан зогсооход чиглэгддэг. Энгийн сануулга бол хэн нэгэн гэмт хэрэг үйлдсэнийг хүлээн зөвшөөрсний дараа цагдаагийн албан хаагчийн гаргаж байгаа албан ёсны мэдэгдэл юм. Болзолт сануулга нь ижил төстэй боловч тухайн зөрчил үйлдсэн хүн хохирогчид нөхөн төлбөр төлөх эсвэл гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө уучлалт гуйх зэрэг тодорхой нөхцөлүүдийг дагаж мөрдөхийг зөвшөөрөх ёстой. Цагдаагийн сануулга нь техникийн хувьд эрүүгийн шийтгэл гэж ангилагддаггүй ч дэлгэрэнгүй мэдээллийг ирээдүйд лавлах зорилгоор цагдаад хадгалдаг бөгөөд хэрэв тухайн хүн ирээдүйд дахин гэмт хэрэг үйлдсэн гэж шийтгэгдсэн бол шүүгч анхааралдаа авч болно. Сануулгыг одоогийн болон ирээдүйн ажил олгогчдод мэдэгдэж болох бөгөөд хэрэв тухайн хүн нь хүүхэд, эмзэг бүлгийн хүмүүстэй ажиллах гэх мэт тодорхой үүрэг гүйцэтгэдэг бол (үүнийг шүүгээгүй бол) мэдэгдэх ёстой байдаг.

Сануулга хүлээн авах нь хэн нэгний Европын Холбооноос гадуур аялах, ажиллах чадварт нөлөөлж болзошгүй тул зарим улс орнууд нэвтрэх виз олгохоос татгалзах эрхтэй.

Болзолт сануулга

Болзолт сануулга нь энгийн сануулгаас өөр бөгөөд яллахаас зайлсхийхийн тулд тодорхой нөхцөлүүдийг дагаж мөрдөх ёстой байдаг. Хөнгөн гэмт хэрэгт 10-аас дээш насны хүн бүрт болзолт сануулга өгч болно. Сануулга өгөхийн тулд яллах хангалттай нотлох баримт байх ёстой бөгөөд зөрчил үйлдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрч, сануулга авахыг зөвшөөрсөн байх ёстой. Гэмт этгээд сануулах нөхцөлийг дагаж мөрдөөгүй тохиолдолд тэднийг баривчлах, гэмт хэрэгт буруутгах боломжтой. Харин тохиролцсон хугацаандаа болзол хангасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр хэргийг хааж болно. Болзолт сануулгыг өгөхдөө хувь хүнд гурван төрлийн нөхцөлийг санал болгож болно.

18 Simple caution (including youth cautions), <https://hub.unlock.org.uk/knowledgebase/simple-caution/>.

19 Cautioning and Diversion, <https://www.cps.gov.uk/legal-guidance/cautioning-and-diversion>.

20 Simple caution, <https://hub.unlock.org.uk/knowledgebase/simple-caution/>.

Үүнд:

- Нөхөн сэргээх нөхцөл нь гэмт хэрэгтнүүдийг цаашид гэмт хэрэг үйлдэхийг нь зогсоохын тулд хандлагаа өөрчлөхөд нь туслах зорилготой. Жишээлбэл, хар тамхины үр нөлөөг таниулах хичээлд хамрагдах гэх мэт.
- Хохирлыг нөхөн барагдуулах нөхцөл нь гэмт хэрэгтнүүдэд тухайн хүнд эсвэл нийгэмд учруулсан хохирлоо арилгах зорилготой бөгөөд үүнд: учруулсан хохирлоо нөхөн төлөхөд туслах арга хэмжээ байж болно.
- Нөхөн сэргээх, хохирлыг нөхөн барагдуулах нөхцөл тохирохгүй тохиолдолд шийтгэлийн нөхцөлийг сонгоно. Үүнд торгууль ногдуулж болно.

Залуучуудын сануулга

10-17 наснаас дээш насны залуус гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн, алба хаагчид гэмт хэрэг үйлдсэнийг нотлоход хангалттай нотлох баримт байгаа бол залуучуудад сануулга өгч болно.

Өсвөр үеийнхний болзолт сануулга

Өсвөр үеийнхний болзолт сануулга нь өсвөр үеийнхний энгийн сануулгатай адил боловч нэмэлт нөхцөлтэй байдаг. 10-17 насны хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэрэг үйлдсэн болохыг нотлох хангалттай нотлох баримттай бол алба хаагчид санал болгож болно. Сануулга нь яллахаас өөр арга бөгөөд зохих нөхцөлүүдийг Өсвөрийн гэмт хэрэгтэй тэмцэх баг (ҮОТ) үнэлгээний дараа зөвлөнө. ҮОТ нь нөхцөлийг дагаж мөрдөхийг хариуцдаг бөгөөд хэрэв нөхцөлийг дагаж мөрдөөгүй бол анхны гэмт хэрэг үйлдсэний төлөө хариуцлага хүлээлгэж болзошгүй. Тус сануулга нь гэмт хэргийн ихэнх бүртгэлд харагдана.

Зөвшөөрөгдөх зан үйлийн гэрээ

Энэхүү гэрээ нь хувь хүн болон цагдаа, орон нутгийн засаг захиргаа эсвэл бүртгэлтэй нийгмийн өмчлөгчдийн хооронд сайн дурын бичгээр байгуулсан гэрээ юм. 18 нас хүрээгүй залуу хүнд өгөхдөө эцэг эх, асран хамгаалагчид нь мөн гэрээ олгодог. Ярилцлагын үеэр тухайн хүн нийгмийн эсрэг үйл ажиллагаа явуулахгүй байхыг зөвшөөрсөн тохиолдолд гэрээний нөхцөлийг тохиролцсон болно. Гэрээнд тэдний эцэг, эх, асран хамгаалагч, гэрээнд үйлчилж буй байгууллагын төлөөлөгч, орон нутгийн цагдаагийн ажилтанг байлцуулан гарын үсэг зурна.

Олон нийтийн нөхөн төлбөр

Олон нийтийн нөхөн төлбөр нь нутгийн иргэдэд гэмт хэрэгтнүүдийн учруулсан хохирлоо хэрхэн арилгах талаар санал бодлоо илэрхийлэх боломжийг олгодог. Энэ нь ихэвчлэн гэмт хэрэгтнийг нутгийн сургууль, шашны бүлгүүд, сүм хийдүүд, буяны байгууллага, олон нийтийн байгууллагуудад нийгэмд тустай цалингүй ажил хийлгэдэг. Зөрчил гаргагчид долоо хоногт дор хаяж зургаан цагийн олон нийтийн нөхөн төлбөрийн ажлыг хийх ёстой бөгөөд төслийг 12 сарын дотор дуусгах ёстой. Ийм төрлийн ажил хийж байгаа гэмт хэрэгтнүүд дээр нь «Олон нийтийн нөхөн төлбөр» гэсэн бичигтэй хүрэм өмсдөг байна.

Сануулгад өртөж болзошгүй амьдралын талбарууд

Цагдаа нар сануулга бол зүгээр л «бугуйг алгадах» гэж үздэг бөгөөд олон хүмүүсийн хувьд энэ нь тэдний амьдралд маш бага нөлөө үзүүлдэг. Зарим хүмүүсийн хувьд сануулга нь ажил эрхлэлт, боловсрол, даатгал, аялал, ирээдүйн шүүх хуралдаанууд зэрэгт илүү ноцтой бөгөөд байнгын үр дагавартай байдаг.

2.3 Цагдаагийн байгууллагаас торгуулийн мэдэгдэл гаргах

Торгуулийн мэдэгдэл нь шийтгэлийн нэг төрөл юм. Цагдаагийн албан хаагчид тодорхой зөрчил гаргасан 18 ба түүнээс дээш насны хүмүүст торгуулийн мэдэгдэл гаргаж болно. Торгууль нь 45.00 фунт стерлинг эсвэл 85.00 фунт стерлинг байж болох бөгөөд гэмт хэрэгтнүүдийн 5.00 фунт стерлингийн хураамжийг багтаасан болно. Цагдаа нар зарим төрлийн зөрчилд яллахын оронд торгуулийн мэдэгдэл өгөх боломжтой.²¹ Хэрэв торгуулийн мэдэгдлийг хүлээн авбал төлбөрөө бүрэн төлөх эсвэл шийдвэрлэсэн өдрөөс хойш 28 хоногийн дотор шүүхээр хэлэлцүүлэхийн аль нэгийг сонгож хүсэлт гаргах ёстой. Торгуулийн мэдэгдэлд торгуулийг хэрхэн төлөх эсвэл шүүх хуралдаанд оролцохыг хэрхэн хүсэх талаар тайлбарласан байдаг. Хэрэв торгуулийн мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн боловч 28 хоногийн дотор торгуулиа төлөөгүй эсвэл шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргахгүй бол торгууль 50 хувиар нэмэгдэнэ. Жишээ нь 60,00 фунт стерлинг нь нэмэгдэж 120,00 фунт стерлинг болно. Тухайн шүүхээс оногдуулсан торгуулийн шийтгэлийн мэдэгдлийг хэрэгжүүлэхийн тулд шүүх ч бас оролцоно. Хэрэв торгуулийн мэдэгдлээс татгалзвал цагдаагийн ажилтан өөр арга хэмжээ авах, тэр дундаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой. Торгуулийн мэдэгдлийг хүлээн зөвшөөрч торгуулиа төлснөөр нь гэм буруугаа хүлээн зөвшөөрөх шаардлагагүй бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэхгүй. Торгуулийн мэдэгдэл өгсөн тухай тэмдэглэл хөтөлж, цаашид торгуулийн мэдэгдэл хүлээн авах боломжтой эсэхийг шийдэхэд энэ мэдээллийг ашиглана. Торгуулийн мэдэгдэл нь анх удаа болон хөнгөн төрлийн зөрчил үйлдсэн этгээдэд гэмт хэргийн бүртгэлд орохоос зайлсхийх боломжийг олгодог. Харин давтан зөрчил үйлдсэн этгээдэд энэ нь боломжгүй болдог байна.

2. Ирланд улс

3.1 Насанд хүрэгчдэд анхааруулах тогтолцоо²²

2006 оны 2-р сард Ирландад насанд хүрэгчдийг (өөрөөр хэлбэл 18-аас дээш насны хүмүүсийг) эрүүгийн хариуцлагад татахаас өөр шинэ тогтолцоо хэрэгжиж эхэлсэн. Уг тогтолцоог насанд хүрэгчдийн анхааруулах тогтолцоо гэж нэрлэдэг бөгөөд тухайн хүн зөрчил үйлдсэнийг нотлох баримт байгаа бөгөөд ийм зөрчилд яллах нь нийтийн ашиг сонирхолд хамаарахгүй тохиолдолд яллахаас өөр хувилбар байж болдог. Энэхүү тогтолцоог хэрэглэж болох хэд хэдэн тодорхой эрүүгийн гэмт хэрэг (зөрчил) байдаг. Ирланд Улс нь «An Garda Síochána» хэмээх үндэсний иргэний цагдаагийн албатай бөгөөд «Ирландын энх тайвны хамгаалагчид» гэсэн утгатай. Энэ нь 14,500 ажилтантай бөгөөд орон нутгийн болон үндэсний хууль

21 enforcement in Ireland, <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Europe/IRELAND>.

22 Adult Cautioning Scheme, https://www.citizensinformation.ie/en/justice/law_enforcement/adult_cautioning_scheme.html#.

сахиулах үйлчилгээ үзүүлдэг. Үүнийг ихэвчлэн «Гарда» гэж нэрлэдэг.²³ Хэрэв уг тогтолцоонд тусгагдсан эрүүгийн зөрчлийн аль нэгийг үйлдсэн гэж сэжиглэж байгаа бол анхааруулах шийдвэрийг (яллахын оронд) орон нутгийн Гардагийн ахлах ажилтан (эсвэл орон нутгийн ахлагчаар ажиллаж байгаа Гарда байцаагч) гаргадаг. Сануулга өгөх эсэхээ шийдэхдээ Гарда дараах зүйлийг анхаарч үзэх ёстой:

- Сэжиглэгдсэн төлөв байдал;
- Орчны нөхцөл байдал;
- Гэм буруугүй нотлох баримт;
- Нийтийн ашиг сонирхол;
- Хохирогчийн санал;

Хэрэв тухайн зөрчил үйлдэгч тодорхой асуудлаар сануулга хүлээн авахад бэлэн байгаа бол Гардагийн ахлах ажилтан яллахгүй гэж үзэж байгаагаа мэдэгдэх болно. Цаашид ийм төрлийн зөрчил үйлдвэл эрүүгийн хариуцлага хүлээнэ гэдгийг анхааруулна.

Нийтийн ашиг сонирхол гэж юу вэ?

Прокурорын оронд анхааруулах шийдвэр гаргах нь ноцтой чухал шийдвэр бөгөөд Гардагийн ахлах ажилтан тухайн зөрчил нь анхааруулахад тохиромжтой гэдэгт итгэлтэй байх ёстой. Энэ нь зөвхөн уг тогтолцооны нэг хэсэг болох зөрчлийн хуваарьт багтсан гэсэн үг биш юм. Энэ нь зөрчил үйлдсэн тодорхой нөхцөл байдлыг авч үзэх зайлшгүй шаардлагатай гэсэн үг. Хэрэв тухайн нөхцөлд нийтийн эрх ашгийн үүднээс яллах шаардлагагүй бол сануулга өгч болно.

Нийтийн эрх ашгийг тодорхойлоход анхаарах өөр нэг зүйл бол гэмт этгээд юм. Жишээлбэл, насанд хүрсэн, урьд нь ял шийтгэл хүлээгээгүй хүнд анхааруулах шийтгэл өгөх нь үр дүнтэй байх магадлалтай бөгөөд ирээдүйд ижил төстэй зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх боломжтой эсэхийг анхаарч үзэх ёстой байдаг. Гэсэн хэдий ч ердийн гэмт хэрэгтнийг уг тогтолцоонд оруулах нь зохимжгүй байх магадлалтай.

Хохирогчийн саналыг хэрхэн авч үздэг вэ?

Сануулга өгөх шийдвэр гаргахын өмнө бүх хохирогчийн саналыг боломжтой бол Гардагаас авах ёстой. Хэрэв хохирогч сануулга өгөх ёсгүй гэж үзэж байгаа бол шийдвэр гаргахаас өмнө хохирогчийн санал болгож буй аливаа шалтгааныг Гардагийн ахлах мэргэжилтэн харгалзан үзэх ёстой. Гэсэн хэдий ч хохирогч эсэргүүцэж байлаа ч ахлах ахлагчаас сануулга өгөх боломжтой. Ийм тохиолдолд Гарда сануулга өгөх эсэхээ шийдэхээсээ өмнө Улсын прокурорын газрын даргаас зөвлөгөө авч болно. Хэрэв хохирогчдод нөхөн төлбөр өгөхийг санал болговол энэ нь сануулга өгөх аливаа шийдвэрийг дэмжинэ. Мөн анхааруулах шийдвэр нь зөвхөн нөхөн олговортой холбоотой асуудал биш юм.

3.2 Анхааруулах журам

Ахлах ахлагчаар ажиллаж байгаа Гарда байцаагч насанд хүрэгчдэд зориулсан сануулгыг удирддаг. Тухайн зөрчил үйлдэгч сануулгыг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр гаргаж, сануулгыг бүртгэж цаашид ямар нэгэн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн

23 Law enforcement in Ireland, <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Europe/IRELAND>.

хэргээр шийтгэгдсэн тохиолдолд шүүхэд мэдэгдэн, шүүхээр шийдвэрлэнэ гэдгийг эсэргүүцэхгүй байх ёстой. Анхааруулах санаа нь үүнийг зөвхөн нэг удаа зөрчил үйлдсэн этгээдэд хэрэглэх ёстой байдаг, гэсэн хэдий ч (зөвхөн хамгийн онцгой тохиолдолд) өмнө нь сануулга авч байсан хүнд дахин сануулга өгч болдог. Ийм онцгой нөхцөл байдлын жишээнд:

- Анхны сануулга өгснөөс хойш урт хугацааны завсарлагатай байсан бөгөөд ахлах ахлагч ийм хугацаа өнгөрсний дараа хоёр дахь удаагаа сануулга өгөх нь тухайн хүнд ашигтай гэж үзэж байгаа бол ахлах ажилтан Гарда нь эхлээд Улсын яллах газрын даргын зөвшөөрлийг авах ёстой. Насанд хүрэгчдийн анхааруулах тогтолцоонд хамрагдах гэмт хэрэг, зөрчлийн жагсаалт дараах байдалтай байна.

Эрүүгийн шүүх (Нийтийн хэв журам хамгаалах)-ийн тухай хууль 1994 он

4-р хэсэг: Олон нийтийн газар согтуурах

5-р хэсэг: Олон нийтийн газар эмх замбараагүй байдал үүсгэх

6-р хэсэг: Олон нийтийн газар заналхийлэх, доромжлох, хүч хэрэглэх

8-р хэсэг: Гардагийн заавар (тушаал)-ыг дагаж мөрдөхгүй байх

9-р хэсэг: Санаатайгаар саад учруулах (санаатай саад)

11-р хэсэг: Гэмт хэрэг үйлдэх зорилгоор барилга руу орох

13-р хэсэг: Айдас төрүүлэхүйц байдлаар барилга руу нэвтрэх гэх мэт (зөвхөн 2020 оны 12-р сарын 14-ний өдрөөс үйлдсэн гэмт хэргийн хувьд)

21-р хэсэг: Олон нийтийг хянах хязгаарлалтыг дагаж мөрдөхгүй байх (зөвхөн 2020 оны 12-р сарын 14-ний өдрөөс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хувьд)

Эрүүгийн шүүх (Хулгай, залилангийн гэмт хэрэг)-ийн тухай хууль 2001 он

4-р хэсэг: Хулгай эд хөрөнгийн үнэ 1000 еврогоос хэтрэхгүй

17-р хэсэг: Хулгайлагдсан эд хөрөнгөтэй харьцах (холбогдох эд хөрөнгийн үнэ 1000 еврогоос бага байвал)

18-р хэсэг: Хулгайлагдсан эд хөрөнгийг эзэмших (холбогдох хөрөнгийн үнэ 1000 еврогоос бага бол)

Согтууруулах ундааны тухай хууль 2003 он

6-р хэсэг: Согтуу хүний үйлдсэн зөрчил

8-р хэсэг: Эмх замбараагүй байдал үүсгэх

Хүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль 1997 он

2-р хэсэг: Халдлага – хөнгөн зэргийн халдлага (Гардагийн гишүүдэд халдсан хэргийг прокурорын газрын даргад хэлэлцүүлэхээр шилжүүлнэ)

Гэмт хэргийн хохирлын тухай хууль 1991 он

2-р хэсэг: Эд хөрөнгийг гэмтээх (гэмтсэн эд хөрөнгийн үнэлгээ 1000 еврогоос бага бол)

3-р хэсэг: Эд хөрөнгөд хохирол учруулахаар заналхийлэх

Мансууруулах бодисын зүй бус хэрэглээний тухай хууль 1977 он

3-р хэсэг: Каннабис эсвэл каннабисын давирхайг эзэмших (зөвхөн 2020 оны 12-р сарын 14-ний өдрөөс үйлдсэн гэмт хэргийн хувьд)

1995 оны Энгийн Худалдааны хууль

3-р хэсэг: Зөвшөөрөлгүй эсвэл зөвшөөрөл зөрчсөн арилжаа (зөвхөн 2020 оны 12-р сарын 14-ний өдрөөс үйлдсэн гэмт хэргийн хувьд)

Лицензийн тухай хууль 1872

12-р хэсэг: Олон нийтийн газар согтууруулах ундаа хэрэглэсэн

1842 оны Дублины цагдаагийн хууль

Хэсэг 14(12): Нийтийн замд саад учруулах (Зөвхөн Дублин хотын (Шүүх) дүүрэгт хамаарна)

Хураангуй харьяаллын (Ирланд) 1871 оны нэмэлт өөрчлөлтийн тухай хууль

8-р хэсэг: Театр эсвэл олон нийтийн үзвэр үйлчилгээний газарт бусдыг доромжилсон эсвэл үймээн самуун дэгдээсэн үйлдэл (зөвхөн Дублин хотын (Шүүхийн) дүүрэгт хамаарна)

3.3 Торгууль

Ирланд улсад торгуулийг шүүгчийн шийдвэрээр гэмт хэргийн шийтгэл болгон төлөх ёстой мөнгөн дүн гэж тодорхойлдог. Шүүхээс төлөх ёстой хэмжээ, торгуулийг төлөх өдрийн тоог тогтоодог. Шүүх хуралдааны дараа торгуулийн мэдэгдэл гаргадаг байна.²⁴

Торгуулийн төрөл сонголтууд:

Торгуулийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн төлөх боломжтой бөгөөд торгуулийг шүүхийн аль ч газар, шуудан эсвэл цахимаар шүүгчийн зөвшөөрсөн хугацаанд бүрэн төлнө.

Дараах тохиолдолд шуудангийн салбаруудад хэсэгчлэн төлөх боломжтой:

- Торгууль нь 100.00 еврогоос дээш бол;
- Шүүхээс торгууль ногдуулснаас хойш 42 хоногийн дотор эхний төлбөрийг төлсөн бол;
- Эхний төлбөр нь торгуулийн 10% -тай тэнцэх буюу түүнээс дээш бол.

Хэрэв хэсэгчлэн төлөхөөр шийдсэн бол торгуулиа бүрэн төлөхөд нэг жил 42 хоногийн хугацаа байдаг. Эхний төлбөрийн дараа, дараагийн төлбөр бүрийг өмнөх төлбөрөөс хойш 30 хоногийн дотор төлөх ёстой (хамгийн багадаа €5.00). Эхний хэсгийг төлсний дараа төлбөрийн төлөвлөгөөг хүргүүлдэг. Эхний төлбөрийг шүүхийн шийдвэр гарснаас хойш зургаан долоо хоногийн дотор төлөх ёстой. Хэрэв төлөөгүй бол торгуулийн дүнг бүрэн төлөх ёстой бөгөөд хэсэгчлэн төлөх боломжгүй болдог.

24 Fines imposed district court, <https://www.courts.ie/fines-imposed-district-court>.

Торгууль төлөөгүй тохиолдолд авах арга хэмжээ

Хэрэв тухайн зөрчил үйлдэгчийн торгууль төлөгдөөгүй эсвэл хугацаа нь дуустал хэсэгчлэн төлөхгүй бол торгуулийн гүйцэтгэлийн мэдэгдэл илгээнэ. Уг мэдэгдэлд өөр шүүх хуралд оролцох ёстой огноо, цагийг тусгасан байдаг. Тус шүүх хурлаар торгуулийн үлдэгдэл төлбөрөө бүрэн төлөх боломжийг олгох эсвэл шүүгч дараах (дараалалтайгаар) арга хэмжээнүүдээс аль нэгийг сонгож болно.

- Орлогын хавсралт нэхэх;
- Нөхөн сэргээх захиалга - зөвхөн 500 еврогийн торгууль эсвэл байгууллагын торгууль;
- Нийтийн үйлчилгээ;
- Хорих.

3. Австрали улс

4.1 Сануулах шийтгэл

«Сануулга» гэдэг нь цагдаагийн байгууллагаас гаргадаг, зөрчил үйлдсэн этгээдэд дараагийн шатны хууль ёсны арга хэмжээ авахаас зайлсхийх боломжийг олгодог нэг төрлийн арга юм.²⁵

Цагдаагийн сануулга нь цаашид зөрчил гаргахаас сэргийлэхийн тулд хуульд заасны дагуу бүртгэлжүүлж байгаа хэлбэр юм. Австралид сануулгын арга хэмжээг авах нь прокурор, шүүхэд хэрэг шийдүүлснээс оронд цагдаагийн байгууллагын шатанд сануулга өгөх нь зөрчил үйлдэгч дахин зөрчил үйлдэх магадлалыг бууруулдаг гэж үздэг. Учир нь тухайн хүнд итгэж, итгэлцлийн үүднээс сануулга өгч өөр шийтгэл оногдуулалгүй өнгөрч байгаа нь зөрчил үйлдэгчид эерэгээр нөлөөлж дахин ижил төстэй зөрчил үйлдэхгүй байх дээр анхаардаг байна. Цагдаагийн байгууллагаас зөвхөн тодорхой хүчин зүйлийг харгалзан сануулга өгч буй ач холбогдол нь гэмт хэргийг шүүхэд шийдүүлэхээс сэргийлдэг. Гэмт хэргийн тухай хууль, Цагдаагийн тухай хуульд сануулгын арга хэмжээг зохицуулсан байдаг.

Сануулах арга хэмжээ авахын тулд:

- Тухайн хүний эсрэг Prima Facie хэрэг үүсгэх ёстой.
- Сануулга хүлээн авсан этгээд зөрчлөө хүлээн зөвшөөрөх ёстой.
- Гэмт этгээд нэмэлт нөхцөл, түүний дотор сануулгыг хүлээн зөвшөөрөх ёстой.
- Сануулга нь цагдаагийн түрүүчээр батлагдсан байх ёстой.
- Сануулга нь тухайн зөрчилд тохирсон байх ёстой.

Цагдаагийн ажилтан дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- Гэмт этгээдийн гэмт хэргийн түүх (хэрэв байгаа бол);
- Хохирогчийн үзэл бодол; (хэрэв тэд сануулга өгөх нь хангалттай гэж үзвэл)
- Цагдаагийн дүгнэлт; (хэрэв тэд сануулга өгөх ёстой гэж үзвэл)
- Гэмт этгээд гэмшсэн, хохирол барагдуулах эсэхээ ямар нэгэн байдлаар илэрхийлсэн буюу оролдсон бол;
- Зөрчлийн зэрэг

25 National Police Checks, <https://www.australiannationalcharactercheck.com.au/Cautions-and-Police-Checks.html>.

Австралийн цагдаагийн байгууллагаас дараах сануулгыг өгсөн байна. Жишээ болгон дор дурдав:

- Гэмт хэрэгт холбогдож байгаагүй 86 настай эрэгтэй хэдхэн долларын үнэтэй хүнсний бараа хулгайлсан байна. Саяхан эхнэрээ нас барсны дараа тэрээр сэтгэлийн зовууртай байсан. Хожим нь тэрээр хулгайлсан хүнсний мөнгөө бүрэн төлсөн.
- Сүмийн буяны савнаас хувцас авч явсан 76 настай эрэгтэй. Улмаар хулгай хийснээ цагдаад хүлээсэн байна. Тэрээр гэмт хэргийн түүхгүй бөгөөд хийсэн хэрэгтээ харамсаж байв.
- Олон нийтийн арга хэмжээн дээр согтуу байсан 18 настай эмэгтэй; цагдаа болон бусад хүмүүсийг харааж зүхсэний дараа баривчлагджээ. Тэрээр ямар нэгэн гэмт хэргийн түүхгүй.

Насанд хүрээгүй хүүхдүүдэд цагдаагийн сануулга өгдөг үү?

Австралийн Залуучуудын болон Насанд хүрээгүй хүүхдүүдийн шүүх байгууллагын ачаалал их байдаг бөгөөд “хөнгөвтөр” зөрчлүүдийг яллах нь ачаалал нэмэгдүүлэх магадлалтай гэжээ.

Тиймээс, зохих (хөнгөн зэргийн) зөрчлийн хувьд Цагдаагийн байгууллага тэднийг шүүхэд шилжүүлэхээс илүүтэй албан бус сануулга өгдөг. Хөнгөн зэргийн зөрчлийг цагдаагийн алба хаагч “газар дээр нь” сануулга өгснөөр шийдвэрлэх боломжтой бөгөөд үүнийг цагдаагийн албан бус сануулга гэж нэрлэдэг. Албан бус сануулга өгсөн тохиолдолд ямар ч шийтгэл оногдуулахгүй, харин өсвөр үеийнхэн гэмт хэргийн мөн чанар, цаашид ижил төстэй зөрчил дахин гаргахгүй байх, мөн сөрөг зан үйлийн үр дагаврыг тодорхой ойлгох ёстой.²⁶ Гэхдээ цагдаагийн байгууллагаас зөвхөн эцэг эх, асран хамгаалагчийг нь байлцуулан сануулга өгөх боломжтой. Насанд хүрээгүй зөрчил үйлдэгчид дараах нөхцөлд сануулга өгнө.

- Хохирогчид хохирлыг барагдуулсан байх, барагдуулахаа илэрхийлсэн;
- Хяналттай/хяналтгүй олон нийтийн үйлчилгээний ажилд оролцох;
- Хохирогчоос уучлалт гуйх;
- Цаашид өөрийн үйл болон биеэ зөв авч явах тал дээр анхаарахаа илэрхийлэх.

4.2 Торгууль

Зам тээврийн торгууль²⁷

Тухайн зөрчил үйлдсэн этгээд торгуулийн шийтгэл авсан өдрөөс хойш 28 хоногийн дотор бүрэн төлөх эсвэл 200 доллар ба түүнээс дээш торгуулийн төлбөрийн төлөвлөгөөг зохиох боломжтой. Кредит эсвэл дебит картаар хийсэн бүх төлбөрт зээлийн картын нэмэлт хураамж ногдуулдаг. Торгуулийг төлөхдөө:

- ВРАУ;
- онлайн;
- шуудангаар;
- биечлэн төлж болно.

26 Young offenders, <https://lawhandbook.sa.gov.au/ch06s07.php>.

27 Fines and enforcement, <https://www.qld.gov.au/transport/safety/fines/pay>.

Төлбөрийн төлөвлөгөөг гаргах

Хэрэв торгуулийн хэмжээ 200 доллар ба түүнээс дээш бол төлбөрийг хуваан төлж болно. Хэрэв торгуулийн төлбөрийн лавлагааны дугаар байгаа бол эхний төлбөрөө онлайнаар, BPAY эсвэл Australia Post-аар төлөх боломжтой. Төлбөрийн лавлагааны дугаар байхгүй бол эхний төлбөрөө тээвэр, автомашины хэрэглэгчдэд үйлчлэх аль ч төв, Квинсландын засгийн газрын агентлагийн хөтөлбөрийн оффис дээр эсвэл шуудангаар чек эсвэл мөнгөн хэлбэрээр захиалга илгээх замаар төлөх боломжтой. Улсын Торгуулийн хэрэг эрхлэх газраас сайн дурын төлбөрийг төлөх хугацаа хэзээ болохыг мэдэгдэх захидал илгээдэг.

Төлбөрийн төлөвлөгөөг тохируулахын тулд дараах зүйлсийг анхаарна.

- Торгуулийн мэдэгдэлд заасан өдрөөс хойш 28 хоногийн дотор \$60-ийн эхний төлбөрийг хийх,
- торгуулийн ард талд дахь төлбөрийн сонголтын хэсгийг бөглөнө (өөрийн сонголтоор «сайн дурын төлбөрийн төлөвлөгөө»-г сонгоно)
- Эхний төлбөрийг онлайнаар хийх (хэрэв зөрчлийн мэдэгдэлд цахимаар төлөх сонголт байгаа бол).

Хугацаа хэтэрсэн торгууль

Шуудангийн илгээмжээр торгууль төлөх тухай сануулгыг илгээгээгүй ч хэрэв цахим сануулагчид бүртгүүлсэн бол хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө цахим сануулга өгнө.

Хэрэв мэдэгдэл хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор торгуулиа төлөх ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол торгуулийн улсын бүртгэлд мэдэгдлийг илгээх бөгөөд торгуулийн төлбөрийг нөхөн төлүүлэх, түүн дээр нөхөн төлүүлэхэд гарч буй аливаа зардлыг нэмэн төлүүлэх арга хэмжээ авах боломжтой. Торгуулийн хяналтын улсын бүртгэлд мэдэгдвэл зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн замын хөдөлгөөний бүртгэлд зөрчлийн оноо тооцогдоно.

Зөрчлийн болон шүүхийн торгуулийг үл тоомсорлох нь тэдгээрийг арилгахгүй.²⁸ Баруун Австралид торгууль төлөхгүй байх тохиолдолд лицензийг түдгэлзүүлэх, банкны данснаас эсхүл цалингаас мөнгө суутгах (гарнижийн захиалга), тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцохыг хориглох, улсын бүртгэлтэй дугаарыг цуцлах, эд хөрөнгийг хураах, худалдах, албадан хөдөлмөр эрхлүүлэх, зэрэг ноцтой үр дагавартай. Магистратын шүүх торгуулийн төлөлтийг хэрэгжүүлэхийн тулд зохих арга хэмжээг авдаг. Хэрэв торгуулийг төлөхөд хүндрэлтэй байгаа бол Торгуулийн бүртгэлийн газартай тохирсон сонголтоо харилцан тохиролцож болно.

Хуулийн хэрэгжилтийн тогтолцоо²⁹

Муж, нутаг дэвсгэр бүр торгууль болон зөрчлийн мэдэгдлийг биелүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авна. Ерөнхийдөө эдгээр нь улсын өр барагдуулах байгууллагад өр төлбөрөө төлж барагдуулаагүй этгээдийн эсрэг шат дараалсан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг олгодог. NSW-ийн хууль эрх зүйн тогтолцоог энэ бүлэгт жишээ болгон ашигласан болно.

28 Fines Enforcement Registry (FER), <https://www.wa.gov.au/service/justice/administrative-law/fines-enforcement-registry-fer>.

29 Fines and infringement notices, <https://www.alrc.gov.au/publication/fines-and-infringement-notice-2/>.

NSW-ийн торгуулийн хэрэгжилтийг 1996 оны Торгуулийн тухай хуулийн (NSW) (хууль) дагуу хуульчилж, Улсын өр барагдуулах (SDR)-аар удирддаг бөгөөд одоо “Орлого NSW” гэж нэрлэгддэг байна. Торгууль барагдуулаагүй этгээдэд албадлагын арга хэмжээг авдаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хураангуй

(1) Торгууль гүйцэтгэх тухай тогтоол гаргасны дараа энэ хэсэгт заасан гүйцэтгэх ажиллагааны хураангуйг доор харуулав.

- (а) Торгуулийн гүйцэтгэлийн захиалгын үйлчилгээ Торгуулийн гүйцэтгэлийн тухай мэдэгдлийг торгууль төлөөгүй этгээдэд хүргүүлж, хэрэв төлбөрөө төлөөгүй бол гүйцэтгэх арга хэмжээ авахыг мэдэгдэнэ.
- (б) Жолооны үнэмлэх, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийг түдгэлзүүлэх, цуцлах, 6 сарын турш төлөгдөөгүй байвал Зам, далайн үйлчилгээний газраас жолооны үнэмлэхийг мөн цуцална.
- (в) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: Хэрэв торгууль төлөөгүй этгээд жолооны үнэмлэх, бүртгэлтэй тээврийн хэрэгсэлгүй, эсхүл Комиссын дарга Зам тээвэр, далайн үйлчилгээний газарт албадлагын арга хэмжээ авахыг үүрэг болгосноос хойш 21 хоногийн дотор торгууль төлөөгүй бол эд хөрөнгийг битүүмжлэх эсвэл торгууль төлсөн этгээдийн эзэмшиж буй газрын төлбөрийг бүртгэх.
- (г) Нийтийн үйлчилгээний тушаал: Хэрэв иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа амжилтгүй болвол торгууль төлөөгүй этгээдэд олон нийтэд тустай ажил хийх тухай тушаал гаргана.
- д) Торгууль төлөөгүй этгээд олон нийтэд тустай ажил хийх тухай тушаалыг биелүүлээгүй бол торгууль төлөөгүй этгээдийн хорих ялыг цагдаагийн алба хаагчид хүлээлгэн өгнө (хүүхдээс бусад) .
- (е) Хуулийн этгээд төлөх торгууль: Торгуулийн гүйцэтгэлийн журам (олон нийтэд тустай ажил хийлгэх, хорихоос бусад) нь хуулийн этгээдийн төлөх торгуульд хамаарна.
- (ё) Торгуулийн шийтгэлийг хөнгөлөх: Торгууль төлөөгүй этгээд төлөхийн тулд нэмэлт хугацаа шаардагдаж болох ба Комиссар торгуулийг бүхэлд нь буюу хэсэгчлэн барагдуулах зорилгоор торгуулийн төлөөгүй хэсгийг хасч эсвэл ажил, бүтээн байгуулалтын захиалга [WDO] гаргаж болно.

3. Оросын Холбооны Улс

5.1 Үндсэн ойлголт

ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн³⁰ 1.2 дугаар зүйлд Захиргааны зөрчлийн тухай хууль тогтоомжийн зорилгыг тусгасан байдаг. Үүнд:

“Захиргааны зөрчлийн тухай хууль тогтоомжийн зорилго нь иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах, иргэдийн эрүүл мэнд, хүн амын ариун цэвэр, эпидемиологийн сайн сайхан байдал, нийтийн ёс суртахууныг хамгаалах, хүрээлэн буй орчныг хамгаалах, төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх тогтоосон журам, нийтийн хэв журам, аюулгүй байдал, өмчийг хамгаалах, захиргааны зөрчлөөс иргэн, хуулийн этгээд,

30 Code Of Administrative Offences Of The Russian Federation, December 30, 2001.

нийгэм, төрийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах түүнчлэн захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх” гэсэн байна. Түүнчлэн тус хуулийн 3.1 дүгээр зүйлд Захиргааны шийтгэлийн зорилго нь захиргааны зөрчил үйлдсэн тохиолдолд төрөөс тогтоосон шийтгэлийн хүрээнд хэрэгжүүлдэг арга хэмжээ бөгөөд түүнийг тухайн зөрчил үйлдсэн этгээд дахин зөрчил үйлдэх болон бусад этгээд шинээр зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлнэ” гэжээ.

Захиргааны зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд заасан Захиргааны шийтгэлийн төрөлд:

- 1) сануулга;
- 2) захиргааны торгууль;
- 3) захиргааны зөрчлийн хэрэгсэл, объектыг нөхөн төлбөртэйгээр хураан авах;
- 4) захиргааны зөрчлийн хэрэглүүр буюу объектыг хураах;
- 5) хувь хүнд олгосон тусгай эрхийг хасах;
- 6) захиргааны баривчлагаа;
- 7) гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ОХУ-аас захиргааны журмаар албадан гаргах;
- 8) эрх түдгэлзүүлэх;
- 9) үйл ажиллагааг захиргааны журмаар түдгэлзүүлэх гэж заасан байгаагаас харахад захиргааны зөрчилд анхааруулах шийтгэл өгдөг болох нь харагдаж байна.

5.2 Сануулах шийтгэл

Мөн ОХУ-ын Захиргааны хуулийн 3.4-р зүйл Сануулга³¹-ыг нарийвчлан тусгасан байна.

1. Сануулга нь хувь хүн, хуулийн этгээдийн албан ёсны шүүмжлэлийг илэрхийлсэн захиргааны шийтгэлийн арга хэмжээ юм. Сануулгыг бичгээр өгдөг.
2. Хүний амь нас, эрүүл мэнд, ургамал, амьтан, хүрээлэн буй орчин, соёлын өв (түүх, соёлын дурсгалт зүйл)-д, ОХУ-ын дурсгалт газар, улсын аюулгүй байдал, байгалийн болон гар аргаар үүссэн байгалийн тогтоц, түүнчлэн эд хөрөнгийн хохирол учруулаагүй тохиолдолд захиргааны зөрчлийг анх удаа үйлдсэн тохиолдолд сануулга өгнө.
3. Анхааруулах хэлбэрээр захиргааны шийтгэл оногдуулах нь энэ хуулийн II хэсэгт заасан эсвэл ОХУ-ын бүрэлдэхүүнд байгаа аж ахуйн нэгжийн захиргааны зөрчлийн тухай хуульд заагаагүй тохиолдолд захиргааны шийтгэл болох захиргааны торгуулийн хэлбэрийг ашгийн бус байгууллага, түүнчлэн хуулийн этгээдийн көвшөөрөлгүй аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй жижиг, дунд аж ахуйн нэгж, албан хаагчид энэ хуулийн 4.1.1-д заасны дагуу сануулга өгч болно.

31 «Кодекс Российской Федерации об административных правонарушениях» от 30.12.2001 N 195-ФЗ (ред. от 01.07.2021, с изм. от 09.11.2021) (с изм. и доп., вступ. в силу с 01.10.2021) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/080d25276289006c381505fe470f240608f4ad77/.

Оросын холбооны улсын Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд Шийтгэлийн төрлүүдийг доорх байдлаар тусгасан байна.³²

- торгууль;
- тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах;
- тусгай болон цэргийн цол, хүндэт цол, төрийн одонг хураах;
- албадан ажил хийлгэх;
- засан хүмүүжүүлэх ажил;
- цэргийн албаны хязгаарлалт;
- эд хөрөнгийг хураах;
- баривчлах;
- сахилгын цэргийн ангид алба хаах;
- эрх чөлөөг нь тодорхой хугацаагаар хасах;
- бүх насаар нь эрх чөлөөг нь хасах;
- цаазаар авах ял.

Үүнээс харвал Эрүүгийн хуулийн шийтгэлийн төрөлд сануулгын шийтгэл байхгүй байна.

5.3 ОХУ-ын торгуулийн төрөл

Орос улсад хууль тогтоомжид хүнд хэлбэрийн гэмт хэргээс гадна хөнгөн хэлбэрийн гэмт хэргийн талаар хуулийн зохицуулалттай бөгөөд хөнгөн хэргийн гэмт хэрэгт ихэвчлэн захиргааны торгууль оногдуулахаар хуульчилсан байдаг.

BMS хуулийн фирмийн GR-практикийн дарга Дмитрий Леснякийн хэлснээр торгуулиа төлөхгүй байх нь Орост дараагийн захиргааны арга хэмжээ авахад хүргэдэг - хүн хоёр дахин их мөнгө төлж, баривчлагдах эрсдэлд орох эсвэл олон нийтийн албадан ажил хийх шаардлагатай болдог. Тухайлбал, бусдыг үл хүндэтгэсэн (садар самуун үг хэллэг хэрэглэх, бусдын эд хөрөнгөд хохирол учруулах гэх мэт) олон нийтийн газар зүй бус авир гаргасан бол 500-1000 рублийн (8-16 доллар) захиргааны торгууль ногдуулах, эсвэл 15 хоног хүртэл хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулдаг.

“Торгуулийн дийлэнх нь 20-40 км/цагийн бүсэд хурд хэтрүүлсэнтэй холбоотой байдаг. Хурд хэтрүүлсний торгууль нь 500 рубль (8 доллар) гэж заасан байдаг ба торгуулийн 50 хувийг эхний 20 хоногт төлж болно.”³³

2016 оны 1-р сарын 1-ээс эхлэн жолооч нар захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэр гарснаас хойш 20 хоногийн дотор төлсөн бол ногдуулсан торгуулийн хагастай тэнцэх хэмжээний төгрөгөөр замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн захиргааны торгууль төлөх боломжтой болсон. Энэхүү заалтыг 2014 оны 12-р сарын 22-ны өдрийн 437-ФЗ Холбооны хуулиар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр захиргааны зөрчлийн шийтгэлийг нөхөн сэргээхтэй холбоотой ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу батлагдсан. 2016 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон.³⁴

32 The Criminal Code of the Russian Federation, 1996

33 Ksenia Zubacheva, Russia Beyond, 2019

34 The official website of the Ministry of Internal Affairs of the Russian Federation, 2021 <https://en.mvd.ru/news/item/7064770>

Гэсэн хэдий ч замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн тохиолдолд торгуулийн дүнгийн хагасыг төлөх боломжийг олгодоггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь замын хөдөлгөөний дүрмийг ноцтой, бүдүүлэг зөрчсөн бүхэл хүрээг хамардаггүй. Тодруулбал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон жолооч шалгуулахаас татгалзсан тохиолдолд захиргааны шийтгэлээр тогтоосон төлбөрийг бүрэн төлөх ёстой. Мөн хүний амь нас хохироосон зам тээврийн осол гаргасан жолоочид захиргааны шийтгэл оногдуулах, захиргааны шийтгэл оногдуулсан тохиолдолд бүрэн барагдуулна гэж заасан байдаг.

Хурдны дээд хязгаарыг 40 км/цаг-аас дээш хэтрүүлсэн, гэрлэн дохиог зөрчих, эсрэг урсгалын эгнээгээр дүрэм зөрчин замын хөдөлгөөнд оролцох, бүртгэлгүй тээврийн хэрэгсэл жолоодох зэрэг зөрчлийг давтан үйлдсэн бол захиргааны шийтгэлийг бүхэлд нь хэрэгжүүлнэ.

Хурд хэтрүүлсний зарим нийтлэг торгууль нь:³⁵

Зөрчил	Шийтгэл
Хурдны хязгаарыг 10-20 км/цагаар хэтрүүлсэн	Анхааруулах эсхүл 100 рубль торгууль
Хурдны дээд хязгаарыг 20-40 км/цагаар хэтрүүлсэн	300 рублиэр торгох
Хурдны хязгаарыг 40-60 км/цаг хэтрүүлсэн	1000-1500 рублиэр торгох
Хурдны дээд хязгаарыг 60 км/цагаас хэтрүүлсэн	2000-2500 рублиэр торгох, эрхийг 4-6 сараар хасах эсхүл эрхийг нь түдгэлзүүлнэ

Эцэст нь дээрх зарим улс орны жишээнээс харахад торгууль оногдуулаад, торгуулиа төлүүлэх арга хэмжээ аван заасан хугацаанд сайн дураар төлөөгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэн дараагийн шатны арга хэмжээ авдаг нь торгуулийг үр дүнтэй болгох бас нэгэн шийдэл мэт харагдаж байна. Торгууль тавиад эргээд торгуулийг төлүүлэх нарийн тогтолцоотой байх нь чухал байна.

35 Road Rules and Regulations in Russia, <https://www.angloinfo.com/how-to/russia/transport/driving/on-the-road>

ДҮГНЭЛТ

Тус судалгааны хүрээнд сонгон авч судалсан улсуудын жишгээс харахад Эрүүгийн холбогдолтой зөрчлийг Эрүүгийн хууль болон түүнтэй холбогдох хуулиудаар харин Захиргааны зөрчлийг Захиргааны тухай хууль болон Захиргааны зөрчлийн тухай хуулиар зохицуулдаг байна. Энэ нь хуулийг ойлгох, хэрэглэх, хэрэгжүүлэхэд илүү ойлгомжтой хялбар бөгөөд харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд мөн хуулийн зарчмыг баримтлахад ач холбогдолтой харагдаж байна.

Судалсан зарим орнуудын сануулах шийтгэлийг нэгтгэн дүгнэхэд ХБНГУ нь хөнгөн шинжтэй зөрчилд бага дүнтэй торгууль ногдуулах эсвэл сануулгын арга хэмжээ авдаг ба анх удаа болон давтан зөрчил үйлдэгчид ялгамжтай байдлаар шийтгэл оногдуулах тал дээр анхаарсан байна. Харин Англи улс сануулах шийтгэлийн олон төрөл болох энгийн сануулга, болзолт сануулга, залуучуудын сануулга, залуучуудын болзолт сануулга гэж ангилан зөрчил үйлдсэн хүний нас, амьдралын нөхцөл байдал, зан үйлийн байдал гэх зэргийг харгалзан үзэж эдгээр төрлүүдээс сонгон сануулга өгөх боломжтой нь давуу харагдаж байна. Мөн Англи улсын бас нэгэн ач холбогдолтой сануулах шийтгэлийн төрөл нь зөвшөөрөгдөх зан үйлийн гэрээ болон олон нийтийн нөхөн төлбөр байна. Зөвшөөрөгдөх зан үйлийн гэрээний үр дүнд тухайн зөрчил үйлдэгчийг цаашид дахин зөрчил үйлдэхээс сэргийлэх бөгөөд өөрийн гаргасан зөрчлөө ухамсарлан ойлгох боломжийг өгч байгаа юм. Харин олон нийтийн нөхөн төлбөрийн төрөл нь нутгийн иргэдэд гэмт этгээдийн учруулсан хохирлоо хэрхэн арилгах талаар санал бодлоо илэрхийлэх боломжийг олгодгоороо давуу талтай бөгөөд ихэвчлэн зөрчил үйлдэгчийг сүм хийд, буяны байгууллага, сургууль гэх зэрэг газруудад нийгэмд тустай цалингүй ажил хийлгэдэг нь эргээд нийгэм болоод олон нийтэд тустайгаас гадна тухайн хүний зан байдал хүмүүжилд нөлөөлөх үр дүнтэй шийтгэлийн арга болохыг онцолсон.

Ирланд улсын хувьд сануулах шийтгэл оногдуулахдаа нийтийн эрх ашиг болон хохирогчийн санаа бодлыг чухалчилж үзэн шийдвэр гаргадаг нь давуу харагдсан юм. Австрали улсын хувьд насанд хүрээгүй хүүхэд болон залуучуудад ял оногдуулахыг нэн тэргүүнд тавилгүйгээр сануулга өгөхийг илүүд үздэг. Учир нь Австрали улсад залуучууд, өсвөр насныхны нөхцөл байдал, амьдралын туршлага, шилжилтийн үеийн тогтворгүй сэтгэл зүйн байдал зэргийг харгалзан анхаарах ёстой гэдэг. Мөн прокурор, шүүхийн ачааллыг бууруулах зорилго юм. Харин ОХУ-ын хувьд сануулах шийтгэл нь Захиргааны зөрчлийн шийтгэлийн төрөлд багтдаг бөгөөд Эрүүгийн холбогдолтой зөрчилд сануулах шийтгэл оногдуулдаггүйгээрээ дээрх 3 улсаас ялгаатай.

Торгуулийн шийтгэлийг хэрэгжүүлж буй байдлын хувьд дээрх улсууд оногдуулсан торгуулийг заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд төлүүлэх арга хэмжээ эсхүл дараагийн шатны арга хэмжээг авдаг нь ижил төсөөтэй бөгөөд харин авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь ялгаатай байсан юм. ХБНГУ-ын хувьд болгоомжгүйгээр үйлдэгдсэн зөрчилд санаатайгаар үйлдсэн зөрчилд оноож байгаагаас бага дүнгээр торгууль оногдуулахыг хуульчилсан байх бөгөөд торгууль төлөгч этгээд эдийн засгийн боломжгүй тохиолдолд тодорхой хугацаанд хуваан төлж болох ба хугацаандаа төлж чадаагүй тохиолдолд уг эрхийг цуцлах арга хэмжээг авдаг байна. ОХУ-ын зам тээврийн зөрчил гаргагчдыг торгуулиа сайн дураараа заасан хугацаанд төлүүлэхийн тулд захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэр гарснаас хойш 20 хоногийн дотор торгуулиа төлсөн бол ногдуулсан торгуулийн хагастай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгууль төлөх боломжийг олгосон байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992. <https://legalinfo.mn/mn/detail/367>
2. Захиргааны хариуцлагын тухай хууль, 1992. <https://legalinfo.mn/mn/detail/280>
3. Зөрчлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2017. <https://legalinfo.mn/mn/detail/12695>
4. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (төсөл), <https://lawforum.parliament.mn/draft/65/>

Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Б.Чимид, БНМАУ-ын Захиргааны эрх, УБ, 1973 он
2. Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо, Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга) болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмж, <https://legaldata.mn/b/177>
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Захиргааны хариуцлагын тухай хуультай холбоотой судалгаа” 2004 он, <https://nli.gov.mn/?p=1937>
4. Ц.Цогт, “Захиргааны хариуцлага” ба “эрүүгийн хариуцлага” (англо-саксоны эрх зүйн системн жишээ) <https://legaldata.mn/b/395>
5. Г.Ганбаатар, Л. Оюнчимэг “Зөрчлийн тухай хууль дахь зөрчилдөөн бүхий зарим асуудал” Шүүх эрх мэдэл сэтгүүл №4(2017)
6. М.Чинбат: Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудал <http://prokuror.mn/blog/ON/4408>

Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. World Justice Project, Rule of Law Index 2021, <https://worldjusticeproject.org/sites/default/files/documents/WJP-INDEX-21.pdf> (Сүүлд үзсэн: 2021.11.23)
2. Administrative offences, <https://criminal-law-germany.lawyer/administrative-offences/>
3. Act on Regulatory Offences in the version published on 19 February 1987 (Federal Law Gazette [Bundesgesetzblatt] I p. 602), last amended by Article 5 para. 15 of the Act of 21 June 2019 (Federal Law Gazette I, p. 846) https://www.gesetze-im-internet.de/englisch_owig/englisch_owig.html#p0329
4. Cambridgeshire constabulary <https://www.cambs.police.uk/information-and-services/Cautions-warnings-penalties>
5. Simple caution (including youth cautions), <https://hub.unlock.org.uk/knowledgebase/simple-caution/>
6. Cautioning and Diversion, <https://www.cps.gov.uk/legal-guidance/cautioning-and-diversion>
7. Simple caution, <https://hub.unlock.org.uk/knowledgebase/simple-caution/>
8. Police-issued penalty notices, <https://www.nidirect.gov.uk/articles/police-issued-penalty-notices>
9. Adult Cautioning Scheme, https://www.citizensinformation.ie/en/justice/law_enforcement/adult_cautioning_scheme.html#

10. Law enforcement in Ireland, <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Europe/IRELAND>
11. Fines imposed district court, <https://www.courts.ie/fines-imposed-district-court>
12. National Police Checks, <https://www.australiannationalcharactercheck.com.au/Cautions-and-Police-Checks.html>
13. Young offenders, <https://lawhandbook.sa.gov.au/ch06s07.php>
14. Fines and enforcement, <https://www.qld.gov.au/transport/safety/fines/pay>
15. Fines Enforcement Registry (FER), <https://www.wa.gov.au/service/justice/administrative-law/fines-enforcement-registry-fer>
16. Fines and infringement notices, <https://www.alrc.gov.au/publication/fines-and-infringement-notice-2/>
17. Code Of Administrative Offences Of The Russian Federation, December 30, 2001
18. “Кодекс Российской Федерации об административных правонарушениях” от 30.12.2001 N 195-ФЗ (ред. от 01.07.2021, с изм. от 09.11.2021) (с изм. и доп., вступ. в силу с 01.10.2021) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/080d25276289006c381505fe470f240608f4ad77/
19. The Criminal Code of the Russian Federation, 1996
20. Ksenia Zubacheva, Russia Beyond, 2019
21. The official website of the Ministry of Internal Affairs of the Russian Federation, 2021 <https://en.mvd.ru/news/item/7064770>
22. Road Rules and Regulations in Russia, <https://www.angloinfo.com/how-to/russia/transport/driving/on-the-road>
23. Finland's fine example, <https://australiainstitute.org.au/wp-content/uploads/2020/12/TAI-Discussion-Paper-Finlands-fine-example.pdf>

ДӨРӨВ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ПРОКУРОРЫН ОРОЛЦОО

Судалгааг удирдсан:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D) С.Сүхбаатар
Эрдэм шинжилгээний ажилтан Т.Намуун
Эрдэм шинжилгээний ажилтан Б.Дүүрэнжаргал
Эрдэм шинжилгээний ажилтан Х.Мөнгөнчимэг

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, хэрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно гэж тусгасан бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж байна.

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /2017/, Прокурорын тухай хууль /2017/ зэрэг хуулиудад зөрчлийн хэрэг бүртгэлд прокурор хяналт тавих талаар хуульчилсан байдаг.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо нь Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд тодорхойлсон прокурорын чиг үүрэгт хамаарах эсэх талаар судлаачдын дунд маргаан өрнөдөг бөгөөд зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт нь зөрчлийн талаарх ойлголт, онцлогтой салшгүй нягт холбоотой.

2002 оны захиргааны хариуцлагын тухай хуулиар захиргааны зөрчлийг тодорхойлж түүнд тавих прокурорын хяналтыг хуульчилсан бол 2017 оны зөрчлийн тухай хуулиар өмнө нь захиргааны хариуцлагын тухай хуульд тодорхойлж байсан зөрчлөөс гадна бусад хуулийн холбогдох санкциудыг нэгтгэн тусгаснаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын хяналтын цар хүрээ өргөсөж, прокурорын байгууллагын ачаалал нэмэгдсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны прокурорын хяналтад холбогдох нөхцөл байдлыг тогтоон, дүгнэснээр практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг олоход дөхөм болох тул уг судалгаагаар зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо, зөрчлийн¹ хэрэг бүртгэлд тавих прокурорын хяналтын асуудлыг судалж, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхийг зорилоо.

1 Энэхүү судалгаанд “Зөрчил”-ийг “Захиргааны хариуцлага”, “Зөрчил” гэх хоёр нэр томъёогоор хэрэглэх болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БА ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

Уг судалгаагаар прокурорын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавьж буй хяналт зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлдөг эсэх, энэ асуудлын талаарх онолын болон харьцуулсан судалгааг хийх замаар практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон судлахыг зорьсон билээ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог тодорхойлохын тулд зөрчлийн талаарх ойлголт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны онцлогийг судлах шаардлагатай бөгөөд Зөрчлийн тухай хуульд² зөрчил гэдэг нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Эрүүгийн хуулиар нийгмийн амин чухал эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалдаг бол зөрчлийн тухай хууль тогтоомжоор гэмт хэргийн шинжгүй үйлдэл эс үйлдэхүйг зөрчил хэмээн тодорхойлж, хуулиар тогтоосон журмыг зөрчихөөс урьдчилан сэргийлдэг. Гэмт хэрэг, зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог өнөөгийн байдлаар авч үзвэл эрүүгийн хариуцлага, захиргааны хариуцлага гэж ерөнхийд нь ангилж гэмт хэрэгт ял оногдуулж, зөрчилд захиргааны шийтгэл хүлээлгэж байна.³ Өөрөөр хэлбэл, Эрүүгийн болон Захиргааны хариуцлага нь тэдгээрийн үндсэн зорилго, хүлээлгэх хариуцлага буюу шийтгэл зэргээрээ ялгаатай бас онцлогтой байна. Эрүүгийн хариуцлагын үндсэн зорилго нь Кантын тодорхойлсноор “Нийтийн эрх ашиг” -ийг хамгаалах, төлөөлөх, зөрчсөн этгээдийг хорих, шийтгэх бол Захиргааны хариуцлагын үндсэн зорилго нь хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, шийтгэж хорихоос илүү сануулах, ухааруулах онцлогтой байна.⁴

Зөрчлийн тухай хуулиар зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг зааж, зөрчлийн шинжийг бусад хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлдог.⁵ Үүнээс дүгнэн үзвэл нийгмийн хор аюул багатай үйлдлүүд түүнчлэн хууль, дүрэм, журам, норм, стандарт зөрчсөн эсхүл тодорхой нэрлэн заасан үйлдэл, эс үйлдэхүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж үздэг байна.

Харин өмнө үйлчилж байсан захиргааны хариуцлагын тухай хуульд зөрчил хэмээн ерөнхийд нь тодорхойлох бус захиргааны зөрчил хэмээн тодорхойлдог байжээ. Тодруулбал Захиргааны хариуцлагын тухай хуулийн /1992/ гуравдугаар зүйлд захиргааны зөрчил хэмээн тусгаад “Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж үзнэ” хэмээн тодорхойлдог байжээ.⁶

2 Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга, /2017/

3 Б.Цэдэндамба, Ц.Болор-Эрдэнэ, Зөрчлийн эрх зүй, Соёмбо принтинг, 2019, 13 дахь тал.

4 С.Асланбек, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба прокурорын хяналт, 4 дэх тал, <http://legaldata.mn/b/804>.

5 Зөрчлийн хэрэг дэх прокурорын оролцоо <http://prokuror.mn/page/4103>.

6 Хууль зүйн үндэсний хүрээлэн, судалгааны тайлан, 2007, 388 дахь тал.

Хуульд тодорхойлсноор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт нь зэрэг явагдах бөгөөд зөрчлийн хэрэг бүртгэлт дуусахад, эсхүл зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг оролцогч эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй, прокурор тухайн шийдвэрдийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл шүүхэд дүгнэлт бичиж хүргүүлэх эрхтэй байна.

Өөрөөр хэлбэл, ЗШШТХ-д заасан ажиллагааг хангах зорилгоор явуулж буй хэрэг бүртгэлт, уг ажиллагаа нь хуулийн хүрээнд явагдаж буй эсэхэд тавих прокурорын хяналт, оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхээр хянан шийдвэрлэх цогц ажиллагааг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэж ойлгож болохоор байна.⁷

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч 4 төрлийн субъектийг хуулиар тогтоосон байдаг. Үүнд:

1. эрх бүхий албан тушаалтан,
2. зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан,
3. прокурор,
4. зөрчил хянан шийдвэрлэх шүүх.

Зөрчлийн хэрэг бүртгэлтэд зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд прокурорын хяналт хэрэгждэг бөгөөд прокурорын байгууллага нь өнөөгийн байдлаар зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, улсын хэмжээн дэх зөрчлийн тоо бүртгэлийг нэгтгэн хариуцдаг.

1.1. Прокурорын чиг үүргийн талаарх Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина” гэж зааснаас үзвэл прокурорын чиг үүрэг нь дараах байдлаар байна:

- Хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих,
- Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих,
- Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих,
- Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох.

Өөрөөр хэлбэл прокурор зөвхөн “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх” ажиллагаанд хяналт тавих эрхтэй байна. Үүнээс үүдэн “Зөрчил” нь прокурорын дээрх чиг үүрэгт хамаарах эсэх талаар судлаачдын байр суурь ялгаатай байгаа нь ажиглагддаг.

7 Зөрчлийн хэрэг дэх прокурорын оролцоо <http://prokuror.mn/page/4103>

Судлаач Ц.Цогт “Нийт зөрчлийн дийлэнх буюу зөрчлийн захиргааны актыг гаргах ажиллагааг захиргааны байгууллага, албан тушаалтан хийж гүйцэтгэдэг бөгөөд энэ нь “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах” ажиллагаа биш Захиргааны ерөнхий хуулийн дагуу хийгдэх захиргааны шийдвэр гаргах ажиллагаа (мөрдөн байцаах ажил биш) тул энэхүү захиргааны үйл ажиллагааг хянах эрхийг прокурорт өгсөн нь Үндсэн хуулийн зөрчил үүсгэж байна”⁸ гэж дүгнэсэн байна.

Харин 1992 оны Үндсэн хуулиар прокурорын байгууллагын уламжлалт чиг үүргийг өөрчилсөн тухай судлаач Б.Чимид “прокурорын “ерөнхий хяналт”-ын чиг үүргийг захиргааны хэргийн шүүхэд шилжүүлснээр “Монгол Улсын прокурорын газрууд бол Үндсэн хуулийн чиг үүргийн (функц)-хээ хувьд яриангүй эрүүгийн мөрдөн шалгах хүрээний байгууллага” болж, “мэргэшсэн байгууллага болж буйг”⁹ тайлбарласан байна.

Түүнчлэн, судлаач С.Нарангэрэл “Хууль зүйн хариуцлага, захиргааны эрх зүйн зөрчил, хариуцлага, сахилгын зөрчил, хариуцлага, иргэний эрх зүйн зөрчил, хариуцлага зэргийг ялган зааглах, тодорхойлох шаардлагатай. Зөрчлийн хор уршиг, эрүүгийн гэмт хэргийн хор уршгийн ялгаа юу билээ? Гэтэл Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар захиргааны эрх зүйн зөрчил алга болж, Зөрчлийн тухай хуулийг Эрүүгийн хуулийн нэг хэсэг болгосон байна. Түүнчлэн 220, 230-аад хуульд байсан хариуцлагыг ЗӨВХӨН МЕХАНИКААР тусгасан нь хангалтгүй юм.”¹⁰ гэж шүүмжилснээс үзвэл 1992 оны Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэг өөрөө Зөвлөлтийн гэх “Прокурорын Ерөнхий хяналт”-ыг халсан мэргэшсэн буюу зөвхөн Эрүүгийн мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтэд хяналт тавих /Захиргааны хариуцлага, зөрчилд биш/ эрхийг олгосон болох нь харагдаж байна.¹¹

Дүгнэвэл дээрх судлаачдын бичсэнээс үзэхэд Монгол Улсын үндсэн хуулиар тодорхойлсон прокурорын чиг үүрэг нь ЭХХША-ны нэгэн үе шат болох хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавихад хамаарахаар байна. Харин өдгөө хэрэгжиж буй зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог дүгнэн үзвэл зөвхөн ЭХХША-нд бус ЗШША-нд хяналт тавихаар хуульчилсан нь Монгол улсын Үндсэн хуульд тусгагдсан прокурорын чиг үүрэгт хамаарах эсэх нь эргэлзээтэй байна.

Эдгээр саналын зөрүүтэй байдлыг тодруулахын тулд прокурорын чиг үүргийн талаарх тодорхойлолтуудыг судлая.

1. Прокурор (лат. procurare, анг. public procurator, public prosecutor) –прокурорын хяналтыг хэрэгжүүлэх бүрэн эрх бүхий прокурорын байгууллагын албан хаагч, төрийн тусгай албан тушаалтан. Прокурорын тухай хуульд заасны дагуу прокурор нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд улсын яллагчаар иргэн, захиргааны хэрэг бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцоно.¹²

8 Ц.Цогт, Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу Прокурорын хяналт, 20. <http://legaldata.mn/b/387>.

9 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, 2004, 226 дахь тал.

10 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ, 2018, <https://nli.gov.mn/?p=4957>.

11 С.Асланбек, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба прокурорын хяналт., 4 дэх тал, <http://legaldata.mn/b/804>.

12 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2021, 339 дэх тал.

2. Прокурор нь шүүх эрх мэдлийг хууль ёсоор хэрэгжүүлэхэд хууль ёсоор оролцож, хууль зүйн үүрэг гүйцэтгэдэг Үндсэн хуулийн байгууллага бие даасан тогтолцоо юм. Прокурорын Үндсэн хуулийн чиг үүргийн агуулга, түүнийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг Прокурорын тухай хууль болон ЭХХШтХ болон, мөн бусад төрлийн хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд дэлгэрүүлэн заасан байдаг.¹³

3. Прокурор гүйцэтгэх эрх мэдлийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулах захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хуульд заасан журмын дагуу төрийг төлөөлөн оролцоно.¹⁴

4. Прокурор захиргааны хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, шийдвэрт хяналт тавина. Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналтыг прокурорын хяналтын бие даасан төрөлд хамааруулж ойлгоно. Захиргааны зөрчилд хэрэг бүртгэлт явагдвал прокурор түүнд хяналт тавина.¹⁵

Эдгээрээс үзэхэд зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавих нь прокурорын чиг үүрэгт хамаарч болохоор байна. Иймд ЗШША-нд прокурор оролцох нь Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй буюу прокурорын үйл ажиллагаа нь хүний эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангуулах зорилгод чиглэж байх тул ЗШША-нд прокурорын хяналт тодорхой хэмжээгээр байх нь зохистой байна.

1.2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцооны талаарх ойлголт

ЗШША-ны үе шат нь гомдол мэдээллийг хүлээн авах, хэрэг бүртгэлт явуулах /прокурорын хяналт/, зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа гэж тус тус ангилж болох юм. Эдгээр үе шатыг схемчлэн үзвэл дараахь байдлаар байна:

13 Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008, 336 дахь тал.

14 Д.Ганзориг, Захиргааны эрх зүйн тайлбар толь, (Хоёр дахь хэвлэл), 2003, 99 дэх тал.

15 УПЕГ, ХЗҮТ, Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, 2003 он 16 дахь тал.



Эдгээрээс ЗШША-ны үе шат бүрээр нь прокурорын оролцоог тодорхойлвол:

1. Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх шат

- Гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгэх
- Эрх бүхий албан тушаалтны гомдол мэдээллийг хүлээн авч гаргасан шийдвэрийг бүртгэх, тэдгээр шийдвэрт хяналт тавих
- Хэргийн харьяаллын асуудлыг шийдвэрлэх, /эрх бүхий албан тушаалтан гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх шийдвэр гаргасан тохиолдолд тухайн шийдвэртэй танилцаж, харьяаллын асуудлыг шийдвэрлэх/;
- Гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн тохиолдолд прокурор тухайн шийдвэрийг хянаад ЗШШТХ-ийн 6.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар шийдвэрийг хэвээр үлдээх; шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгож, даалгавар өгөх; шийдвэрийг хүчингүй болгож, зөрчлийн болон эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах шийдвэрийн аль нэгийг гаргана.
- Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн тохиолдолд тухайн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох үндэслэлтэй гэж үзвэл ЗШШТХ-ийн 6.6 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар дүгнэлт бичиж, шүүхэд хүргүүлнэ.

2. Хэрэг бүртгэлтийн шат

- Зөрчлийн хэргийг бүртгэж, дугаар олгох;
- Хэрэг бүртгэлтийн хугацааг 30 хүртэл хоногоор сунгах;

- Хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох;¹⁶
- Эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийн удирдах албан тушаалтны шийдвэр, ажиллагааны талаархи гомдлыг хянан шийдвэрлэх;
- Зөрчил шалгах тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхээр даалгавар өгөх;
- Үндэслэлгүй эрх хасах арга хэмжээ авсан бол цуцлах, саатуулагдсан хүнийг суллах;
- Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад эрх бүхий албан тушаалтан хууль зөрчсөн бол зөрчлийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар шалгуулахыг зогсоох талаар дээд шатны албан тушаалтанд шаардлага хүргүүлэх;
- Зөрчлийн хэрэг бүртгэлт, хяналтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийг гаргуулан авах, газар дээр нь танилцах, иргэн, албан тушаалтнаас тайлбар авах;
- Прокурорын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэх;

3. Хэрэг бүртгэлтийг дуусгах

- Хэрэг бүртгэлтийг дуусгахад гаргасан шийдвэрийг бүртгэх;
- Эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсхүл зөрчлийн хэрэг бүртгэлтэд буцаах;
- Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг өөрчлөх хүчингүй болгох үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлэх;
- Эрх бүхий албан тушаалтны шийтгэлээс чөлөөлөх тухай шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ.

4. Шүүхийн шат

- Дээр дурдсанаар прокурор ЗШШТХ-ийн 6.6 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 6.12 дугаар зүйлийн 11 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ.
- ЗШШТХ-ийн 2.2 дугаар зүйлийн 1.16 дахь хэсэгт зааснаар шүүх хуралдаанд оролцох бүрэн эрхтэй бөгөөд ЗШШТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар ЭХШ-д харьяалагдах зөрчлийн шүүх хуралд оролцоно. Харин ЗХШХШТХ-ийн 17 дугаар зүйлд зааснаар хэргийн оролцогч болно.

ЗШША дахь прокурорын оролцоог Прокурорын тухай хууль болон ЗШШТХ-д тодорхойлсон. Прокурор нь ЗШШТХ-д зааснаар ЗШША-тай холбоотой 17 бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.¹⁷ Эдгээр чиг үүргийг ерөнхийд нь хянах, харьяаллыг шийдвэрлэх, шүүх хуралд оролцох болон бусад ажиллагаа хэмээн ангилж болох юм.

16 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017, 4.2 дугаар зүйлд зааснаар хүний биед үзлэг хийх; байгууллага хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл, баримт бичгийг гаргуулан авах; хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах; хүнд шинжилгээ хийлгэх ажиллагааг явуулах зөвшөөрлийг олгохоор байна.

17 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017, 2.2-р зүйл.

Хянах:

1. зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;
2. оролцогчийн гаргасан гомдол, хуульд заасан бусад үндэслэлээр зөрчлийн хэргийг хянах;
3. хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан ажиллагааг хуульд заасны дагуу явуулсан эсэхийг хянах;
4. эрх хязгаарлах арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг хянах;

Хэргийн харьяаллыг шийдвэрлэх:

1. зөрчлийг өөрөө илрүүлсэн, мэдээлэл хүлээн авсан бол харьяаллын дагуу шилжүүлэх;
2. ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 2, 4, 5 дахь хэсэгт заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийн харьяаллыг тогтоох;
3. зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх;
4. тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, харьяаллын дагуу шилжүүлэх;

Шүүх хуралд оролцох:

1. зөрчлийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох- ЗШШТХ-ийн 6.6 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 6.12 дугаар зүйлийн 11 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар тус тус шүүхэд дүгнэлт бичиж хүргүүлэх эрхтэй байна. Шүүх хуралдаанд эрх бүхий албан тушаалтан, прокурор оролцоно.

ЗШША-нд холбогдох бусад:

1. хуульд заасны дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг сунгах;
2. эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны шийдвэр, ажиллагааны талаархи гомдлыг хянан шийдвэрлэх;
3. прокурорын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэх;
4. хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны зөвшөөрөл олгох;
5. хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэх;
6. зөрчил шалгах тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхээр даалгавар өгөх;
7. эрх бүхий албан тушаалтны эрх хязгаарлах арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан саналыг шийдвэрлэх;
8. Үндэслэлгүй эрх хасах арга хэмжээ авсан бол цуцлах, саатуулагдсан хүнийг суллах;
9. зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад эрх бүхий албан тушаалтан хууль зөрчсөн бол зөрчлийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар шалгуулахыг зогсоох талаар дээд шатны албан тушаалтанд шаардлага хүргүүлэх;

10. зөрчлийн хэрэг бүртгэлт, хяналтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийг гаргуулан авах, газар дээр нь танилцах, иргэн, албан тушаалтнаас тайлбар авах;

11. хуульд заасан бусад

1.3. Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих нь

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд: “Прокурор хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавина” гэж зааснаар хэрэг бүртгэх гэдэг нь эрх бүхий албан тушаалтан гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн тухай үйл баримтыг хууль тогтоомжийн дагуу анхлан шалгаж, нотлох баримтыг бэхжүүлж байгаа үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагаа нь эрүүгийн болон захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа гэсэн 2 төрөлтэй.¹⁸ Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналтыг прокурорын хяналтын бие даасан төрөлд хамааруулдаг.


Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын зорилго нь захиргааны зөрчлийг хянан шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд зөрчлийн талаарх хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангуулахад оршино. Мөн түүнчлэн зөрчил нэрийн дор гэмт хэргийн шинжтэй үйлдэлд шийтгэл оногдуулж, ял завшуулахгүй байхад прокурорын хяналт чиглэгддэг.

Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих явцдаа зөрчлийн хэрэг, материалтай танилцах нь зөрчлийг шалгах явц, ажиллагаа хуульд заасны дагуу явагдаж буй эсэхэд чиглэгдэх ба эрх бүхий албан тушаалтнаас нотлох баримтыг хуульд заасны дагуу цуглуулж бэхжүүлсэн байдал, хүн, хуулийн этгээдийн эрх, ашгийг зөрчсөн эсэх зэрэг хэрэг бүртгэлтийн ажиллагаанд бүхэлд нь үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана түүнчлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийг бүрэн гүйцэд бодитой явуулах үүднээс тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар өгч болох бөгөөд үүндээ дутуу хийгдсэн болон цаашид хийх ажиллагааны талаар тодорхой заасан байна. Мөн зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хянахдаа хяналтын харьяа байгууллагын хэмжээнд, эсвэл ЗШШТХ-ийн тодорхой, зүйл хэсгийн хүрээнд дээд шатны прокуророор баталсан удирдамжийн дагуу шалгалт хийдэг. Тус шалгалтын зорилго нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон журам, хувь хүн, хуулийн этгээд, төр, нийтийн эрх ашиг зөрчигдөж байгаа эсэхийг хянахад чиглэгдэх бөгөөд хууль зөрчсөн зөрчил илэрвэл арилгуулах арга хэмжээ авахад оршино.

18 Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан, Прокурорын хяналт, 2009 он. 162 дахь тал.

ЗШША-нд прокурор оролцохдоо дараах хүрээнд хяналт тавина¹⁹:



Зөрчлийн хэрэг бүртгэлтийн оролцогчдоос гомдол гаргасан тохиолдолд холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас хэрэг, материалыг авч даруй хянаана. Зөрчлийн шинжгүй, илтэд гэмт хэргийн шинжтэй асуудалд үндэслэлгүйгээр шийтгэл оногдуулсан байвал хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулахаар, харин хуулийн зүйл, заалтыг буруу хэрэглэсэн, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хуульд заасан хэмжээнээс их буюу бага торгууль ногдуулсан байвал түүнийг өөрчлүүлэхээр шүүхэд прокурор дүгнэлт бичнэ.

Хэрэв зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад тухайн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй болох нь тогтоогдсон тохиолдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татан, зохих байгууллагад шилжүүлнэ.

Харин өмнө нь үйлчилж байсан захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу Прокурор нь БНМАУ-ын Прокурорын хяналтын дүрмэнд зааснаар хяналт тавихын тулд захиргааны зөрчилтэй хэрэг шийдвэрлэхэд оролцдог байсан. Хэрэг шийдвэрлэх хуралд биеэр байх, гаргасан актыг хянах зэргээр прокурорын оролцоо нь энэ ажиллагаанд социалист хууль ёсыг тууштай хангах чухал баталгаа мөн гэж үздэг байжээ. Захиргааны комисс зэрэг бусад байгууллага хэрэг шийдвэрлэх хурал болох тухай прокурорт урьдчилан мэдэгдэх, зөрчил гаргасан этгээдэд захиргааны шийтгэл хүлээлгэсэн тухай тогтоол шийдвэрийнхээ хуулбарыг түүнд явуулж байх үүрэгтэй байсан байна.²⁰

Нийтээр дагаж биелүүлэх журам тогтоосон хуулийн хэм хэмжээ зөрчсөн гэх үйлдэл, явдал нь эрх зүй зөрчсөн хэрэг болдог. Түүнийг зөрчигдсөн харилцааны шинж, үйлдсэн этгээдийн гэм буруугийн хэр хэмжээгээр гэмт хэрэг, бусад зөрчил гэж ялгадаг байна. Бусад зөрчлөөс энд захиргааны шууд холбогдоно.

19 Прокурорын тухай хууль, 2017, 11 дүгээр зүйл.

20 Б.Чимид, БНМАУ-ын Захиргааны эрх, 1973 он. 340 дэх тал.

“Захиргааны зөрчил” нийгмийн аюул, гэм буруугийн хэр хэмжээгээр их бол гэмт хэрэгт тооцогдох, мөн гэмт хэрэг гэсэн нь хор аюулаар ялимгүй бол захиргааны зөрчилд тооцогдох учир шалтгаан бий. Ийм учраас зохих албан тушаалтан их, бага энэ хоёр зөрчлийг бүртгэх, зохих нотолгоог бэхжүүлэх, зөрчлийн тухай хэрэг үүсгэх ажиллагаандаа хуулийг хэрхэн биелүүлж байгааг хянадаг. Энэ үүднээс захиргааны зөрчилтэй хэргийг бүртгэх ажиллагаанд тавих хяналтыг хэрэг бүртгэх ажиллагааны талаархи хяналтын нэг дэд хэсэг болгон үздэг.²¹

Захиргааны болон эрүүгийн хэргийг бүртгэх ажиллагааны алинд ч хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, хууль буруу хэрэглэвэл ноцтой зөрчигдөх магадлал байдаг. Жишээ нь, захиргааны болон эрүүгийн хэргийн журмаар хүнийг албадан саатуулах (түр саатуулах, баривчлах)-д тухайн этгээдэд халдаж байгаагаараа хүний эрхийн асуудал болдог. Иймд прокурорын хяналт нэгэн адил чухал гэж үздэг байна.²²

21 Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008 он. 338 дахь тал.

22 Мөн тэнд.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗӨРЧЛИЙН ХЭРЭГТ ХЯНАЛТ ТАВИХ ПРОКУРОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ПРАКТИКТ ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ

ЗШША дахь прокурорын оролцоог хэрэгжүүлэхэд хуулийн зохицуулалтаас хамаарч практикт дараахь байдлаар нийтлэг бэрхшээл тулгардаг байна.

- ЗШША-ны шат дамжлаг их, хуулийн зарим заалт тодорхойгүй байгаагаас хэрэглэхэд хүндрэл учирдаг
- Шүүхийн ялгаатай байдлаас шалтгаалан иргэн, хуулийн этгээдийн хүлээх эрх, үүрэг тодорхойгүй байдаг
- Монгол Улсад ЗШША-г хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтны 60-70% нь хуульч бус бусад салбарын мэргэжилтнүүд байдаг учраас сургалт явуулах, чиглэл, зөвлөмж өгөх, зааварлах асуудал байнга гардаг
- Прокурорын ажлын ачааллаас болж зөрчлийн хэрэг хуульд нийцэж байгаа эсэхийг бүрэн хянах нь эргэлзээтэй байдаг.

Дээрх тулгарч буй бэрхшээлийн талаарх тоо баримтыг дэлгэрүүлэн судлая.

ЗШША-ны шат дамжлаг их, хуулийн зарим заалт тодорхойгүй байгаа тухайд:

Өмнөх бүлэгт ЗШША дахь прокурорын оролцоог хэрхэн хуульчилсан талаар авч үзсэн билээ. Тодруулбал, Прокурорын байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг эрх бүхий байгууллага хүлээн авсан үеэс шүүхээр шийдвэрлэгдэж, тэрхүү шийдвэр биелэгдэж дуусах хүртэл бүхий л үе шатанд оролцож, үйл ажиллагааг нь холбож, тодорхой шийдвэрүүдийг гаргадаг чиг үүрэгтэй байна.²³ Өөрөөр хэлбэл прокурор нь ЗШША-ны бүхий л үе шатанд оролцож байгаа нь нэг талаас захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлөх, хоёрдугаарт прокурорын байгууллагын ачааллыг хэт нэмэгдүүлсэн байна.

ЗШШТХ-ийн дагуу 2017 оны 07 дугаар сараас 2020 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд прокурорын байгууллага нь эрх бүхий байгууллагуудаас шалган шийдвэрлэсэн нийт 532.224 зөрчлийн талаарх гомдол мэдээллийн болон газар дээр нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 5.489.514 зөрчлийн шийдвэрлэлт, зөрчлийн 88.126 хэргийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд хяналт тавьж ажиллажээ.²⁴

Шүүхийн ялгаатай байдлаас шалтгаалан иргэн, хуулийн этгээдийн хүлээх эрх, үүрэг тодорхойгүй байгаа тухайд:

ЗШШТХ-ийн 2.1 дүгээр зүйлд зааснаар зөрчил хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тодорхойлдог бөгөөд зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэх журам нь ялгаатай байдлаар хуульчлагдсан байна²⁵.

23 М.Чинбат, Эрүүгийн Болон Зөрчлийн Хууль Тогтоомжийн Хэрэгжилт, Анхаарах Асуудал, 2021 <http://prokuror.mn/blog/ON/4408>.

24 УЕПГ-ын статистик мэдээлэл. 2020 он.

25 Монгол Улсын зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /Сургагч багш нарт зориулсан гарын авлага/, ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 2017, 98 дахь тал.

	Эрүүгийн хэргийн шүүх	Захиргааны хэргийн шүүх
Гомдол гаргах журам	Шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Эрүүгийн хэргийн шүүхэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана. Гомдол гаргахад УТХ төлөхгүй.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана: - Хуульд тусгайлан заасан бол УША хийгдсэн байхыг шаардана. - Гомдол гаргахад УТХ төлнө.
Гомдлыг шийдвэрлэх журам	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг журмыг удирдлага болгоно.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.
Хугацаа	Дүгнэлт, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ. /ЗШШТХ-ийн 8 дугаар бүлэг/	Энэ төрлийн маргааныг захиргааны хэргийн анхан шатны шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. /ЗХШХШТХ-ийн 112 дугаар зүйл/
Давж заалдах	Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна. /ЗШШТХ-д зааснаар/	Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй /ЗХШХШТХ-д зааснаар/

ЗШША-д оролцогчийн эрх, үүрэг нь ЗШШТХ-иар тодорхойлогдсон байдаг боловч шүүх хуралд оролцох эрх зүйн байдал нь дээр дурдсанаар өөр байдлаар зохицуулагддаг. Тодруулбал, ЭХШ-ээр зөрчлийг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд ЗШШТХ-ийн 8 дугаар бүлэгт зааснаар болон ЭХХШТХ-д заасан нийтлэг журмыг баримталдаг бол ЗХШ-ээр зөрчлийг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд ЗХШХШТХ-д заасан журмыг баримталдаг. ЗШШТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар прокурор шүүх хуралдаанд оролцоно.

Энэ талаарх статистик мэдээллийг авч үзвэл:

Анхан шатны шүүхүүд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 10999 зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулсан байна. Харин давж заалдах шатны шүүх зөрчлийн 288 хэргийг шийдвэрлэсэн байна.

Монгол Улсад ЗШША-г хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтны 60-70% нь хуульч бус бусад салбарын мэргэжилтнүүд байдаг учраас сургалт явуулах, чиглэл, зөвлөмж өгөх, зааварлах асуудал гардаг тухайд:

ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлд зааснаар дараах 31 төрлийн эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг харьяалан хэрэгжүүлдэг.

- Консулын эрх бүхий албан тушаалтан,
- Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч,
- Төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан,
- Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга,
- Тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан,
- Олон нийтийн цагдаа,
- Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч,
- Ахлах шийдвэр гүйцэтгэгч,
- Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч,
- Хүүхдийн эрхийн улсын байцаагч,

- Хорих ангийн эрх бүхий албан тушаалтан,
- Авлигатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан,
- Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч,
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагч,
- Гаалийн улсын байцаагч,
- Татварын улсын байцаагч,
- Оюуны өмчийн улсын байцаагч,
- Нийгмийн даатгалын байцаагч,
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч,
- Гал түймрийн улсын хяналтын байцаагч,
- Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч,
- Монголбанкны хянан шалгагч,
- Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч,
- Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч,
- Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч,
- Статистикийн улсын байцаагч,
- Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч,
- Төмөр замын тээврийн улсын байцаагч,
- Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч,
- Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч,
- Санхүүгийн мэдээллийн улсын байцаагч,

Практикт, өнөөдрийн байдлаар дээрх 31 байгууллагын 216 нэгжид харъяалагдах 10011 эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлж байгаа бол Улсын ерөнхий прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих бие даасан хэлтэс ажиллаж, улсын хэмжээнд зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаанд тавих хяналтын ажлыг дагнан хариуцсан 68 хяналтын болон ахлах прокурор ажиллаж байна.

Мөн эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан 2314 шийдвэрийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэн, прокурорын дүгнэлт бичиж, шүүхээр шийдвэрлүүлснээс 1601 буюу 69.2 хувьд нь эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгуулж, 713 буюу 30.8 хувьд нь шийтгэлийн хуудсанд өөрчлөлт оруулсан байна.

Харин ЗШША-г хэрэгжүүлдэг эрх бүхий албан тушаалтнуудын талаар УЕПГ-ын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ү.Содномцог²⁶ дараахь байдлаар ярилцлагадаа дурджээ.

26 <http://prokuror.mn/blog/YA/3212>

“Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжээд хоёр жил орчим шахам болж байна. Энэ хугацаанд бид зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа. Өнгөрсөн хугацаанд хүндрэлтэй асуудал юу байсан гэвэл хуулиуд маань шинээр батлагдсан, хоёрдугаарт цагдаагийн байгууллагыг эс тооцвол бусад байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд ихэвчлэн хуульч биш хүмүүс байсан. Иймд прокурорууд хяналтынхаа явцад хуулиудыг зөв хэрэгжүүлэх асуудлаар сургалт явуулах, чиглэл, зөвлөмж өгөх, зааварлах асуудал байнга гарч байсан.”

Иймд дээрх ЗШША-г хэрэгжүүлдэг эрх бүхий албан тушаалтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, улмаар эдгээр албан хаагчдад чиглэсэн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байдал ажиглагдаж байна.

Прокурорын ажлын ачааллаас болж зөрчлийн хэрэг хуульд нийцэж байгаа эсэхийг бүрэн хянах нь эргэлзээтэй байгаа талаар:

Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат “Шүүх эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын үндэсний чуулган”-д тавьсан Эрүүгийн Болон Зөрчлийн Хууль Тогтоомжийн Хэрэгжилт, Анхаарах Асуудал ²⁷ хэмээх илтгэлдээ дараахь нөхцөл байдлын талаар дурдсан байна.

- Прокурорын эрхэм зорилго бол Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, шударга ёсыг тогтоох, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, иргэд аюулгүй, итгэл үнэмшилтэй, эрх чөлөөтэй амьдрах нийгмийг бүтээх явдал юм.
- Прокурорын газарт Захиргааны салбар эрх зүй /зөрчлийн асуудлаар/ мэргэшсэн боловсон хүчин байгаа эсэх нь тодорхой биш /ихэнх прокурор Эрүүгийн эрх зүйгээр мэргэшсэн байдаг/, дээр нь ажлын ачааллаас болж зөрчлийн хэрэг хуульд нийцэж байгаа эсэхийг бүрэн хянах нь эргэлзээтэй.

Тодруулбал, Нийслэлийн Ерөнхий прокурор Д.Баярмагнайгийн “Үндэсний шуудан” сонинд өгсөн ярилцлагад²⁸ энэ тухай дурдсан байна:

“Энэ онд прокуроруудын ажлын ачааллыг өмнөх оныхтой харьцуулбал 40 орчим хувиар өссөн нь шинэчлэн батлагдсан Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой. Зөвхөн нийслэл, дүүргийн хэмжээнд энэ оны 7-р сарын 1-нээс хууль хэрэгжиж эхэлснээс хойших гурван сарын хугацаанд Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан 106 мянга гаруй материалыг хянаж ... прокурорын байгууллагад маш их ачаалал өгч байгаа. Жишээ нь, нийслэл, дүүргийн хэмжээнд тус хяналтын чиглэлээр 149 зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын 2852 эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавин, бүртгэл судалгааг хөтлөн ажиллаж байна. Дунджаар нэг прокурор долоон нэгж, байгууллагын 123 эрх бүхий албан тушаалтны шалгаж шийдвэрлэсэн 4256 зөрчлийн талаарх гомдол мэдээлэлд хяналт тавьсан байна. Гэтэл зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд гэхэд манай байгууллагад ердөө дөрөвхөн прокурор ажилладаг” гэжээ.

27 М.Чинбат, Эрүүгийн Болон Зөрчлийн Хууль Тогтоомжийн Хэрэгжилт, Анхаарах Асуудал, 2021 <http://prokuror.mn/blog/ON/4408>.

28 Д.Баярмагнай, “Прокурорын байгууллага «ХААЛТТАЙ» байх ёстой. Олон нийт нээлттэй байлгах гэж шахаж шаардах ч хэрэггүй” ярилцлага, <https://ikon.mn/n/154k>.

Мөн УЕПГ-ын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ү.Содномцог ярилцлагадаа:

“Зөрчлийн тухай хууль батлагдсанаар манай прокурорууд, ялангуяа нийслэл, дүүргийн эрүүгийн хэрэг, зөрчлийн хэрэгт хяналт тавьдаг прокурорууд маань орой үдэш болтол, амралтын өдрүүдэд ажиллахгүй л бол ажлаа дийлдэггүй. Прокурорын байгууллага гэмт хэрэг болон зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сурталчлах, иргэдийн дунд яриа таниулга хийх, байгууллагуудад мэдэгдэл шаардлага хүргүүлэх зэргээр ажилладаг”²⁹

Дээрх ярилцлагуудаас үзэхэд ЗШША-наас үүдэн прокурорын ачаалал нэмэгдсэн байгааг харж болно.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тавьж буй прокурорын хяналтын талаарх статистик мэдээлэл³⁰ /2021 оны эхний 11 сарын байдлаар/

Зөрчил шийдвэрлэсэн албан тушаалтан	Нийт	Хувиар
Цагдаа	1814370	98.6%
Мэргэжлийн хяналт	5178	0.3%
Онцгой байдал	245	0.01%
Бусад	20633	1.12%
Нийт зөрчил	1840426	

Прокурорын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьсан тухай тоон статистикаас харвал энэ оны эхний байдлаар 1840426 зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэгт хяналт тавьж ажилласан байх бөгөөд эдгээрийн дийлэнх хувийг /98.6%/ цагдаагийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрлэсэн хэрэг эзэлж байна. Прокурор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих нь нэгдүгээрт, зөрчил нэрийн дор гэмт хэргийн шинжтэй үйлдэлд шийтгэл оногдуулж, ял завшуулахгүй байх, хоёрдугаарт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн эрх зөрчигдөхөөс урьдчилсан сэргийлэхэд чиглэгддэг.

Дээрх хэсэгт “цагдаагийн байгууллагыг эс тооцвол бусад байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд ихэвчлэн хуульч биш хүмүүс байсан” хэмээснээс үзвэл ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлд заасан эрх бүхий албан тушаалтны харьяаллын асуудлыг эргэн харах шаардлага ажиглагдаж байна. Хуулийг нэг мөр хангуулахын тулд “мэргэжлийн бус” буюу хуульч бус албан тушаалтнуудыг прокурор зайлшгүй хянах шаардлагатай гэх агуулгын хүрээнд ЗШШТХ-д прокурорын оролцоог хэтэрхий өргөн хүрээнд хуульчилсан нь зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг эрх бүхий байгууллага хүлээн авсан үеэс шүүхээр шийдвэрлэгдэж, тэрхүү шийдвэр биелэгдэж дуусах хүртэл бүхий л үе шатанд прокурор оролцох эрх зүйн үр дагаврыг бий болгожээ. Прокурорын хяналт тавьсан зөрчлийн талаарх тоо баримтаас үзэхэд зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудаас цор ганц хуульч мэргэжлийн хэмээн үзэж байгаа цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрлэсэн хэрэг дийлэнх хувь /98.6%/-ийг эзэлж байгааг анхаарвал зохистой.

29 <http://prokuror.mn/blog/YA/3212>.

30 Prokuror.mn хаягаас статистик мэдээллийг түүвэрлэн, нэгтгэв. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү./

Уг бүлэгт дурдсан практикт тулгамдаж буй асуудлуудыг үндэслэн:

- Эрх бүхий албан тушаалтны шалган шийдвэрлэх зөрчлийн харьяаллын давхардал, хийдлийг арилгах,
- прокурорын хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг сайжруулахад анхаарч, эрх хязгаарлах арга хэмжээ авах үндэслэл, журмыг тодорхой болгох,
- зөрчлийг газар дээр нь, эсхүл гомдол, мэдээллийг шалгах явцад хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэлийг ялган зохицуулах,
- холбогдогчийг албадан ирүүлэх үндэслэлийг тодорхой болгох,
- зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байгаа ялгаатай стандартыг өөрчилж, шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг адил журмаар хэрэгжүүлэх зохицуулалтыг хуульчлах зэрэг байдлаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАДААДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Уг бүлгээр манай улстай газар нутгийн хувьд хөрш, хөгжлийн хувьд нэг түвшнээс эхэлсэн гэх утгаараа дараах 2 улсыг сонгож, Захиргааны зөрчилд прокурор хэрхэн хяналт тавьдаг эсэхийг гадны зарим улстай харьцуулан судлахыг зорилоо.

3.1. Бүгд Найрамдах Хятад Ард улсын эрх зүйн зохицуулалт

Тус улсад 1996 онд баталсан “Захиргааны шийтгэл”-ийн тухай хууль үйлчилдэг бөгөөд 8 бүлэг, 64 зүйлтэй байна³¹. Тус хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу захиргааны шийтгэл /хариуцлага/-ийг орон нутгийн болон улсын түвшинд “Захиргааны байгууллага” оногдуулах бүрэн эрхтэй байна. Захиргааны шийтгэлтэй холбогдсон процесс ажиллагааг Захиргааны эрх зүйн процессын тухай хууль болон Захиргааны эрх зүйн асуудлыг дахин хэлэлцэх тухай хуулиар зохицуулдаг бөгөөд захиргааны шийтгэлтэй холбоотой гомдлыг шүүхээр шийддэг хэдий ч Хятадад Захиргааны хэргээр дагнасан шүүх байхгүй учир ерөнхий харьяаллаар шийддэг байна. Түүнчлэн, захиргааны байгууллага захиргааны шийтгэлийг /буруугаар, үзэмжээр/ хүссэнээр зүй бусаар ашиглах боломж олгогдсон, тэр бүр гомдлыг шүүх хэлэлцдэггүй гэх шүүмжлэлд өртөгддөг байна.

Манай улсын хувьд ЗШША дахь прокурорын оролцоо нь тухайн улсын прокурорын байгууллагын чиг үүрэгтэй холбоотой байдаг тухай өмнөх бүлэгт дурдсан билээ. Үүнээс үүдэн БНХАУ-ын прокурорын байгууллагын чиг үүргийг хэрхэн хуульчилсныг судаллаа. Прокурорын байгууллагын эрх зүйн байдлыг БНХАУ-ын Ардын прокурорын органик хууль (2018)³²-аар тодорхойлдог бөгөөд тус хуульд зааснаар прокурор дараахь чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. (20 дугаар зүйл)

- Хуульд заасан эрүүгийн хэргийн мөрдөн байцаах эрхийг хэрэгжүүлэх;
- Эрүүгийн хэргийг хянан шалгах, эрүүгийн сэжигтнийг баривчлах эсэхийг батлах, шийдвэрлэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, яллах эсэхийг шийдвэрлэх, яллах шийдвэр гаргасан тохиолдолд төрийн яллах ажиллагааг дэмжих;
- Хуулийн заалтын дагуу нийтийн ашиг сонирхлын маргаан үүсгэх;
- Шүүхийн үйл ажиллагаанд хуулийн хяналт тавих;
- Шүүхийн шийдвэр, магадлал болон бусад хүчин төгөлдөр хууль эрх зүйн баримт бичгийн биелэлтэд хуулийн хяналт тавих;
- Хорих, хорих ангийн хууль сахиулах үйл ажиллагаанд хуулийн хяналт тавих;
- Хуульд заасан бусад чиг үүрэг.

31 Lehman, Lee and Xu хуулийн фирмийн Англи хэл дээрх орчуулга.
<http://www.lehmanlaw.com/resource-centre/laws-and-regulations/administration/administrativepunishment-law-of-the-peoples-republic-of-china-1996>.

32 БНХАУ-ын Ардын прокурорын органик хууль (2018) <https://www.chinalawtranslate.com/en/organic-law-of-the-peoples-procuratorate-of-the-prc-2018/>.

Үүнээс үзэхэд БНХАУ-ын ЗШША-нд прокурор оролцдоггүй бөгөөд прокурорын чиг үүрэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавихад чиглэдэг байна.

3.2. Оросын Холбооны улсын эрх зүйн зохицуулалт

Тус улсын “Захиргааны хариуцлага” нь “Эрүүгийн хариуцлага”-аас олон шинжээрээ ялгаатай болохыг судлаачид тэмдэглэсэн байна. Тодруулбал, а/ Захиргааны хариуцлагыг гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас шүүхийн бус журмаар оногдуулдаг, б/Захиргааны хариуцлага оногдуулж буй зөрчил нь гэмт хэрэгтэй харьцуулахад аюул багатай бөгөөд захиргааны хариуцлага нь эрүүгийн хариуцлагатай харьцуулахад хүнд биш байдаг, в/Захиргааны хариуцлагыг ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн кодексоор тогтоодог бол эрүүгийн хариуцлагыг зөвхөн ОХУ-ын Эрүүгийн кодексоор тогтооно. Тиймээс захиргааны зөрчилд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн асуудал нь захиргааны эрх зүйн салбарын асуудалд хамаардаг байна.

ОХУ-д Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх журмыг Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар³³ зохицуулдаг. Хууль нь 2001 оны 12 дугаар сарын 20-нд төрийн думаар ёсчлогдон 2001 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ОХУ-ын зөвлөлөөр батлагдсан байна.

Уг хууль нь ОХУ-ын Үндсэн хууль болон олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, олон улсын гэрээнд үндэсэх бөгөөд хэрэв захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль олон улсын гэрээ, бусад дүрэмд нийцээгүй бол олон улсын хэм хэмжээ, дүрмийг баримтлана хэрэглэнэ гэж тусгагджээ. ОХУ 2016 онд Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульдаа шинэчилсэн найруулга хийж 32 бүлэг, 32 заалттай болсон.

Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн зорилт нь иргэн, хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эрүүл ахуй, нийтийн ёс суртахуун, байгаль орчныг хамгаалах, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд тогтоосон журам гаргах, нийгмийн аюулгүй байдал, эд хөрөнгө, төр нийгэм, хуулийн этгээд, хүний хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Уг хуулийн 4 дүгээр зүйлд дараах үндсэн зарчмуудыг тусгажээ. Үүнд:

1. Захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага оногдуулахдаа Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд заасан журмыг баримтлах;

2. Иргэнд захиргааны шийтгэлийг иргэнд оногдуулахдаа түүний санхүүгийн чадавх, гэм буруугийн шинж байдал зэргийг харгалзан хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх;

3. Захиргааны зөрчилд оногдуулах шийтгэлийг хуулийн этгээдэд хүлээлгэхдээ хуулийн этгээдийн хөрөнгө болон санхүүгийн байдал, зөрчлийн гэм буруугийн шинжийг харгалзан хариуцлагыг хүндрүүлэх эсхүл хөнгөрүүлэх;

4. Захиргааны эрх зүйн нэг зөрчилд нэг хариуцлага хүлээлгэх.

Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог Захиргааны зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь заалт болон Прокурорын тухай хуулиар зохицуулсан байна.

33 ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль 2001 он.

Прокурорын тухай хууль нь 1992 оны 1 дүгээр сарын 17-нд батлагдсан бөгөөд тус хуульд Прокурор эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шаардлагыг тогтоосон хугацаанд заавал биелүүлэх үүрэгтэйг онцолсон байна.³⁴ Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасны дагуу прокурор болон түүний орлогч захиргааны зөрчил үйлдэгдсэн нь тогтоогдсон тохиолдолд дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Прокурорын тухай хуулийн 1.1.2-р зүйлд прокурорын чиг үүргийн талаар дараах байдлаар хуульчилсан байна:

- Холбооны яамд, улсын хороод, үйлчилгээ болон бусад холбооны гүйцэтгэх засаглал, ОХУ-ын үүсгэн байгуулагчдын төлөөллийн (хууль тогтоох) болон гүйцэтгэх байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, цэргийн удирдлагын байгууллага, хяналтын байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; арилжааны болон арилжааны бус байгууллагын удирдах байгууллага, дарга нар, түүнчлэн тэдгээрээс гаргасан эрх зүйн баримт бичгийг хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;
- Холбооны яамд, улсын хороод, албад болон бусад холбооны гүйцэтгэх засаглал, ОХУ-ын үүсгэн байгуулагчдын төлөөллийн (хууль тогтоох) болон гүйцэтгэх байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, цэргийн удирдлагын байгууллага, хяналтын байгууллагууд, албан тушаалтан, арилжааны болон арилжааны бус байгууллага, тэдгээрийг удирдах албан тушаалтан дарга нар иргэний эрх, эрх чөлөөг хангахад хяналт тавих;
- Шуурхай, эрэн сурвалжлах үйл ажиллагаа, хэрэг бүртгэлт, урьдчилсан мөрдөн байцаалтын ажиллагаа эрхэлж буй байгууллагын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- Хорих, цагдан хорих газрын захиргаанаас хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- ОХУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид заасан эрх мэдлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх;
- Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах.

ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон төлөөллийн байгууллагууд хариуцагчаар татагдах боломжтой. Дээрх байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагаа хууль зөрчсөн бол иргэн прокурорт мэдэгдэх эрхтэй. Прокурор уг асуудлыг шалгаж үзээд үндэслэлгүй нь тогтоогдвол зөрчлийг нэн даруй арилгах шаардлага хүргүүлдэг байна.³⁵

34 ОХУ-ын Прокурорын тухай хуулийн 9.1, 22, 27, 30, 33 дугаар зүйл.

35 ОХУ-ын Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь заалт.

Уг шаардлагыг биелүүлэх хугацааг прокуророос тогтоох бөгөөд орон нутгийн байгууллага 10 хоногийн дотор прокурорын шаардлагыг хэлэлцэн хариу мэдэгдэнэ. Прокурорын санал гаргасан өдрөөс сарын хугацаанд хуульд заасан зөрчлийг /шалтгаан, нөхцөл/ арилгахаар тодорхой арга хэмжээ авч, түүнийг прокурорт мэдэгдэх үүрэгтэй. Мөн прокурор хуулийн этгээд болон албан тушаалтанд дахин зөрчил гаргахгүй байх талаар бичгээр сануулга өгдөг.

Захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой хэргийг байгууллага, албан тушаалтаны шалгах хугацаа 15 хоног байна. Шүүхээс захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх хугацаа 2 сар байх бөгөөд оролцогчдоос хүсэлт гаргавал нэмэлт мэдээлэл, нотлох баримт цуглуулах зорилгоор шүүгч 1 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл зөрчил үйлдэгдсэнээс хойш 60 хоногийн дотор эрх бүхий этгээдийн дээд шатны байгууллага болон шүүхэд хандана.

ОХУ-ын хувьд ЗШША дахь прокурорын оролцоо нь манай улстай ижил байдлаар зохицуулагдсан байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

ЗШШТХ-ийн 2.2 дугаар зүйлд ЗШША-нд хэрэгжүүлэх прокурорын бүрэн эрхийг тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хуулиас эхтэй. ЗШША-ны бүх үе шатанд прокурор оролцож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд тодорхойлсон прокурорын чиг үүрэгт хамаарах эсэх талаар судлаачид нэгдсэн дүгнэлтэд хүрээгүй бөгөөд өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль нь прокурорын үндсэн чиг үүрэг, мөн чанарт нийцээгүй хэмээн шүүмжлэлтэй хандах нь бий.

Өөрөөр хэлбэл, судлаачдын бичсэнээс үзэхэд Монгол Улсын үндсэн хуулиар тодорхойлсон прокурорын чиг үүрэг нь ЭХХША-ны нэгэн үе шат болох хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавихад хамаарахаар байх боловч прокурорын талаарх тодорхойлолт, ойлголтуудыг авч үзвэл прокурор хүний эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангуулах зорилгод чиглэж байх тул ЗШША-нд хяналт тавьж байгаа нь прокурорын үндсэн чиг үүрэгт харшлаагүй байна.

ЗШША нь нөгөө талаасаа захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд хамаарах бөгөөд үүнийг заавал прокурор хянах шаардлагатай эсэх нь маргаантай хэвээр байна. ЗШШТХ-д зааснаар прокурорын оролцоог ЗШША-ны бүх үе шатанд хамааруулсан нь прокурорын байгууллагад хэт их ачаалал үүсгэх болжээ.

Улсын хэмжээнд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тавих хяналтын ажлыг дагнан хариуцсан 68 хяналтын болон ахлах прокурор ажиллаж байгаа бол нийслэлийн хэмжээнд зөрчлийн ажиллагаанд ердөө 4 прокурор ажилладаг тухай дээр дурдсан билээ. Прокурорын байгууллагын статистикт үндэслэн нэг прокурорт оногдох хэргийг тооцоолвол улиралд дунджаар 13,532³⁶ зөрчлийг хянадаг байна.

Олон улсын харьцуулалтаас дүгнэвэл, БНХАУ-ын хувьд ЗШША-нд прокурор оролцдоггүй, прокурорын үндсэн чиг үүрэг ЭХХША-нд хяналт тавихад чиглэгддэг бол ОХУ-ын хувьд манай улстай ижил байдлаар буюу прокурор нь ЗШША-нд хяналт тавьж оролцдог байна.

Прокурорын байгууллагын ачаалал, ЗШША-нд хяналт тавих шаардлагатай эсэх талаар нийгмийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

ЗШША нь нэг талаас захиргааны байгууллагаас захиргааны эрх зүйн салбарын хууль тогтоомж зөрчсөн зөрчилд шийтгэл оногдуулж буй нэгэн төрлийн захиргааны акт гаргах үйл ажиллагаа бөгөөд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар эрхээ хамгаалуулж, хууль ёс зөрчигдсөн эсэхийг хянуулах хууль зүйн боломж нь нээлттэй байгаа тул уг ажиллагаанд прокурор заавал оролцох шаардлагагүй юм. Иймд:

- Захиргааны хэм хэмжээний акттай шууд холбоогүй гардаг зөрчлүүдийг зааглах,
- Захиргааны хэм хэмжээний акттай шууд холбоогүй гардаг зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавьдаг байхаар зохицуулах,
- ЗШША явуулах эрх бүхий албан тушаалтныг прокурорын байгууллагын оролцоогүйгээр байхаар мэргэшүүлэх шаардлагатай байна.

36 Уг тооцооллыг гаргахдаа улсын хэмжээнд прокурор хяналт тавьсан зөрчлийн статистикийг прокурорын тоонд хувааж харьцуулав.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2017.
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017.
4. Прокурорын тухай хууль, 2017.

Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Б.Цэдэндамба, Ц.Болор-Эрдэнэ, Зөрчлийн эрх зүй, 2019.
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн, судалгааны тайлан, 2007.
3. Ц.Цогт, Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу Прокурорын хяналт, 20. <http://legaldata.mn/b/387>.
4. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, 2004.
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ, 2018.
6. С.Асланбек, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба прокурорын хяналт
7. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2021.
8. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008.
9. Д.Ганзориг, Захиргааны эрх зүйн тайлбар толь, 2003.
10. УПЕГ, ХЗҮТ, Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, 2003.
11. Б.Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан, Прокурорын хяналт, 2009.
12. Б.Чимид, БНМАУ-ын Захиргааны эрх, 1973.
13. М.Чинбат, Эрүүгийн Болон Зөрчлийн Хууль Тогтоомжийн Хэрэгжилт, Анхаарах Асуудал, 2021 <http://prokuror.mn/blog/ON/4408>.
14. УЕПГ-ын статистик мэдээлэл, 2020.
15. Монгол Улсын зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /Сургагч багш нарт зориулсан гарын авлага/, 2017.
16. Д.Баярмагнай, “Прокурорын байгууллага «ХААЛТТАЙ» байх ёстой. Олон нийт нээлттэй байлгах гэж шаахад ч хэрэггүй” ярилцлага <https://ikon.mn/n/154k>.

Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Lehman, Lee and Xu хуулийн фирмийн Англи хэл дээрх орчуулга.
2. БНХАУ-ын Ардын прокурорын органик хууль, 2018.
3. <https://www.chinalawtranslate.com/en/organic-law-of-the-peoples-procuratorate-of-the-prc-2018/>.
4. ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль, 2001.
5. ОХУ-ын Прокурорын тухай хууль.



УЕП газрын Зөрчлийн хэлтсийн хяналтын прокурор Алдархишигтэй хийсэн ярилцлагын хэсгээс: "Бид бол хууль хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага тиймээс Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар зөрчилд хяналт тавьж ажиллаж байгаа. Зарим тохиолдолд хуулийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй, ойлгомжгүй зүйл заалтууд байдаг. Тиймээс прокурорууд ажлаа бэрхшээлгүй хийхийн тулд шүүхийн харъяаллаас эхлүүлээд засаж залруулах шаардлагатай. Мөн түүнчлэн хуулийн зүйл заалт нь тов тодорхой, олон салаа ойлголтгүй байх, хэрэгжүүлэхэд саадгүй байх ёстой".



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ

2021.07.01-2021.08.01

Цагдаа	472638	96.5%
Мэргэжлийн хяналт	960	0.19%
Онцгой байдал	100	0.02%
Бусад	15822	3.2%

Нийт зөрчил	489520	↓ 11%
Нийслэлд	130479	↓ 9%
Орон нутагт	93981	↓ 13%

www.prokuror.mn

Зөрчлийн улмаас
учирсан хохирол

213.568 мян.төг ↓ 70%

Төлөгдсөн хохирол



252.687 мян.төг ↓ 61%

Шийтгүүлсэн хүн

164128 ↓ 1%

Хуулийн этгээд

191 ↓ 36%



Буурсан зөрчил ↓

Мөрийтэй тоглох	4	73%
Хулгайлах	20	66%
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	247	52%
Гамцгаас хамгаалах тухай хууль зөрчих	110	52%
Танхайрах	78	50%
Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	130	45%
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	152	43%
Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	6162	24%
Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	486	12%

Өссөн зөрчил ↑

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

147884 2%

Амралт зугаалга ихэссэнтэй холбоотойгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил өмнөх сараас 2 хувиар өсөж, улсын хэмжээнд гарч байгаа нийт зөрчлийн хэргийн 68.5%-ийг эзэлж байна.



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧИЙН ТООН МЭДЭЭ

2021.08.01-2021.09.01

Цагдаа	95382	98.8%	Нийт зөрчил	96458	↓ 57%
Мэргэжлийн хяналт	475	0.4%	Нийслэлд	56471	58.5%
Онцгой байдал	37	0.03%	Орон нутагт	39987	41.5%
Бусад	662	0.68%			

www.prokuror.mn

Зөрчлийн улмаас
учирсан хохирол

403.119 мян.төг ↑ 78%

Төлөгдсөн хохирол


322.639 мян.төг ↑ 80%

Шийтгүүлсэн хүн

70208 ↓ 57%

Хуулийн этгээд

285 ↑ 48%



0.21%	16-18 нас	27.9%	36-45 нас
13.3%	18-25 нас	13.6%	46-55 нас
38.8%	26-35 нас	5.6%	56-аас дээш нас

Буурсан зөрчил ↓

Хүний биед халдах	1262	4%
Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	304	37%
Мөрийтэй тоглох	1	75%
Гамцгаас хамгаалах тухай хууль зөрчих	116	9%
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	61741	58%
Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	127	4%
Бусад төрлийн зөрчил	4363	43%

Өссөн зөрчил ↑

Танхайрах	128	58%
Гэр бүлийн хучирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	326	31%
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	174	13%
Хүүхдийн эрхийг зөрчих	214	12%



Хулгайлах

33 ↑ 65%



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ

2021.09.01-2021.10.01

Цагдаа	62010	97.9%
Мэргэжлийн хяналт	528	0.8%
Онцгой байдал	31	0.04%
Бусад	733	1.26%

Нийт зөрчил	63302	↓ 35%
Нийслэлд	39062	61.7%
Орон нутагт	24240	38.3%

www.prokuror.mn

Зөрчлийн улмаас
учирсан хохирол

348.957 мян.төг ↓ 22%

Төлөгдсөн хохирол


299.657 мян.төг ↑ 85.8%

Шийтгүүлсэн хүн

44271 ↓ 37%

Хуулийн этгээд

261 ↓ 17%



Буурсан зөрчил ↓

Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих	99	21%
Хулгайлах	30	14%
Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	293	5%
Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	124	4%
Хүний биед халдах	1302	3%

Өссөн зөрчил ↑

Хүүхдийн эрхийг зөрчих	320	48%
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	458	30%
Танхайрах	159	16%
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	192	9%



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

36631 ↓ 41%



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧИЛҮЙН ТООН МЭДЭЭ

2021.10.01-2021.11.01

Цагдаа	215365	99.3%
Мэргэжлийн хяналт	496	0.2%
Онцгой байдал	27	0.01%
Бусад	787	0.4%

Нийт зөрчил	216858	↑ 8%
Нийслэлд	171660	79.1%
Орон нутагт	45198	20.8%

www.prokuror.mn

Зөрчлийн улмаас
учирсан хохирол

699.109 мян.төг ↑ 63%

Төлөгдсөн хохирол

531.537 мян.төг 76%

Шийтгүүлсэн хүн

213952 ↑ 8%

Хуулийн этгээд

263 ↓ 23%

163103 76.2%

50849 23.8%



0.12% 16-18 нас

13% 18-25 нас

37.8% 26-35 нас

27.6% 36-45 нас

14.3% 46-55 нас

6.6% 56-аас дээш нас

Өссөн зөрчил ↑

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	365	64%
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	713	50%
Хүүхдийн эрхийг зөрчих	443	33%
Танхайрах	227	31%
Мөрийтэй тоглоом тоглох	5	25%
Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	189	21%
Хүний биед халдах	1699	14%
Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	506	13%

Буурсан зөрчил ↓

Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих	94	8%
---------------------------------------	----	----



Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

194095 ↑ 7%



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ

2021.11.01-2021.12.01

Цагдаа	231608	99.1%
Мэргэжлийн хяналт	480	0.3%
Онцгой байдал	50	0.02%
Бусад	1362	0.6%

Нийт зөрчил	233499	↑ 7.6%
Нийслэлд	184008	78.8%
Орон нутаг	494925	21.2%

www.prokuror.mn

Зөрчлийн улмаас
учирсан хохирол

12.976.474 мян.төг ↑ 15.8 дахин

Төлөгдсөн хохирол


737.919 мян.төг 5.6%

Шийтгүүлсэн хүн

231231 ↑ 8%

Хуулийн этгээд

239 ↓ 13%



0.4% 16-18 нас

27.7% 36-45 нас

13.1% 18-25 нас

14% 46-55 нас

38.2% 26-35 нас

6.2% 56-аас дээш нас

Өссөн зөрчил ↑

Танхайрах	274	79%
Мөрийтэй тоглоом тоглох	7	40%
Хулгайлах	48	37%
Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	565	10%
Хүүхдийн эрхийг зөрчих	455	3%
Гамцгаас хамгаалах тухай хууль зөрчих	76	2.2 дахин

Хүүхдийн бие махбодод халдсан, үл хайхарсан, хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 300.000 төгрөгөөр торгоно.



Буурсан зөрчил ↓

Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	165	14%
Хүний биед халдах	1641	5%
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	357	3%
Гэр бүлийн хучирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	700	2%



Замын хөдөлгөөний
аюулгүй байдлын
тухай хууль зөрчих

13468 ↑ 7%

ТЭМДЭГЛЭЛ